


МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ҮГИЙГ МЭДЭГДЭХҮҮН МЭДЭХҮҮН БА
ХЭЛЭГДЭХҮҮН ХЭЛЭХҮҮНИЙ ТАЛААС ҮЗЭХ НЬ

М. Базаррагчаа*
Б. Мөнгөнцэцэг*

1. Хичээх -шамдах, чармайх, идэвх оролдлого гаргах, санаа тавих
2. Мэрийх -хамаг хүчээ дайчлан ажиллах, сурах
3. Чармайх -чин үнэнээр хүчлэн зүтгэх, мэрийх, шамдах¹
4. Шамдах -1.ажил үйлд хичээх, мэрийх 2.шаардах, шахах, яарах
5. Шавдах -хүний байн байн шаардах, шалах, яарах, түргэлэх
6. Улайх -мэрийх, чармайх, махрах, улайрах (хэт мэрийх)
7. Махрах -ажил хэргийг бүтээх гэж чармайх, зүтгэх
8. Зүтгэх -хүн аливаа үйл явдалд хичээл мэрийлт гаргах, зүтгэх хичээх
9. Айлчлах -аливаа ажил үйлд хүч чадал, оюун ухаанаа шавхан гаргах
10. Оролдох -ямар нэг зүйлийг хийж бүтээхээр чармайх, мэрийх"

гэсэн ойролцоо үүр үгс нь заах, өгөх-орших ба үйлдэхийн тийн ялгалт жинхэнэ нэрийг "хувиа хичээх, ажилд чадлаараа хичээх" гэх мэтээр өгүүлбэрийн үйлдэгчийн зорилго (цель)-ын үүднээс бүрэн гүйцэтгэх үйлийг (количество) заасан бол "шамдах-шавдах" гэсэн төсөөт ойролцоо үг нь цагийн утга голлосон байна. Тэгвэл "улайх, махрах, зүтгэх" нь биеийн хүч давамгайлан уг үйлийг гүйцэтгэх гэж зорих утгатай ажээ. Иймээс дээрх ойролцоо үгсийг хэлэгдэхүүний талаас



* ШУ-ны доктор, профессор

* "Гурван Эрдэнэ" БДС-ийн багш, магистр

¹ Баярсайхан Б. (2009) *Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг*. Эрхэлсэн Б.Баярсайхан, хянан тохиолдуулсан А.Янжиндолгор. Улаанбаатар.

гэж утгаар нь харьцуулж болно. Үүнд “а, в” нь тусах, “б, г, д” нь эс тусах үйл үгээр ялгарах ба эдгээр өгөх-оршихын тийн ялгалт жинхэнэ нэрийг захирч чадна. Иймээс

а) эрдэмд/эрдмийг хичээ-

чармай-

мэрий-

эрдэмд/биеэ дайчил-

эрдэмд/хүчээ шавх-

б) эрдэмд махар-

эрдэмд зүтгэ-

эрдэмд шамд-

эрдэмд шавд-

эрдэмд улай-

эрдэмд улайр-

в) “эрдмийг/ эрдмээр оролд-” гэж ялгарч болно.

Энэ зохицолт бүтэц нь нийлмэл өгүүлбэрт давтагдана. Тодотгогч цагт нэр нь тодотгуулагч жинхэнэ нэрээ гээвэл нэрийн тийн ялгалаар хэлбэржсэн нийлмэл өгүүлбэр бүтээнэ. Жишээ нь:

Долингор, миний гологдсон хүүхэн гэ-ж

хайрла-ж

аятай өсгөх-ийг

ХИЧЭЭ-НЭ. (Ц.Дамдинсүрэн)

Хөдлөн явах, босох суух, хэлэх ярих болгондоо биеэ хичээнэ. Би чадна гэсэндээ эрхбиш хичээх байгаа, цаадах чинь.

Энэхүү “хичээ-” хэмээх үйл үгийг “чармай-, мэрий-” гэсэн үйл үгээр солих боломжтой ба “өсгөх гэж, өсгөхөөр, хэлэх ярих гэж, хэлж ярихаар, чадна гэж зүтгэнэ/ махарна/ улайрна/ шамдана” гэж зорих утга бүхий өгүүлбэрийг захирч болно. Үүнээс үзвэл дээрх ойролцоо үгийн үүрээс “хичээ-, чармай-, мэрий-” гэсэн дүрслэх үйл үгсийг уул эхийн доторх өгүүлбэрт өөр хооронд нь солиход утга өчүүхэн ч үл гажих тул оновчтой ойролцоо үг гэж болно. Нөгөө талаас, мэрий- нь “muruᠢ-, mirāuᠢ-” –аас, хичээ- нь qajāuᠢ-, kǰyǰy-n (гүдгэр)-аас, “чармай-, чарай-” нь “čirmāuᠢ-, čirāuᠢ-” зэрэг дүрслэх үг, тухайлбал, “уг зүйлд хүч анхаарлаа тавивал биеэ хураан эвхэх юм уу, эсвэл хүчээ дайчлан булчин шөрөмсөө чангалах” зэрэг биеийн хөдөлгөөнөөс үүдэлтэй учраас эдгээрийн утга ойролцоо байх нь дамжиггүй юм.

Ер нь ойролцоо үгийг тодорхойлох хоёр үндсэн хандлага байдгийг эрдэмтэд дурдсан байдаг. Үүнд, зарим нь утга ойр боловч ялгаатай үгс, зарим нь адил утгатай үгс гэдэг. Үүний эхнийх нь ойролцоо үүр үгсийг нэгэн ухагдахуунд зангиддаг бол сүүлчийнх нь “нэг үг нэг л ухагдахуунтай” хэмээх зарчмыг баримталж, утга нь адил (ижил) (омосемия омосемантика) байна гэдэг. Хоёрдогч үзэлтнүүд “утга ойр байна” гэдэг нь тодорхой биш, харин “утга нь адил байна” гэдэг нь бодитой юм гэнэ. Эхний үзэлтнүүд туйлын ойролцоо үг гэж байж болохгүй. Учир нь, ойролцоо үгс нь ямагт утгаараа ялгарахыг эрмэлзэж байдаг гэнэ. Тэгвэл хоёрдогч үзэлтнүүд ойролцоо үг байхын үндэс нь адилсах үзэгдэл юм. Иймд туйлын адил байх (туйлын ойролцоо үг), үгийн утга ижилсэн саармагших, харилцан солилцож болох зэрэг шинжтэй гэдэг байна. Ийнхүү “ойр ба адил” гэх нь үгс нь утгаараа адил байхын зэрэгцээ ялгарч, ялгарахын зэрэгцээ адил байх гэсэн нэг юмын хоёр тал ажээ. Энэ хоёр үзлийн анхдагч нь ойролцоо үгсийг хийсвэр ухагдахуунд багтааж, ялгарах буюу салах талыг, хоёрдогч нь ойролцоо үгсийг юманд багтааж, саармагших буюу нийлэх талыг тус тус барьсан хэрэг ажээ. Жишээлбэл, “хичээ-, мэрий-, чармай-” гэсэн ойролцоо үгсийн утга нь адил тул солих боломжтой байхын дээр энэ гурав нь туйлын ойролцоо үг баймаар. Харин дээрх “а, б, в” гэсэн бүлэг үгс нь “тухайн үйлийг гүйцэтгэж дуусгах” гэсэн нэг ухагдахуун

(утга)-тай боловч өөр хоорондоо ялгаатай ойролцоо үгс юм. Жич, “шамдах-шавдах” нь төлөөний үг, “улайх-улайрах” нь үгийн хувилбар байж болох биз. Ойролцоо үгийн талаарх дээрх хоёр саналыг тодруулахын тул загварчилбал,

№	I. ойролцоо үгс (синонимия)	II. адил үгс (омосемия)
1.	Утга ойролцоо боловч ялгаатай үгс	Утга адил үгс
2.	Нэг ухагдахуун нь олон үгсийг багтаана.	Нэг ухагдахуун нь нэг үгтэй тэнцэнэ.
3.	Туйлын адил юм байхгүй тул туйлын ойролцоо үг гэж байшгүй.	Ойролцоо утга гэдэг тодорхойгүй, харин утга адил гэвэл зүйтэй.
4.	Ойролцоо үгийн утгын ялгараанд түшиглэсэн эгнээ нь хөдөлгөөнтэй, задгай байдаг.	Утга адил байдаг учраас туйлын ойролцоо үг байхаас гадна нэгийг нөгөөгөөр сольж болно. Утга зохицохдоо саармагшина.
5.	Ойролцоо үгийн утгын ялгааг тогтоохыг эрмэлздэг. Энэ нь уул ухагдахууны олон талыг тухайлбал, нарийвчилсан ба өргөтгөсөн, хязгаарласан ба эсрэгцсэн зэрэг олон утгыг илтгэдэг.	Ойролцоо үгийн утгын адил талыг тогтоохыг эрмэлздэг. Энэ нь найруулгын элдэв ялгаа, саармагших ёс, ярианы чөлөөт байдал, үгийг үгээр тайлбарлах зэргээс шалтгаална.
6.	Ойролцоо үгийн утга ойр шинж нь хэлний түвшид, ялангуяа үгийн утгын нарийн бүтэц, тогтворжилтын зэрэгцээ хувьсамтгай байдлаас үүдэлтэй бодит ухамсрын задлаг төсөөллөөс шалтгаалдаг.	Ойролцоо үгийн утга адил шинж нь бусад тэмдгийн тогтолцоонд ажиглагддаг шиг хэлний тухай томьёолбор (код)-оос үүдэлтэй нийлэг төсөөллөөс эхтэй юм.
7.	Ойролцоо үгийн утгын тогтвортой талыг илрүүлдэг.	Ойролцоо үгийн утгын амьд хөдөлгөөн илрүүлдэг.

гэж харьцуулж болно. Энэ тухай А.А.Брагина “Ойролцоо үгийг утгын адилсал” гэж нэг талаас үздэг байхад нөгөө талаас, утгын ялгараа гэж үзэх нь хэлний мөн чанар, түүний гүйцэтгэх үүргийн шинж торхийн дотоод эсрэгцэлтэй холбоотой юм”² хэмээн тайлбарласан нь үнэнд нийцнэ. Энэ тухай бид ойролцоо үг гэнэ” (Рецензия на “словарь синонимов”) гэж тодорхойлсон байна. М.И.Фомина энэхүү хоёр талыг барьсан тодорхойлолт хийсэн байна. Үүнд тэрээр “Нэг нь нөгөөгөөсөө утгаараа ялгарч байгаа, эсвэл найруулгын өнгөөрөө ялгарч байгаа, нэг бол энэ хоёр шинжээрээ ялгарч байгаа, нэг ухагдахууныг янз бүрээр нэрлэсэн, үгийн утгаараа адил буюу ойролцоо үгийг ойролцоо үг гэнэ”³ гэж өгүүлсэн нь дээрх адил ба ойролцоо гэж ялгахыг мэрийсэнгүй. Гэтэл Н.М.Шанский утгын хувьд ч, найруулгын хувьд ч туйлын адил үгс байдаггүй. Юу гэвэл, нэг юм болоод түүний янз бүрийн шинжийг нэрлэдэг. Бодит байдлын нэг юмыг тэмдэглэж буй үгсийг ойролцоо үгс гэнэ⁴ гэж бодит ойролцоо үгийн тухай мэдэгдэхүүний талаас өгүүлсэн байна. Д.Н.Шмелев “Тодорхой нөхцөлд ялгаатай


² Брагина А.А. (1986) *Синонимы в литературном языке*. стр. 122, Москва.

³ Фомина М.И. (1983) *Современный русский язык. Лексикология*, стр. 78, Москва.

⁴ Шанский М.Н. (1972) *Лексикология современного русского языка*. стр. 52, Москва.

байсан махбодууд нь заавал саармагшиж адил болдог үгсийг ойролцоо үг гэнэ”⁵ гэж хэлэхүүний талаас тодорхойлжээ. Тэгвэл А.А.Уфимцева “Үг судлалын нэгжүүд нь бүхэл утгаараа ч, хэсэг утгаараа ч адил болж буй биш, харин ерөнхий утгаараа холболдсон үгсийг ойролцоо үг гэнэ”⁶ гэж хэлэгдэхүүний талаас тодорхойлсон байна. Мэдэхүүний талаас ойролцоо үгийг хэрхэн тодорхойлсныг үзье. А.П.Евгеньева “Утгаараа ойролцоо буюу адил тэнцүү үгсийг ойролцоо үг гэх ба энэ нь үгтэй зохицох, сэтгэлийн өнгө аясыг илтгэх, аль найруулгад хамаарах, яруу тодорхой илтгэх, утгыг нарийн ялгах зэргээр өөр хоорондоо ялгаатай байхуйц, үндэстний утга зохиолын хэлний үгийн сан-утга зүйн тогтолцоонд онцгой байр эзлэхүйц үгс юм”⁷ гэсэн нь ойролцоо үгийн хэрэглээний онцлогийг дурдсан байна. Тэрээр, толь бичигт нэг ухагдахууныг тэмдэглэсэн өнөөгийн утга зохиолын хэлний үгсийг оруулахдаа а) өгүүлэгч бичигчийн аль аль нь уул ухагдахууны нэг шинжийг ялгаж нарийвчлан ойлгож чадах (мэхэл-, залил-, хуур-, овло-, молигод-) б) шинж чанарын илрэх хир хэмжээ зэргийг мэдэх (эмнэг, хангал, онгон, атар, танхи, ардаг, онгог тансаг); в) үйлийн эрчмийг мэдэх (элэглэ-, доогло-, шоол-, дуурай-, даажигна-, тохуурх-, шогчил-, гоочил-, өөчил-); г) уул юманд өгүүлэгч хэрхэн хандах үнэлэхийг ялгах (тэнэг, мунаг, мулгуу, мунхруу, мангар, мангуу, дүйнгэ, солиг) хэрэгтэй гэж үзсэн нь мэдэхүүний үндсэн ойлгохуун болно.

Хэлэгдэхүүний талаас, ойролцоо нэр ба үйл, тэмдэг ба орон цагийн үгс нь дор дороо утгын хол ойрын харьцаатай байхыг тохицол гэж болно. “Залхуу, хойрго, хашин, алжуу, цаарга, хошуун, удаан, дөжир, назгай, цалгар” гэх мэт ойролцоо үүр үгсээс “залхуу хойрго” нь хүний тухайд “хашин, цаарга” нь малын тухайд голдуу ялган хэлэлцэх ба “алжуу” нь “салан задгай, цалгар назгай” хэмээх үгтэй утгаараа ойр тусацтай аж. Харин “хошуун, удаан, дөжир” зэрэг нь “залхуу хойрго”-оос нэлээд хол буюу захын байрлалтай юм. “Оёг, мохдог” гэвэл бүр ч холдох байдалтай бөгөөд “оёг согог”, “мохоо мөлгор” гэсэн үгсийн салаа утгаас үүсэлтэй аж. “Залхуу хойрго” гэсэн хоёр үгээс “залхуу” нь түгээмэл хэрэглэгдэх тул гол үг (доминант) болно. Ю.Д.Апресян ойролцоо үүр үгсийн гол үглэвэр (лексема) нь хамгийн ерөнхий утгатай байх, олонтоо хэрэглэх, олон үгтэй зохицох, дунд найруулгад багтах, хүнд ойр (давын өмнө санаанд буудаг) байх зэрэг шинжийг дурдсан байна.⁸ Дээрх үгсийг Р.А.Будаговын загвараар⁹



⁵ Шмелев Д.Н. (1977) *Современный русский язык. Лексика*, стр. 196, Москва.

⁶ Уфимцева А.А. (1968) *Слово в лексико-семантической системы языка*, стр. 185, Москва.

⁷ Евгеньева А.П. (1970) *Синонимы русского языка// Словарь синонимов русского языка*, Том I, стр. 11, Ленинград.

⁸ Апресян Ю.Д. (1999, 2000) *Новый объяснительный словарь синонимов русского языка*. Первый выпуск, стр. VII, Второй выпуск, стр. IX, Москва.

⁹ Будагов Р.А. (1965) *Введение в науку о языке*, стр. 58, Москва.

гэж эгнүүлж болох ба “алхаг, залхаг, залхуу” гэсэн үгс нь ойролцоо биш, төсөөт үгс болно. Иймээс “залхуу хойрго” нь “хашин цаарга”-тай ижилсэн ондоошиж, өөр хоорондоо тохицсон бүтэц бий болгож байна.

Толь бичигт а. Залхуу -1. Ажил хөдөлмөрт дургүйлхэн хойш сууж, хойргоших зантай (“залхуу назгай, залхуу хойрго, алжуу залхуу” гэсэн ойролцоо хоршоо үгийг хавсаргажээ). 2. Малын хол явах дургүй, хашин, залхуу амьтан (нозоорч хөшсөн дөжир амьтан). 3. Бие нозоорч, амрах дур хүрсэн үе, залхуу хүрэх

б. Хойрго -залхуу, удаан, хойш суумтгай (“алхаг хойрго, залхуу хойрго, хойрго цаарга, удаан хойрго, хашин хойрго, цалгар хойрго” гэх мэт хоршоо үгийг иш татжээ)

в. Хашин -1. Морь малын оёг удаан, 2. Залхуу хойрго (хашин хойрго, хашин мохдог)

г. Цаарга -1. Ажил хөдөлмөрт хашин хойрго, татгалзангуй (хойрго цаарга), 2. Үг хүлээж авах дургүй, маргамтгай¹⁰ гэж тайлбарласнаас үзвэл, энэ дөрвөн үгийн олонх утганцар таарч, цөөнх утганцар нь ялгарч байна. Харин “хойрго цаарга” нь төсөөрхүү үг (параномозия) болж болох юм. Учир нь “х-ц, ой-аа” авиалбар солигдож, “Хийх ажилд ч хойрго

Хэлэх үгэнд ч цаарга” гэж утга ба хэлбэрээр төсөөрхөн, найруулах ур маяг (стилистическая фигура)-ийг бүтээж болно. Дээрх гол үгсээс

а) залх-	залх - уу залх - лт залх - л залх - лага	} Syn.	залх - уу - р _v - л залх - уу - д _v - залх - уу - чид _v -	} para.
б)	хойрго		хойрго - д- хойрго - л- хойрго - ш-	} Syn.
в)	хашин		хашин - на- хашин - д	} Syn.
г)	цаарга		цаарга - д- цаарга - ш- цаарга - л- цаарга - л - аа _n - ч цаарга - л - д _n	} Syn. } para.

гэх мэтээр ойролцоо ба төсөөт үгс үүснэ. Олонхи судлаачид утга ба найруулгын ойролцоо үг хэмээн ангилсаар ирсэн нь зогсонги ба хөдлөнг тал болох ба О.Н. Емельянова “утгын ойролцоо үгс (идеографические или понятийные синонимы);

¹⁰Баярсайхан Б. (2009) Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг. Эрхэлсэн Б.Баярсайхан, хянан тохиолдуулсан А.Янжиндолгор. Улаанбаатар.

найруулгын ойролцоо үг (стилистические синонимы) гэж ялган, сүүлчийнхийг найруулгын өнгө аясаар ялгарч адил утгатай үгс хэмээжээ. Энэ нь а) найруулга хоорондын ба б) яруу болоод сэтгэл хөдлөлийн өнгө аяс бүхий нэг найруулгын ойролцоо нэгж (зэрэг сөрөг өнгө аяс) гэж ангилагдахаас гадна утга-найруулгын ойролцоо нэгж (бродить-дундаж найруулга) – шататься (ажилгүй гунхах), хар ярианы найруулга, блуждать (замаасаа төөрөх) (номын хэлний найруулга)¹¹ хэмээн үзжээ. Үүний утгын ойролцоо нэгж гэгч нь мэдэгдэхүүн буюу хэлэгдэхүүнийх, найруулгын ойролцоо нэгж нь мэдэхүүн буюу хэлэхүүнийх болох ажээ.

Хэлэгдэхүүний ойролцоо нэгж нь утгаараа бүрэн ба бүрэн бус тохирдог бол хэлэхүүний талаас, өгүүлбэр ба эхийн дотор солих боломжтой байдаг тул тухайн юмс үзэгдлийн аль нэг шинж, онцлог талыг тодруулдаг. Жишээ нь:

Тэнгэрээс ангид орон зай хаа нэгтээ байгаа гэдэгт би хувьдаа хэзээ ч итгэдэггүй. Тэнгэр ямагт газрыг өмсөж оридог агуу их хүчин учраас тэр шүү дээ (П.Хурай) гэхэд “ангид – өөр-өмнөө-, ондоо-бусад-гадна-тусгай-жич; итгэдэг-найддаг-үнэмшидэг; орших-байх; хэзээ ч-ямагт, байнга, үргэлж, үүрд, эгнэгт; орон зай-чөлөө завсар-чөлөө зай; өмсөх-хувцаслах-зүүх; агуу-үлэмж-тол-их-аварга-онцгой; хүчин-чадал-ид хав-тамир-тэнхээ-эрч-бяр” гэх мэтээр утгын хол ойрын холбоо бүхий үгсийг жагсааж болно. Жишээ нь, “ангид” хэмээх үгнээ утгаараа хамгийн ойр үгс нь “а”-гийн I-VI-т буй үгс юм.

а) I. өөр (*үгер-е ~ үбер-е*)

II. ондоо

III. ангид (*анги, ангидаа*), салангид ~ саланги

IV. алдаан (*тусгай өөр*)

V. бусад (*бус, биш*)

VI. өмнөө

б) VII. тусгай (*тус, тусдаа, тусгаар, тусгайт, тусгайдаа*)

VIII. онцгой

в) IX. жич (*жичид, жичдээ*)

X. гадна

г) XI. нөгөө

XII. харь

Эдгээр бүлэг үгсийн “а” нь “ялгаран зэрэгцсэн”, “б” нь “ялгаран онцгойрсон”, “в” нь “ялган нэмсэн”, “г” нь “ялган ижилсүүлсэн” гэсэн утгатай бөгөөд бүхэлдээ хоёр юмыг харьцуулсан утгатай ажээ. Энэхүү дөрвөн бүлэг, арван хоёр үгээс зохиогч “ангид” хэмээх үгийг сонгосны учир юу вэ? гэвэл “тэнгэр газар” хэмээх үлэмж орны тухай өгүүлж буй тул дээд үнэлэмж бүхий найруулгын “орш-, хүчин, агуу” хэмээх үгс өгүүлэгчийн санаанд буух нь зүй биз ээ. Өөрөөр хэлбэл, “ангид” хэмээх үг нь бусад ойролцоо үгээ бодвол дээд найруулгын үнэлэмжтэй тул дээрх үгстэй найруулгаараа зохицож байгаа юм. Гэвч ишилсэн өгүүлбэрт шалтгааны утгат нийлмэл өгүүлбэрийн байрыг сольж, тайлбарласан өгүүлбэр¹² болгосноос гадна, “би” гэж өөрийгөө оруулан,

¹¹ Емельянова О.Н. (2003) Синонимы// *Стилистический энциклопедический словарь русского языка*, стр. 381, Москва.

¹² Бертагаев Т.А., Цыдендамбаев Ц.Б. (1962) *Грамматика бурятского языка. Синтаксис*, стр. 267-270, Москва. Пюрбеев Г.Ц. (1979) *Типы сложных предложений в монгольских языках*, стр. 95-98, Москва.

“тэр” гэсэн төлөөний үгээр хэлэх санаагаа онцлохын зэрэгцээ өмнөх өгүүлбэртэй холбосон, “шүү, дээ” хэмээх баймжит сул бүтээврийг хэрэглэснийг үзвэл, дээд найруулгыг ярианы хэлний найруулгатай хосолсон учраас сонин нийтлэлийн найруулгын өнгө аястай болгожээ. Ингэж хэлэхүүний талаас, ойролцоо үгийг солих боломжоос сонгох боломж бий болдог нь уг бичих ярих зүйлийн найруулгын төрөл жанртай холбогдоно. Нөгөө талаас, өгүүлэгчийн үзэл бодол, үнэлэмж баймжийн утга нь мэдэхүүнд хамаарна. Ш.Балли ойролцоо үүр үгийн тухай өгүүлэхдээ “Бидний зорилго бол сонгосон үгийн утга нь уул ойролцоо үгсийн утгад хадгалаастай байхад оршино ...Хэрвээ тэгж хэлэхэд хүрвэл хэлэнд төрөл зүйлийн үгс байдаг. Хэл ярианы баримтаас үзвэл, төрөл зүйлийн үгсийн ялгаа нь ойролцоо нэгжийг судлах үндэс болдог. Хэрэв ойролцоо үүр үгсийн утгыг ерөнхийлөхүйц, үндсэн санааг илтгэх, тэр тусмаа илүү бодит байдлыг илтгэсэн, бодол шаардсан, сэтгэл хөдөлгөх нэг гол үгсийг дагаж үүрлэсэн үг хэллэгийг бүтээхгүй юм бол аливаа ойролцоо үгийн нарийн ширийн утгыг бүх талаас тайлбарлаж чадахгүй болно”¹³ гэжээ.

Ойролцоо үүр үгсийн доторх гол буюу тулгуур үг нь хэлэгдэхүүн ба хэлэхүүний хувьд ялгаатай болно. Жишээлбэл, дээр ишилсэн өгүүлбэрийн хувьд, “ангид” хэмээх үг нь хэлэхүүний хувьд гол буюу тулгуур үг болж, хэлэгдэхүүний талаас, “өөр” гэсэн үг нь гол буюу тулгуур үг болно. О.С.Ахманова “Тиймэрхүү гол буюу тулгуур үгийг хайх нь зүй ёсоор үгийн үндсэн сан хөмрөгийн тухай судалгаатай холбогдох болно”¹⁴ гэж үзсэн нь аль ч найруулгад тохирох үгсийг чөлөөтэй олох бүрэн боломжтойг онцолсон ажээ. Ш.Балли хэлний найруулгын эх булаг нь сэтгэл хөдлөх ба харилцаанд хэрэглэх өнгө аяс, мөн үг нөхцөлийн утга салаалах хэрэглүүр гурав юм гэжээ. Энэ нь ойролцоо нэгж бий болох эх үүсвэр болох ба Ш.Баллигийн ярианы буюу хувь найруулга гэгч нь хувь хүний далд ертөнц буюу үзэл бодол, зан төрхийн ялгаа байдаг гэж зарим судлаачид үздэг байна. Үүнийг О.С.Ахманова зөвшөөрдөггүй байна.¹⁵ “Зохиолчид өөрийн найруулгаараа сэтгэл санааныхаа түүхийг бидэнд үлдээдэг. Энэ нь найруулга нь хүний дотоод ертөнцөд нэвтрэх арга мөн” гэх мэтээр үзэх нь найруулах өнгө аяс, найруулах арга хэрэглүүр, ялангуяа, ойролцоо нэгжийг хэрхэн сонгохоос шалтгаалах аж.

“Дагах” -(юмны хойноос бараадан ойрхон явах) хэмээх үг нь

1. Аялдах, дагаж дарвих (даган баясах)
2. Дуурайн хамтрах (дагаж дуулах)
3. Дагаар орох (дайсан этгээд дагах)
4. Мөрдөх журамлах (заншил дагах)
5. мөшгөх нэхэх (дагаж нэхэх, улаа нэхэх)

6. адуулах, маллах (мал дагах)¹⁶ гэсэн салаа утгын 4-5-р утга нь “нэхэх, мөрдөх (мөшгөх) хөөх” гэсэн үгстэй утга ойролцоо болно. Гэтэл “нэхэх” гэдэг нь “хувцас хунарыг сүлжиж хийх” гэсэн утгатай боловч түүнээс үүссэн “хойноос нь хөөх” гэсэн салаа утга нь “дагах”-тай ойролцоо утгатай ажээ. (Жич, уг тольд “цамц нэхэх, хойноос нь нэхэх, өр нэхэх” (гүйцэх, гүйцээх) гэснийг ижил үг (омонимия) гэж үзсэн байна. Энэ

¹³ Балли Ш. (1961(1951) *Французская стилистика*. стр. 131, Москва.

¹⁴ Ахманова О.С. (1957) *Очерки по общей и русской лексикологии*. стр. 235, Москва.

¹⁵ Ахманова О.С. (1957) *Очерки по общей и русской лексикологии*. стр. 239, Москва.

¹⁶ Баярсайхан Б. (2009) *Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг*. Эрхэлсэн Б.Баярсайхан, хянан тохиолдуулсан А.Янжиндолгор. 189 х., Улаанбаатар.

нь салаа утгаас ижил үгс үүсдэгтэй холбогдоно). “хөөх” (хойноос нь мөшгөн туух, хөөх) хэмээх үг нь

1. хүн амьтныг байгаа газраас нь зайлуулах (гэрээс нь хөөх)
 2. юманд шунах (яргуй хөөх)
 3. ажил төрлөө гүйцээх (замаа хөөх)
 4. огцруулах (ажлаас нь хөөх)
 5. сарниулах (бодлы нь хөөх)
 6. ороо нь орж, эм амьтныг хөөх (бух үнээ хөөх)
 7. хэрэглэх (улаа хөөх) гэсэн салаа утгатайгаас “дагах” гэдэг үгийн 5-рх утгатай 2, 3,
- 6, 7-рх салаа утга нь ойролцоо байна. Харин “хойноос нь нэхэх, улаа нэхэх” гэсэн утгатай “хөөх” гэдэг үгийн 6, 7-р утга ойролцоо болж байна. “мөрдөх” (мөрөөр даган явах)-ийн, “ёс журмыг мөрдөх” гэсэн утга нь “мөрөөр нь хөөх, дагах, нэхэх” гэсэн утгатай ойролцоо байна. Иймээс “дагах-нэхэх-хөөх-мөрдөх (мөшгөх)-сундлах (нэхэн хөөж сүрдүүлэх)” гэсэн үгс нь ойролцоо үгсийн үүр эгнээг бий болгожээ. Иймээс эрдэмтэд үгийн салаа утгын хувилбарыг ижил үг хязгаарладаг бол авиалбар бүтээврийн хувилбарыг ойролцоо үг хязгаарладаг. Энэ санааг Ю.С.Степанов нэлээд тодорхой болгож, “үгийн хийсвэр утгын хувирлыг нэр томьёо хязгаарладаг бол үгийн бодит утгын хувирлыг зүйрлэл хязгаарладаг”¹⁷ хэмээжээ. Тэрээр, “үгийн ойрын салаа утга нь яв явсаар үгийн холын салаа утга болох нэр томьёо болдог. Энэхүү холдсон утга нь анхдагч утгатайгаа эргээд харьцахдаа ижил үг болно” гэж үзсэн байна. Жишээ нь, орос хэлний “луна” хэмээх үг нь “шөнийн гэрэлтүүлэгч, хугацааны нэгж” гэсэн салаа утгатай бол “дэлхийн дагуул, тэнгэрийн эрхэс” гэсэн нэр томьёо болно. Тухайн үгийн авиа болон ухагдахуун нь хэвээрээ байх атлаа нэрлэгдэхүүн буюу юм нь өөр юм буюу нэрлэгдэхүүнээр солигддог. Энэ нь зүйрлэл (метафора) болох ба нэрлэгдэхүүний хувилбарыг хязгаарладаг аж. Жишээ нь, орос хэлний “память, поколение” хэмээх үг нь “память машины, новое поколение машин” гэж утгыг зүйрлэн хэлснээс цаад юмс нь өөр юмсаар солигддог байна.

Ш.Лувсанвандан “Бид нар орос хэл суралцаж байна” гэдгийг “Бид нар орос хэл үзэж байна” гэж хэлж болох бөгөөд үүний утга санаа төдийлөн өөрчлөгдөхгүй байгаа боловч “суралцаж, үзэж” гэдэг хоёр үг гол утгаараа харилцан өөр болно. Энд зөвхөн “үзэж” гэдэг үгийн салбар утга нь хэрэглэх байдлаараа “суралцаж” гэх үгийн гол утгатай тохирсон байна”¹⁸ хэмээн үзсэн байна. Үүнд, салаа утга нь хэлбэр буюу хэлэгдэхүүнээс мэдэгдэхүүнд шилжүүлэн судалдаг утга судлал (семасиология)¹⁹-ын зүйл болдог бол ойролцоо үг нь мэдэгдэхүүн буюу нэр судлал (ономасиология)²⁰-аас хэлэгдэхүүнд шилжүүлэн судлах нэг зүйл болдог.²¹


¹⁷ Степанов Ю.С. (1975) *Основы общего языкознания*. стр. 15, 18, Москва.

¹⁸ Лувсанвандан Ш. (1962) *Үгсийн сангийн зүй*. 505 х., Бээжин.


¹⁹ Утга судлал нь нэг үгийн утгыг судалдаг бол

²⁰ нэр судлал нь юмс ба ухагдахууныг янз бүрээр тэмдэглэхийг судалдаг. Нэр судлал нь ойролцоо нэрийг онцгойлон судална.

²¹ Гречко В.А. (2003) *Теория языкознания*. стр. 210, Москва.



Монгол хэлнээ сарны гэрэл-сарын дотор (хугацаа) гэж ерийн үг нэр томьёо хоёрыг "-н"-тэй, "-н"-гүйгээр ялгадаг. "Алив юмыг доошлуулан хүчлэх юм"-ыг "даралт" гэх ба үүний шууд утга нь "хаалганы даралт" гэх үгэнд байна. Гэтэл "агаарын даралт, цусны даралт, хэвлэлийн даралт хуудас, даралтын тогоо" зэрэг нь тухай тухайн шинжлэх ухааны нэр томьёо болж, анхны утгаас нэлээд холдсон тул хийсвэр (сигнификат) утгын хувилбар болно. Тэгвэл "даралт хавчилт" гэвэл ойрын салаа утга, "даралт (чагтага) томох" гэвэл нэрлэгдэхүүн нь өөр юмаар солигдсон салаа утга болжээ. (хаалганы даралт→чагтага (даралт)→авын даралт (амьтныг хоморгон шахах). Хэрэв тухайн үгийн авиа нь өөрчлөгдөж эхэлбэл, үгийн авианы хувилбар, улмаар төсөөт ба ойролцоо үг болоход хүрдэг. Үгийн салаа утга нь хэлний мэдэхүүн, хэлэхүүний хөдлөнгө шинжийг агуулах боловч мэдэгдэхүүн хэлэгдэхүүн хоёртой зүй ёсоор холбогдох болно. Үүнд:



Мэдэхүүн хэлэхүүн хоёр нь хувь хүний болоод тухайн үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илтгэсэн утгын хувилбар буюу салаа утга байж болно. Энэ тухай Ш. Балли "герман хэлний нарийн нягт чанар (точность) нь франц хэлний энгийн тодорхой чанартай эсрэгцэнэ. Энэ нь хэлний хураах ба дэлгэрэх, ашиг ба сунах, ижиллэх (конденсация) ба ондооших (диссоциация) ёсноос шалтгаална" гэж өгүүлсэн байдаг.

Хэлэхүүний хувьд, ойролцоо үгсийн ялгарах шинж нь уул эхийн дотор шилж сонгох боломжийг олгож, ойролцоо үүр үгсийг бий болгоно. Энэхүү ялгарах шинж нь үгийн утгын утганцар (сема)-аар нөгөө үгийн утганцартай зохицно. Ийнхүү

хэлэгдэхүүний бүрэн ба бүрэн бус тохицол нь мөн бүрэн ба бүрэн бус зохицол болон хувирна. Үүнийг зохицох чадвар (валентность) гэнэ. Үгсийн утгын зохицол нь ойролцоо үгийн утгын багтаамж, тэдгээрийн утганцраас шалтгаалж сонгох, эс сонгох, таарах, эс таарах явдал гарах бөгөөд энэ нь уул өгүүлбэр, эхийн санаа төдийгүй, төрөл жанраас болно. Жишээ нь: Үржилт малаа өсгөхдөө үерхэж явлаа, чамтайгаа. (Р.Чойном. Залуу нас. Уб., 1961) гэхэд “үерх-” хэмээх үг нь “найзал- (дотно нөхөрлөх) хэмээх үйл үгтэй солих боломжтой юм. Учир нь, “найзал-” хэмээх үгнээ а) нийлэх, б) найрах, в) найдах, г) наадах, д) найгах (зүү хаашаа, утас тийшээ) гэх мэт утганцартай бол “үерх-” хэмээх үг нь а) үе мэт таарах, б) насаараа тохирох, в) ойр дотно, г) адил (тоолбол нас чацуу, төөлбөл бие чацуу), д) дотносох зам гаргах гэсэн утганцартай болно. Иймээс энэ хоёр үгийн утганцрын ихэнх нь тохирох тул солих боломжтой ажээ. Тэгвэл, “Налайсан сүргээ хариулж явахдаа найзархаж явлаа, чамтайгаа” гэж болно. Гэтэл “нөхөрлөх, ханилах” хэмээх үг нь “хань бараа болох, анд болох, түшиг хамжаа болох, дэр нийлэх” гэх мэт утгатай юм.

Энэ талаар Тогоо, ойролцоо үгсийн утгын хувьд хөнгөн, хүрээ хэмжээ, хэв заншлын ба сэтгэлгээний өнгө, үг холбох зэргийн ялгааг анхаарах хэрэгтэй хэмээгээд, “ажигла-” гэхэд “нүд талбин шинжисж үзэх”, “анхаар-” гэхэд “сэтгэл тавин сонирхох” гэсэн утгаар ялгагдах ба “хилэгнэ-” гэдэг нь “уурла-” гэхээс хүнд, “зана-” гэдэг нь “хорс-”-оос хүнд тусалттай²² гэжээ. Ийм үгсэд “алдаа-дутагдал, дарлах-доромжлох, ангах-ундаасах, шүтэх-биширэх, цаазлах-хориглох, сарних-бутрах, занчих-цохих, лут-их, мөрөөдөх-дурсах, өлбөрөх-өлсөх” гэх мэт ойролцоо үгсийг багтаажээ. Цааш нь ойролцоо үгс нь хүнд хөнгөний ялгаанаас гадна адил хэрэг үзэгдлийг хийсвэрлэн хураангуйлсан хэмжээ адилгүй “салхи-жавар” (хийн урсгал), гэр-байшин, дайн-байлдаан-тулалдаан, хугацаа-цаг, зам-харгуй” гэвэл эдгээр нэрийтгэлийн утгын хэмжээ адилгүй гэж үзжээ. Мөн “тойрох-тэнэх, хэлэх-чалчих, нүд-мэлмий, унтах-нойрсох, хүүр-чандар, гар-мутар, эхнэр-хатан, хэлэх-айлдах, нэр-алдар, зөвлөх-хуйвалдах, ханихирах-орилох, арга-заль” гэх мэт нь таашаал зэвүүцлээрээ ялгарна гэжээ. Үүнийг мэдэхүүний хувьд баймж үнэлэмжийн ялгаатай гэж болно. “алс-хол” хэмээх үгийг нэгий нь нөгөөгөөр сольж хэрэглэх боловч заримдаа сольж болдоггүй. Жишээ нь: “алс ирээдүй, алслах” гэж болох атал “хол илүү, холдох, хол газар” гэхийг “алс илүү, алсдах, алс газар” гэж болохгүй ажээ.²³ Тэгтэл төв халхчууд “алс газар-хол газар” гэж солин, “алс газар сураар одогч” гэж хэлэлцдэг.

Мэдэгдэхүүний чухал махбодь болсон юмыг хэл шинжлэлд “референт” буюу нэрлэгдэхүүн гэх ба энэ нь А.Х. Гардинер (1879-1963)-ын үзсэнээр “аяндаа мэдэгдэж буй юм” болно. Хэрэв нэг ухагдахууныг олон үгээр илтгэвэл түүнийг хийсвэр ойролцоо үг (“ураг холбосон эмэгтэй” гэсэн нэг ухагдахууныг “эхнэр-гэргий-авгай” (хүүхэн, эм) гурван үгээр илэрхийлжээ. гэдэг бол нэг нэрлэгдэхүүнийг хоёроос дээш үгээр нэрлэвэл бодит ойролцоо үг гэнэ. Жишээ нь: орон зай цаг хугацаагаараа ялгарах нэг одыг монголчууд “үдшийн гялаан-үүрийн цолмон” гэж хоёр өөр үгээр нэрлэдэг. Мөн “лам хуврагийн зоог”-ийг “цав манз”; “агаараар дамжуулах мэдээ”-г “цахилгаан утас” (утас шөрөмсөөр ярих, утас цохих); “гэрэл, агаар оруулах онгорхой”-г “цонх-гэгээвч (салхивч)”; “дуу чимээ хүртэх эрхтэн”-ийг “чих-сонор”; “олноос ялгарах”-ыг

²² Тогоо (1993) Үгийн сангийн зүй. Орчин үеийн монгол хэл, 723 х., Хөх.

²³ Тогоо (1993) Үгийн сангийн зүй. Орчин үеийн монгол хэл, 726 х., Хөх.

"шалгарах-цолгорох"; "өвчнийг анагаах мэргэжилтэн"-ийг "эмч-доктор-оточ"; "адуу маллах хүн"-ийг "агтчин-адуучин"; "гүүний сүүгээр исгэсэн ундаа"-г "айраг-цэгээ"; "хүний цогц эрхтэн"-ийг "бие-лагшин"; "балаг-түйтгэр"-ийг "гай-барцад"; "бараа таваарыг дэлгэн худалдаалах газар"-ыг "дэлгүүр-хориоо"; "хязгааргүй огторгуй дахь одон гарагс"-ыг "орчлон-хорвоо"; "дотоо үерхсэн хүн"-ийг "найз-түши"; "толгой дор ивэх зүйл"-ийг "дэр-жигтүү"; "альтны биеийг бүрхсэн үс"-ийг "ноос-унгас" гэх мэтээр уул хэлний үндсэн үгс нь ормол үг, хуучин үг зэрэгтэй хосолж бодит ойролцоо үгс бүтээдэг байна.

Хэлний мэдэгдэхүүн (ономасиология) нь юмыг ангилан үздэг. Бид нэрлэгдэхүүнийг

1. хүний зүйлс (Эрдэнэ Очир, би, чи, тэр, гар, хөл, өвөлжөө, алба, нүд, чих, хамар, ам, арьс, яс, хэн, юу, яа-) syn. а) бодит утга: атагнуул-туршуул; дайсан-өшөөтөн-атаатан; сайд-түшмэл; сурагч-шавь; шарил-хүүр-үхдэл; замчин-газарчин; айлчин-гийчин-зочин; нүүр-царай-зүс; толгой-тархи-тэргүүн; харуул-манаа-цагдаа-сахиул; хэвэл-гэдэс; хөх-мөөм-дэлэн; идээ-бээр; б. хийсвэр утга: 1) харц-хараа; тэсвэр-тэвчээр; 2) тээр-төвөг-тойв-яршиг-дараа; адаг-эцэс; төлөв-байдал-янз-төрх; нэр-алдар; уг-эх-язгуур; гол-чухал; саад-хориг-тотгор-бэрхшээл; ялгаа-зааг-зөрөө; хэлхээ-холбоо-сүлбээ; аюул-түгшүүр; охь-манлай;
2. адгуусны зүйлс (чоно, баавгай, ялаа, өт, сармагчин, адуу, хонь, нохой, юу, яа-) syn.а. бодит утга: (үхэр-шар, үнээ-мал) (Танай түүгээр чоно нохой тайван уу?) б. хийсвэр утга: тарга-тэвээрэг-(хүч-чадал); идээ-бээр
3. Ургамлын зүйлс (мод, нарс, цэцэг, навч, үндэс, юу, яа-) syn.а. бодит утга: ой-хөвч-тайга; ой-мод; б. хийсвэр утга: шим-тэжээл
4. Хүний бүтээсэн зүйлс (авдар, хувин, гэр, тооно, чөдөр, хашаа, уяа, сур, хазаар, тэрэг) syn.а. бодит утга: туг-далбаа-дарцаг-хиур; шилбүүр-ташуур-малиа; төгрөг-цаас-янчаан-мөнгө; гох-дэгээ; хөрөг-зураг; гэгээвч-цонх; гяндан-шорон; нөмрөг-цув; уяа-шуга-шон; багаж-зэвсэг; балт-сүх; богц-цүнх; бороохой-шийдэм; бөглөө-таглаа; бөмбөр-хэнгэрэг; хана-туурга-хэрэм-хаяа; өлгий-манцуй; б. хийсвэр утга: явдал-ажил-үйлс; халаа-сэлгээ-ээлж; ач-тус; нүгэл-хилэнц; ацаг-хөлс; өр-төлөөс-өшөө; байлдаан-тулалдаан-дайн; хань-бараа; гэрч-баримт; эд-хогшил-хөрөнгө; өргөл-барьц; нэмэр-хандив; зорилт-зорилго; хээл-хаууль; хир-чинээ-чадал; хорио-цааз-цээр; нүгэл-чивэл; гөр-гүжир; магтаал-сайшаал; мэлзээ-мөрий; мэдээ-сураг-чимээ; алдаа-мадаг; шийтгэл-гэгсгээл; тунхаг-зар; тэмдэг-дохио; уламжлал-удамшил; үймээн-шуугиан-дэвжээн; тэтгэмж-асрамж-тусламж;
5. Адгуусны бүтээсэн зүйлс (нүх, хөөс, үүр, ичээ, төвөргөөн, мөөрөх) syn. үлий-нүх
6. Гараг ертөнцийн зүйлс (далай, од, тэнгэр, шороо, газар, нутаг, нар сар, булаг шанд, уул, агаар) syn. нүх-цооног; хир-буртаг; хавчил-ганга; хайр (га)-сайр (га)-зайр; хальс-холтос; салхи-жавар; дов-сондуул; дэлхий-ертөнц-орчлон-хорвоо-бөмбөрцөг; шавар-шавхай; бодис-юм; харз-булаг-шанд; хүдэн-манан-униар-будан; гэрэл-туяа-толон; хоолой-дуу; хөндий-гол-горхи; гуу-жалга-судаг; элс-манх; давалгаа-долгио; чимээ-анир-дуу;
7. Сэтгэхүйн зүйлс (ухаан, бодол, санаа, атаа) syn. оньсого-таавар; шинжилгээ-судалгаа; төрөл-зүйл; төсөв-төлөвлөгөө; тайлбар-зүүлт; арга-самбаа; заль-мэх-ов; ялгаа-зөрөө; ухаан-билэг;

8. Мэдрэхүйн зүйлс (уур хилэн, баяр цэнгэл, өвчин зовлон, хүч чадал, тамир, хайр дурлал) *syn.* итгэл-найдвар; ичгүүр-сонжуур; ид-хүч-тамир-тэнхээ-бяр-бяд-чадал; наргиан-хгөгжөөн-шуугиан; ааш-зан-ааль; зол-завшаан-аз; хайр-дурлал; халшрал-цөхрөл-шантрал; хүсэл-эрмэлзэл; бурхан-шашин;
9. Зөн билгийн зүйлс (зөн, билиг, зүүд) *syn.* ёр-бэлгэ-совин; ерөөл-бэлгэдэл-зөгнөл; буян-хувь-тавилан-заяа; зөн-зорго; зүүд-нойр; зүүд-зэрэглээ;
10. Хий үзэгдлийн зүйлс (буг чөтгөр, бурхан, сүнс сүг) *syn.* буг-чөтгөр-ороолон-үхээр; чөтгөр-албин; чөтгөр-шулам;²⁴ гэж ангилж болох ба дээрхээс гадна юмсын “чанар, тоо, орон, цаг” гэсэн дөрвөн хийсвэр шинжийн зүйлийг нэмж болно. Дээрх жишээг Б.Сумьяабаатар (1966), сурагчид (1977), Дэчин (2001), А.Китамура (2001) нарын толь бичгээс авсан болно.

Н.Д.Арутюнова нэрлэгдэхүүнийг өгүүлбэр судлалын үүднээс, эрхэн ба өртөн үйлдэгч болох ба өгүүлэхүүний үүргээр орсон нэрлэгдэхүүнийг нэрлэгдэхүүн бус гэж үзсэн байна. Логик-утга зүйн үүднээс, нэрлэгдэхүүн нь нэгж болон бүхэл хэсэг зүйлс эсвэл түгээмэл зүйлс, тэдгээрийн шинж чанарыг заах ба мэдэхүүн буюу хэрэглээний талаас, харилцагч этгээд нь уг зүйлийн тухай мэдэх, эс мэдэхтэй холбоотой²⁵ гэж гурван талаас ангилан үзсэн боловч нэрлэгдэхүүнд бие даасан нэгж болох оноосон ба ерийн нэр, нэрийн холбоо үг, заах ба биеийн төлөөний үг, үгүйсгэх (хэн ч биш, юу ч биш, ямар ч биш) ба тодорхойгүй төлөөний үгс багтах ба утга ялгах нэгжид ялгац бүтээвэр, хамаатуулах, заах, тодорхой бус үгүйсгэх онцолбор, тоо ба тэмдгийн нэрийг оруулжээ. Харин энэ тухайд үйл үгийг дурдсангүй нь үйлдэгчийг өгүүлбэртэй холбон үзсэнээс болжээ. Ийнхүү нэрлэгдэхүүн болоод түүнийг тойрсон төлөөний үг, тоо ба тэмдгийн нэр, ялган онцлох бүтээвэр зэргийг тодорхойлсон нь хэлний нэгж, ялангуяа өгүүлбэрийн гүн бүтэцтэй холбогдоно. Харин асуух төлөөний үгс нь нэрлэгдэхүүний хэлэхүүний тал болох биз.

Н.Д.Арутюнова “хэлэхүүний хүрэн дэх бодит байдлын юмсад яг таарах буюу онцлон авсан нэр, түүний бүлэг үгс нь юмсад хамаарах ёсыг нэрлэгдэхүүн”²⁶, “нэрлэгдэхүүн нь өгүүлбэр (үгэлбэр)-ийг ертөнцтэй нөхцөлдүүлдэг арга зам болно.”²⁷ гээд, нэрлэгдэхүүний талаарх гурван чиг хандлага байдгийг дурджээ. Үүнд:

- 1) юм нэр хоёрын холбоог тогтоох онсыг олох
- 2) өгүүлэмж (суждение) бүтээхэд нэр, юуны өмнө үйлдэгч этгээдийн үүргийг тодорхойлох
- 3) нэрлэх ёсыг хэрэглээ буюу хэл ярианы нөхцөлд хэрхэн хэрэглэх хир хэмжээг тогтоох гэж оролддог ажээ. Ийнхүү нэр судлал нь хэлний нэгжийн гүн бүтцийг тодорхойлохыг зорьдог бол утгын гуйвсан хувилбар нь өнгөн бүтэц болно. Үүнд адилтгал (зүйрлэл) ба хам сэрэл (синестезия), орлол ба төлөөлөл, ёгтлол ба бэлгэдэл, егөөдөл ба цээрлэл, ихэсгэл ба багасгал зэрэг дүрслэх ур маяг орох ба эдгээр нь үгийн салаа утга үүсэх эх булаг болно. Нэг үгийн гол ба салаа утга нь нөгөө үгийн гол ба

²⁴ Базаррагчаа М. (1993) Монгол хэлний хоршоо үгийг ангилах нь. *Монгол хэлний хоршоо үг*, 14-17 х., Улаанбаатар.

²⁵ Арутюнова Н.Д. (1990) Референция. *Лингвистический энциклопедический словарь*, стр. 411, Москва.

²⁶ Арутюнова Н.Д. (1990) Референция. *Лингвистический энциклопедический словарь*, стр. 411, Москва.

²⁷ Арутюнова Н.Д. (1982) Лингвистические проблемы. *Новое в зарубежной лингвистике*. Вып. XIII. Логика и лингвистика. (Проблемы референции) стр. 18, Москва.

салаа утгатай ойролцоо байж болох нь дурдсан дүрслэх ур маягтай холбогдоно. Үүнд: “завхай зайдан, нөхөр сүүдэр, түргэн түүхий, уйлах унжих, санах сарвайх, харах хаацайлах, шунах шулах, хэрүүл цуугиан, мандах бадрах, үхэх хатах, хайр гам, гал голомт, өдөр судар, удам судар, тохоох томилох, атаа хор” гэх мэт ойролцоо хоршоо үгс нь адилтгалаар бүтсэн бол сав сааль, хэл ам, гал тогоо, мод толгой (соруулгүй гаанс), түүх шастир, өртөө улаа” гэхчлэн орлолоор утга ойр хоршоо үгс бүтсэн байна. С.Ульманн ойролцоо үгийн талаар бичихдээ, ойролцоо үгс нь утгаараа алгуур ондооших (закон дистрибуции), эсвэл утгаараа ижилсэх (закон притяжения) гэсэн түгээмэл ёс байдаг.²⁸ -ийг дурдсаны сүүлчийн ёс нь монгол хэлний ойролцоо хоршоо үгс болно. Ийнхүү ойролцоо үгс нь нягтран ижилсэх (концентрация) ёс нь хоршоо үг төдийгүй хэлний бүх түвшдийн нэгж хооронд ч бий болдог байна. Жишээ нь: “ягт- (мөхөх, мухардах, туйлдах, тамирдах, эцэх), шалчийх (хавчийх, нялцайх, доройтох, хулчийх) гэж утгажиж ганцажсан хэлц үг нь

шалчийчихсан хүн
 голгүй болсон эр
 гол нь буурсан хүн
 явцгүй болсон хүн
 морь явахаа байсан хүн
 хий нь гарчихсан гүзээ
 энэ болж эцсэн хонины дэлэн болчихсон
 хэмхэрхий араг шиг
 хүнээсээ гарсан хүн
 хүний тооноос гарсан хүн
 шалдаа буусан хүн
 хорвоо нь өнгөрсөн хүн
 хөсөг нь явчихсан хүн
 ир нь мохсон хүн
 харьж гүйцсэн эр
 больчихсон эр
 хорголоо хатаасан амьтан

гууль нь цухуйсан амьтан²⁹ гэсэн хэлц холбоо үг, өгүүлбэртэй утга санаа ойр болох ба нөгөө талдаа “хогшин хонины насгүй бол-, насны наран хэлбий-, насан зүг бол-, нас дээр гар-, нас өндөр бол-, ханат гэр холдож, хадан гэр ойрт-, эсгий гэрээсээ холдож, энгэр газартаа оч-, эрхтэнбүгд мох-“ гэсэн хэлц холбоо үг, өгүүлбэрийн санааг ч агуулж байж болно. Дээрх хэлц нэгжид “гол, гал, морь, хий, дэлэн, араг, хөсөг, ир, хорвоо, хоргол, гууль” гэх мэт түлхүүр ба тулгуур үгс нь нэрлэгдэхүүн болжээ. Үүний дотор “морь, дэлэн, хоргол” нь малтай, “араг, хөсөг” нь нүүдлийн соёлтой холбоо бүхий сүегэр нэгж ч болж болох юм. Ю.Д.Апресян үгийн тайлбартай холбогдуулан, тайлбарлах зүйл буюу ойролцоо үгсийн үүр эгнээн дэх үгсийн утга нь 1) үйл явдал, хэрэг явдал, юмс, шинж, нөхцөл байдлыг ерийн гэнэн байдлаар тэмдэглэсэн байх ба 2) эдгээрийг яригч сонсогч этгээд сайн муу, магадтай магадтай

²⁸ Ульман С. (1970) Семантические универсалии. Новое в лингвистике, Вып. V. (Языковые универсалии), стр. 265-266, Москва.

²⁹ Лувсанжав Чой. (1970) Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь. 147 х., Улаанбаатар.

бус, хүссэн хүсээгүй гэх мэтээр үнэлсэн үнэлэмж хоёроос бүрдэнэ³⁰ гэжээ. Тэрээр, *“утгын зохицол нь үгтэй холбоо бүхий хэлний бус гадаад олон хүчин зүйл болон тэдгээр үгсийг хэрэглэж ирсэн дадал зуриил, мөн түүний боловсронгуй болж ирсэн түүх уламжлал, соёлын утга учрыг илтгэнэ”* гэжээ. Монгол хэлний *“сахал самбай”* гэсэн хоршоо үг нь *“сиймхий муу хадаг”* гэсэн утгатай *“самбай”* хэмээх үгтэй адилтгасан нь монголчуудын сэтгэх онцлогийг илтгэж, *“сахал”* гэсэн гол үгнээ *“сэмбэгэр хөвсгөр”* гэсэн утгыг нэмэр хачир болгож, ойролцоо үг бүтээсэн нь *“үс сахал”* гэсэн шууд утгат хоршоо үгээс ялгаатай юм. Ийнхүү мэдэхүүний хувьд ойролцоо үгс нь үнэлэмжээр ялгарахаас гадна, утга соёлын утга учрыг давхар агуулсан байдаг. Тэгэхдээ хэлэхүүн ба мэдэхүүний ойролцоо үгс нь ихэвчлэн хуурмаг ойролцоо үгс байх болно.

Хэлний шаталсан нэгжүүдээс үг, өгүүлбэр хоёрыг санаа бүтээх хамгийн чухал нэгж хэмээн үзэж болно. Юу гэвэл, салангид юмс үзэгдлийг үгээр нэрлэж, тэдгээрийн хөдлөнг ба зогсонги шинжийг үйл ба тэмдэг нэрээр тодорхойлбол сая тухайн санаа бүхий өгүүлбэр бүтдэг байна. Ийм ч учраас ойролцоо үг, өгүүлбэр, тэдгээрийн хувилбарыг төсөөт үг, өгүүлбэр, тэдгээрийн хувилбараас нь ялгах хэрэгтэй ч тэдгээрийг зааглахад хялбар биш, нэлээд нарийн шалгуур шаардсан төвөгтэй ажил байдаг тул энэхүү асуудлыг шийдэхэд тус дөхөм болох үүднээс ойролцоо үгийн үүсэл, утгын хэв шинжийг тодруулахаас гадна, ойролцоо утгын дотоод заагийг тогтоохыг оролдлоо.

Ийнхүү ойролцоо үгийг бодит буюу юмжуулах харьцаа, хийсвэр буюу дохиожуулах харьцаанд нь үндэслэн, мэдэгдэхүүн-хэлэгдэхүүн-хэлэхүүн-мэдэхүүний талаас ялгасан нь ойролцоо өгүүлбэр, өгүүлбэрийн хувилбар хоёрыг, бүр цаашилбал, төсөөт өгүүлбэрээс зааглахад чухал зүйл болно гэж үзэж байна. Ялангуяа ойролцоо өгүүлбэрийг судлахад, түүнийг бүтээхэд идэвхтэй оролцдог ойролцоо үг хэрхэн бий болдгийг эрхбиш харгалзах нь зүйтэй юм.

Иймээс ойролцоо үг үүсэх эх сурвалжийг *“бодит буюу юмжуулах харьцааны үүднээс, нэг юмыг ойролцоо байдлаар ухаарснаас үүссэн, эсвэл хийсвэр буюу дохиожуулах харьцааны үүднээс, өөр өөр юмыг аль нэг шинжээр нь ойртуулж хэлэнд тулгуурлана”* гэж үзэж болно.

Энэ санааг үгийн дээд түвшин болох өгүүлбэрийн түвшинд харгалзуулан үзвэл болно гэж бид бодож байна. Тодруулбал, монгол хэлний ойролцоо өгүүлбэр (зэргэд) нь нэг талаас, бодит юм үзэгдэл буюу үйл явдалтай шууд холбоо бүхий юмжуулах харьцаа (денотативное отношение)-нд, нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин үйл явдлаас үүдэлтэй холбоо бүхий дохиожуулах харьцаа (сигнификативное отношение)-нд үндэслэдэг гэж үзлээ. Үүнээс үндэслэн, ойролцоо өгүүлбэрийг мэдэгдэхүүн ба мэдэхүүн, хэлэгдэхүүн ба хэлэхүүний талаас мөн ялган үзэж болно. Ялангуяа мэдэгдэхүүн, хэлэгдэхүүний талаас ойролцоо зэргэд өгүүлбэрийг бүтээхэд ойролцоо үг чухал үүрэгтэй болох нь хэлний баримтаас харагдаж байна.

Ю.Д.Апресян ойролцоо өгүүлбэр нь өгүүлбэрийн гүн бүтцээр тодорхойлогдоно гэж үзэж байна. Тэрээр *“Өгүүлбэр бүтэхдээ 1. Дагавраар (Я постоянно читаю в этой библиотеке-Я постоянный читатель этой библиотеки), 2. Үгийн утга салаалах замаар (Фильм произвел настоящую сенсацию-Фильм был настоящей сенсацией), 3. Ойролцоо*

³⁰ Апресян Ю.Д. (1988) *Англо-русский синонимический словарь*. стр. 514, Москва.

нэрээр (Она притворялась глухой-Она прикидывалась глухой), 4. Өөрчлөх (конверсия) замаар (У нас вышли все деньги-Мы истротили все деньги), 5. Эсрэг нэрээр (Он перестал соблюдать правила-Он начал нарушать правила)³¹ үүсгэж болно гэж үзсэн байдаг. Эдгээрийн эхний хоёр нь өгүүлбэрийн хувилбар бүтнэ гэж бодож байна. Эндээс ойролцоо өгүүлбэрийг тодорхойлохдоо тухайн хэд хэдэн ойролцоо өгүүлбэрийг бүтээж буй гишүүн буюу үндэс нөхцөл хоёрын аль алиныг харгалзах шаардлагатай нь илэрхий байна. Харин “*тухайн зэрэгцсэн өгүүлбэрийн хоёроос дээш гишүүд нь ойролцоо үгээр ялгарсан бол ойролцоо өгүүлбэр бүтнэ. (Гэмтэйгээс гэтэлгэсэн, гайтайгаас гаргасан, Хан гэх ханиад гэмгүй, тог гэх томуу гэмгүй.*

Хатуугаас харьдаггүй, бузраас буцдаггүй

*Өрхтэй гэрээр онгийж, тоонотой гэрээр тонгойж тогтон залар)*³²

Хэлний шаталсан нэгжүүдээс бүтээвэр, үг хоёр нь утга илтгэдэг бол өгүүлбэр, цогцолбор хоёр нь санаа илтгэнэ. Өгүүлбэр ба цогцолборын санаа нь бүтээвэр ба үгсийн утгад тулгуурлах ба тухайн өгүүлбэрт бүрэлдүүлбэрийн задаргаа хийн үзэхэд тодорхой харагдах болно. Тухайлбал,

Даравч дардайна.

Булавч бултайна. гэхэд “*дарах-булах, дардайх-бултайх*” гэсэн ойролцоо үг бүхий гишүүдээр ижилсэн холбогдож, “*үнэнийг нууж дарах гэж яаж ч оролдовч заавал ил болдог*” гэсэн санааг агуулж байгаа тул ойролцоо зэргэд болно.

* * *

Гаргалгаараа бүрэн ондоошиж, агуулгаараа бүрэн ба бүрэн бус тохирох үгсийг ойролцоо үг гэнэ. Өөрөөр хэлбэл, адил бусын адил нэгжийг ойролцоо нэгж гэнэ.

Мэдэгдэхүүн буюу нэр судлал (ономасиология)-ын үүднээс, а) *нүд-мэлхий, толгой-тэргүүн, б) ший-жүжиг, ший-янгуу, шял-бүрх, алдаа-мадаг, в) ирэг-хаяа, айвал-мануухай, одоох-нөхөр, оомжих-туулах, эмгэн-самган, балт-сүх, булхах-шургах, шаам-шүүр, бэдрэх-эрэх*” зэрэг ойролцоо үгс нь нэг юмыг өөр өөрөөр нэрлэсэн бол хэлэгдэхүүн буюу утга судлал (семасиология)-ын үүднээс, а) *хэл шинжлэл-хэл судлал, морфем-бүтээвэр, бааз-суурь,*

б)

бие халуу
гэр бүлээ } орги-
нүүр дулаа

халуун нүүр
бүлээн цай
дулаан өдөр

бие халуур-
бүлээр-
цаг дулаар-

нүүр, чих халууц-
гэр бүлээц-
бие дулаац-
наранд

гэсэн дөрвөн бүлэг ойролцоо үгийн тухай тухайн үгтэй зохицох нь салах, нийлэх хоёр янз байна. Үүнийг Ю.Д.Апресян “*үгийн сангийн зохицол*” гэжээ. Харин “*нүүр халуу орги-, халуун нүүр, нүүр халууц-, чих халууц-*” гэвэл “*ичих, уулзаж учрахад бэрх*” гэсэн шилжсэн утга бүтээх учир үүнийг “*утгын зохицол*” гэнэ. Эдгээр үгс нь жинхэнэ нэрнээ хамжих, нэрлэх ба өгөх-орших, гарах тийн ялгалт үгсийг захирч буй нь “*бүтээвэр-өгүүлбэр зүйн зохицол*” болно. Энэ гурван үг нь нэг нь нөгөөгөө орлох буюу нэг нь нөгөөгөө багтаахын зэрэгцээ “*цаг дулаар-, цаг бүлээр-, бие халуур-, бие бүлээр-*” гэж болох атлаа “*цаг халуур-, бие дулаар-*” гэж хэлж болдоггүй. Үүнийг Ю.Д.Апресян “*нөхөх буюу салбицох нөхцөл*” гэжээ.


³¹ Апресян Ю.Д. (1974) Лексическая семантика. Синонимические средства языка. стр. 157, Москва.

³² М. Базаррагчаа нар. (2002) Монгол хэл-9. 32 х., Улаанбаатар.

Үүнээс гадна, в) тухайн үгс нь утгын холбогдолгүй боловч эхэд ойролцоо утга илтгэх (машин зогс-, машин эвдэр-, зүрх зогс-, үх-; бороо зогс- тэнгэр ойгой-; хар гүйхээрээ ир- хар хурдаараа давхи-), г) төрөл зүйлийн үгс нь ойролцоо утга илтгэх (үнэ буу-, үнэ буур-; өндөр хүү-өсгөлүүн хүү; худал хуурмаг, худал хуурамч (хуурамч өнгөц), өмгөөл-, хамгаал-; угаа-, цэвэрлэ-, арилга-) ажээ. Энэхүү “в, г”-д дурдсан ойролцоо үгийг А.Вежбицкая зэрэг эрдэмтэд зөвшөөрдөггүй боловч хэлэхүүн ба мэдэхүүний түвшинд тухайн нэг утгыг тойруугаар ойролцоо утгыг бүтээж болох юм. А.Вежбицкая үгсийн утгын зохицлын талаар төрөл зүйлийн харьцаа заадаг (гипонимия) (цэцэг→сарнай, башир) ерөнхий тодорхойн харьцаа заадаг (тээвэр→машин, унадаг дугуй), их багын харьцаа заадаг (тавилга→ор, сандал), хуурмагаар тоолох (жимс→алим, амтат жүрж) зэрэг хэд хэдэн зүйл болгосон байдаг. Эдгээр нь хуурмаг ойролцоо үг бүтээж болно.

Монгол хэлнээ а) нутаг-нуга, санаа-сэдэв, эд-хөрөнгө, эд-хогишил, сонор-чих, толгой-тархи, айл-гэр, аймаг-сум, аймаг-хошуу, амьтан-хүн, байгаль-орчин, унаа-морь (ерөнхий тодорхой); б) санаа-байдал, сургууль-соёл, хөхөө-шувуу, үхэр-мал, нүүр-царай, амуу-хишиг, араа-шүд, байшин-барилга, бүс-бараа (тодорхой ерөнхий) гэсэн хоршоо үгс нь хуурмаг ойролцоо үгсээр бүтэх ба айл-өрх, үнэ-хүнд, харах-хаацайлах, санах-сарвайх, нас-сүүдэр, зориг-зүрх, зах-зээл, шунах-шулах, хөл-үймээн, түргэн-түүхий, уйлах-унжих, яс-яндан, эцэс-сүүл, залуу-зандан, сэрүүн-тунгалаг, яс-чанар, шагших-магтах, хир-хилэнц, хов-хожуу, тохоон-томилох, нэр-ус, ураг-элгэн, нэр-сүр, гашуунтан-зовлонтон” гэх мэтээр адилтгасан ойролцоо хоршоо үг бүтжээ. Энэ нь мөн л хуурмаг ойролцоо үг болно.

Ийнхүү үг хорших нь ойролцоо үг бүтээх нэг эх үүсвэр болох ба эрдэмтэд ойролцоо хоршоо үг (синонимические пары) гэж нэрлэсэн байдаг. Мөн “хэл ам” гэхэд “үг яриа”-г өгүүлэгч эрхтнээр нь солин нэрлэж, орлолоор бүтсэн ойролцоо үг юм. Үүнийг утга саармагших ёс гэж болно. “уях-сойх” гэсэн хоршоо үгийг авч үзье. “зангидах, бэхлэх, тогтоох” гэсэн утгатай “уях” гэсэн үг нь “алив юмыг хязгаарлах, тогтоох” гэсэн утгатай, “сойх” хэмээх үгтэй хоршиж ойролцоо үг бүтээнэ. Гэтэл энэ үг нь “морь уралдуулахаар засах” гэсэн утгаар ижилсэж буй нь уул хоёр үгийн утга саармагшиж ойролцоо үг бий болгожээ. Үүнд:



Ерийн нэрээс эхтэй оноосон нэр нь мэдэгдэхүүнд, нэр томьёо нь хэлэгдэхүүнд тус тус хамаарна. *Эверестийг Джомолунгма, Маниловыг Хоосон мороодогч, Бямбасан багийн* “Сан баги”, *Жамсраны Цэвээн (Цыбин Жамцарано)-ийг Уулын овгон, Чүлтэмсүрэн арсланг Хужаа, Ц.Дамбадоржийг Абмад, Г.Навааннамжилыг Анваан, М.Цэдэндоржийг Зээхүү, Ж.Барамсайг Ж.Ууган* ³³ гэж оноосон нэг нэрийг өөр ба нууц нэрээр нэрлэсэн нь А.А.Брагинаас оноосон нэр ч ойролцоо байж болно хэмээн үзсэнтэй нийцэж байна. Энэчлэн нэг ухагдахуун илтгэсэн нэр томьёо ч гэсэн ойролцоо утга бүхий үгсээр хэлэлцэгдэх нь байдаг аж. Жишээ нь: *хошуу будаа-овъёос (овёс); үйлт нэр-цагт нэр-тодотгон холбох нөхцөл-тэмдэг үйл; залуур зүй-удирдлагын онол (теория управления); Их хүрээ-даа хүрээ-Улаанбаатар; витамин-амин дэм; усны бух-усны бух шувуу; хотгуужин нугас-хотгуужин-чөрх; гар далавчтаны баг-сарьсан далавчтан; ундар нүдэн шумбуур-ундар шумбуур (шувуунд холбогдолтой нэр томьёо нь оноосон нэрийн хувилбар юм.) бөгж-бугуйвч-залгавч-холбогч; балархай эгшиг-огцом эгшиг* г.м. Энэ тухайд Б.Баярсайхан “*Нэр томьёог бүхэл бүтэн салбарын ертөнцийг үзэх үзэл ч гэж болно. Нэр томьёо нь заримдаа нэгэн зэрэг хэд хэдэн салбарын ч нэр томьёо болж чаддагаараа бас ч олон утгатай гэж хэлж болно*”³⁴ гээд, О.С.Ахмановагийн хэл шинжлэлийн нэр томьёоны тольд “*фразеологическая единица*” гэсэн хэлц үгийн нэр томьёо 23 синоним буюу ойролцоо утгатай үг...орсон байдаг” гэжээ. А.А.Брагина ойролцоо нэр томьёоны тухай бичихдээ “*Ойролцоо нэр томьёо үүсэх нь хам цагийн хэрэглээнээс шалтгаалж, нэр томьёо нь энгийн болох буюу өргөсөх, эсвэл явцуурах гэсэн хоёр хөдөлгөөнтэй холбоотой юм*”³⁵ гэжээ.

Монгол хэлний ойролцоо хоршоо үг нь ойролцоо үг бүтэх эх сурвалж болох ба ойролцоо үгийн үүр эгнээ нь мөн л хослох буюу хорших замаар үүсдэг ажээ. Жишээ нь: “*гүтгэ-, гөрдө-*” (гөрдөн гүтгэх, гүтгэн гөрдөх) гэсэн ойролцоо хос үгийн аль нэгэнд нь “*гүтгэн мэлзэх, гөрдөн мэлзэх*” (хийсэн, хийгээгүй хэрэг, хэлсэн хэлээгүй үгээ ор тас үгүйсгэх) гэсэн ойролцоо үг бүтээнэ. Үүнд:


мэлз-	гөрд-	:	гүжирд-	мэлз-
-------	-------	---	---------	-------

Харин “-д” (-de), -л (-le) дагавар сэлгэх учир “*гөрд-, гөрлө-*” гэсэн нэг язгуурт ойролцоо үг бүтэх ёстой боловч “-л, -д” дагавар нь утгын ноцтой ялгаа эс гаргах тул үгийн хувилбар болно. “-ж- (-й-)” бүтээвэр нь “-d\le-” дагавартай сэлгэж, “*гүтгэ-*” гэсэн үг бүтэж, төсөөт үг үүсчээ. Энэ төсөөт үг нь “*гөрд-*” гэсэн үгтэй хоршиж “*гүтгэх гөрдөх*” гэсэн ойролцоо хоршоо үг бүтнэ.


³³ Баатар Я. (1997) *Утга зохиолын нэр зүй*. 104-106 х., Улаанбаатар.

³⁴ Баярсайхан Е. (2005) *Нэр томьёоны тулгамдсан асуудалд// Нэр томьёо судлал*, 16 х., Улаанбаатар.

³⁵ Брагина А.А. (1986) *Синонимы в литературном языке*. стр. 52, Москва.



гэх мэтээр харьцуулбал хоршсон ойролцоо үгийн нэг гишүүнд нь утга ойр, эсвэл уул хоршоо ойролцоо үгийн аль алинд утга ойр байх ба “эмх цэгц” гэсэн хоршоо үгнээ “журам дэглэм” гэсэн хоршоо үг ойролцоо байх жишээтэй. Бидний санавал, нэг язгуурт ойролцоо үгс нь төсөөт үг ойролцоо үг хоёрын дундын шинжтэй юм. Жишээлбэл, “эц-, цуц-” гэвэл “э” нь “у”-тай, “ц” нь “о” (тэг хоосон)-тус тус сэлгэж үүссэн тул авианы бүрэлдэхүүн, бүтцийн хувьд төстэй, утга ойр юм. Энэчлэн “ядар-, зүдэр-” гэхэд мөн авиалбарын сэлгэцээр бяцхан ялгарсан боловч утга нэг тул ойролцоо ба төсөөт үгийн завсар дундын шинжтэй болно.



Үүнээс “эц-:цуц-; яд-:зүд-; ядар-:зүдэр-; энэл-:шанал-; урва-:шарва-; урва-:хөрвө-; эргэ-:хурга-” зэрэг нь нэг талаас нэг язгуурт ойролцоо үг, нөгөө талаас, уул үгсийг бүтээж буй авиалбарын бүтэц бүрэлдэхүүн төстэй, утга нь төстэй юм. Харин

“буцах: няцах” гэвэл төсөөрхүү үг (параномазия) болно. Мөн “эвэршээ-(өвдөх)-эвэрлэ-, чил-, чилээр-, чилээрх-” гэвэл дагаврын аргаар бүтсэн салаалбар буюу “*derivатема, деривация, синонимическая иррадиация*”³⁶ болно. Ю.Д.Апресян, учир зүй (логика)-д нэр буюу ухагдахууныг бүрэн ба бүрэн бус тохирох, нэг нь нөгөөдөө багтах төрөл зүйлийн харьцаатай, бие биеэ үгүйсгэсэн³⁷ гэж ангилдаг зарчмын дагуу 1. бүрэн тохирох синонимд ойролцоо оноосон нэр ба нэр томъёоноос гадна ойролцоо ба төсөөт үгийн дундын шинжтэй, а) *эцэх-цуцах, ядрах-зүдрэх, ядах-зүдэх, энэлэх-шаналах, энслэх-дэнслэх-донслох, урвах-шарвах, эргэх-хургах, урвах-хорвөх, б) занги-зангиас-зангиа; зангилаа (зангилаас)-зангилгаа* зэргийг багтааж болох юм. Эдгээр нь багтаамжаараа адил боловч агуулга (утга)-аараа өөр юм. Үүнийг S. P (хүү нь ач, ач нь хүү) гэж тэмдэглэнэ.

2. бүрэн бус тохирох синонимд “*чилэх-алжаах, зовох-өвдөх, эвэршээх-тарчлах, халирах-шантрах, харих-буцах, мохох-цуцах, манаа-цагдуул-харуул-сахиур; өргөх-тэтгэх-дэмжих-туслах; хөх-мээм (мөөм)-дэлэн; маргах-мэтгэх-мэлзэх; завсар-хооронд-зуур; тэнэг-мунхаг-мулгуу*” гэх мэт ойролцоо үгийг оруулж болно. Эдгээр нь багтаамжаараа бүрэн бус тохирох авч агуулга (утга)-аараа өөр юм.

ядрах
{

 чил- (бие эрхтний хөдөлгөөн удааширч, хөших)
 алжаа- (бие эрхтэн сулдаж, чилэх) гэхэд “бие эрхтэн сулдаж, сул байх” гэсэн утганцраар тохирч, “удааширч хөших”, “сунаж алдрах” гэсэн утганцраар ялгарч байна.

хүн амьтан үр
төлөө сүүгээр
тэжээх эрхтэн
{

 хөх (үр зулзагаа тэжээх сүүний булчирхай, сүү шимэх сорох эрхтэн)
 дэлэн (адгуусны хэвлийд байх сүүний булчирхай бүхий эрхтэн)
 мээм (цээжний өвөрт байрлах товгор хос эрхтэн)

гэхэд “сүүний булчирхай бүхий эрхтэн” гэдэг утгаараа таарах боловч “хөх” нь “хүн амьтны сүүт эрхтэн” гэсэн утгыг заах тул ерөнхий утгатай ба “хөх” нь “шимэх, сорох, хөхөх” гэсэн утгатай юм. Харин “дэлэн” нь зөвхөн адгуус амьтны тухайд хэрэглэдэг утгатай ажээ. Энэчлэн “мээм-мөөм” нь зөвхөн эмэгтэй хүний хөхийг нэрлэх ажээ. Үүнийг S P гэж тэмдэглэх ба бид “*нөхсөн ойролцоо үгс*” гэж нэрлэсэн билээ.

Үүнийг учир зүйд “*огтлолцох харьцаа*” (пересечение) гэжээ.

- 1) *хундага, туг, гар, толгой, биеэ, хүүхэд, зул, цацал, ая, хошуу, тоосоо, ес өргөх*
- 2) *тэнгэр, хүүхэд, настанг тэтгэх*
- 3) *хүүхэд, настан, санал, ёсыг, итгэл, бодол, санаа, үзэл дэмжих*
- 4) *хүүхдэд, настанд, ажилд, гэртээ, багшид, монголд туслах*


гэхэд “хүүхэд өргөх, дэмжих, тэтгэх” гэж болох боловч “зул дэмжих, тэтгэх” гэж болохгүй юм. Харин “туслах” гэсэн үг нь заах бус, өгөх-оршихын тийн ялгалт нэрийг захирдгаараа ялгарна. Гэвч “настныг өргөх, дэмжих, тэтгэх, настанд туслах” гэсэн ойролцоо утгыг бүтээж болох ажээ.

³⁶ Апресян Ю.Д. (1974) Лексическая семантика// *Синонимические средства языка*. стр. 225, Москва.

³⁷ Ивин А.А. (2000) *Логика*. стр. 44-47, Москва.


“*өргө-, тэтгэ-, дэмж-, тусал-*” гэсэн үүр үгсээс “*өргө-*” гэсэн үг нь “*дээш болго-*” гэсэн бодит утгатай тул үлдсэн хийсвэр үгсэд утгаараа багтах болно. Мөн дээрх “*хөх*” хэмээх үгнээ “*дэлэн, мээм*” хэмээх үг нь утгаараа багтах тул үүнийг багтсан харьцаа бүхий ойролцоо үг гэж болно. Мөн “*тусал-*” хэмээх үг нь “*элбэ-, хамж-, хавсар-, хамс-, тэтгэ-, тэтгэмжил-, дэлнэ-, дэмж-*”, цаашилбал, “*түш-, тул-*” хэмээх ойролцоо үгсийг багтаах учир “багтаагч” хийсвэр буюу ерөнхий утгатай юм.

3. Нэг ухагдахуун нь нөгөөгөө багтаасан харьцаанаас ойролцоо үг бүтнэ. Үүнийг



гэж тэмдэглэх ба энэ нь төрөл (род) зүйл (вид)-ийн харьцааг илтгэнэ. Үүнийг Ю.Д.Апресян хуурмаг ойролцоо үг гэжээ. Үүнд: *харуул* (хөдлөнг бус, “зогсож байдаг”)-*хуяг*(хөдлөнг, “харгалзан явах”)(“зүйл-зүйл”) “*угаах-цэвэрлэх, эвдэх-устгах*” (зүйл-төрөл) зэрэг ойролцоо үгс багтах ажээ.

4. Тухайн хоёр үгс утгын аль нэгэн холбогдолгүй боловч ойролцоо утга илтгэнэ. Жишээ нь: “*хамаг байдгаараа, байдгийгаа шавхан*” гэхийг “*эрвийх дэрвийхээрээ*” “*сиймхийгээр нь хийдүүлэх*” гэхийг “*салхи авхуулалгүй, чих цохиулалгүй*”, “*харсаар байхад*” гэхийг “*улаан нүүрэн дээр нь*”, “*нохой юм боллоо*” гэхийг “*хаашаа харж үхдэг билээ*”, “*таг мартав*” гэхийг “*таг идчихээж, зүүдэнд ч үгүй, арилжээ*” гэх мэтээр хэлэлцдэг. Ийм ойролцоо үг хэллэгийг



гэж тэмдэглэнэ. Энэ мэтээр монгол хэлний ойролцоо үг болоод ойролцоо нэгжийг учир зүй дэх нэрсийн дээрх хэд хэдэн харьцааг нягталбал зохилтой байна.

Л.М.Василев ойролцоо үгийг 1) хэлний нэгжис нь утгаараа туйлын адил буюу омосемант (туйлын ойролцоо үг); 2) хэлний нэгжис нь утгаараа ихэд ойр буюу парасемант (хоршсон ойролцоо үг)³⁸ гэж ангилсан ба ерөнхийдөө туйлын ойролцоо үг хэлэнд байхгүй, харин үгс нь утгаараа ойр байх боловч гүйцэтгэх үүрэг, хэлэх санаа, найруулга зэргээрээ ялгаатай болно гэжээ. Энэ бүхнээс үзвэл, монгол хэлний ойролцоо нэрийг дараах байдлаар баримжаалан ялгаж болох мэт. Үүнд:

1. туйлын ойролцоо үг	1. бодит утгын тохицол 1. -зарлага = тахар -жааз = хүрээ = рам -тонишуул = цондуул 2. буудлага ≠ буудалцаан ≠ буудалдаан шавар ≠ шавдай	мэдэгдэхүүн	2. хийсвэр утгын тохицол 1. эр бөднө = хулжуухай -үйлт нэр = цагт нэр = тэмдэг үйл = нэр тэмдэг 2. халууц- ≠ дулаац- ≠ бүлээц- а) осго- ≠ хөлд- ≠ б) бээр- ≠ даар-	хэлэгдэхүүн
1. оновчтой бус ойролцоо үг	1. өвгөд ≠ өтгөс ≠ дээдэс ≠ урьдас 2. уя- ≠ сой- угаа- ≠ цэвэрлэ- ≠ арилга- ≠ арч- (устга-, ≠ балла-) унт- ≠ нойрс- ≠ дугжир- ≠ хажуул-	мэдэхүүн	хэлэхүүн	1. нөхөр ≠ сүүдэр, хувь ≠ тавилан, хичээ- ≠ мэрий- ≠ чармай- ≠ мэхий- ≠ улай-
2. хуурмаг ойролцоо үг	4. найруулгын утгын зохицол			2. осго- ≠ хөлд- ≠ хөр- ≠ царц- даар- ≠ бээр- = чичир- ≠ мөс бол- оршуул- ≠ нутаглуул- ≠ хөдөөлүүл- ≠ тавь- ярь- ≠ өгүүл- ≠ хүүрнэ- ≠ хөөр- ≠ (чалч- ≠ бур-) 3. шилжсэн утгын зохицол

³⁸Васильев Л.М. (1990) Современная лингвистическая семантика. стр. 128, Москва.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

- Баатар Я. (1997) *Утга зохиолын нэр зүй*, Улаанбаатар.
- Баатар Да. (1992) *Иж үгийн толь*, Хөх.
- Бадамдорж Д. (1997) *Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс*, Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1990) *Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухай*. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1991) *Хэлний үндсэн ба завсрын нэгжийг тал бүрээс үзэх нь*, Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1993) *Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр*, Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1993) *Монгол хэлний хоршоо үгийг ангилах нь. Монгол хэлний хоршоо үг*, Улаанбаатар.
- Базаррагчаа М., Баянсан Ж. (1996, 1997) *Монгол хэл уран зохиолын лавлах*. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (2002) *Монгол хэл-9*. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (2003) *Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай*. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (2005) *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Улаанбаатар.
- Байгальсайхан С. (1995) *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар.
- Бат Ирээдүй Ж. (1998) *Монгол хэлний ойролцоо утгат үг хэллэгийн бүтэц, утга, үүргийн судалгаа*. Хэл бичгийн ухааны доктор (Ph.) –ын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар.
- Баярсайхан Б. (2009) *Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг*. Эрхэлсэн Б.Баярсайхан, хянан тохиолдуулсан А.Янжиндолгор. Улаанбаатар.
- Баярсайхан Е. (2005) *Нэр томъёоны тулгамдсан асуудалд. Нэр томъёо судлал*. Улаанбаатар.
- Бямбасан П. (2006) *Орчин цагийн монгол хэлний синоним. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд*. Улаанбаатар.
- Бямбасан П. (2006) *Монгол хэлний хуучирсан үгийн тухай. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд*. Улаанбаатар.
- Гаадамба М. (1958) *Утга зохиолын онолын товч*. Улаанбаатар.
- Гаадамба Ш. (1989) *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар.
- Галбаяр Г. (2002) *Уран зохиол шинжлэлийн лекц*. Улаанбаатар.
- Галбаатар Д. (2002) *Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь*. Токио.
- Дулам С., Хасбаатар Ц. (1980) *Уран зохиолын онолын үүд*. Улаанбаатар.
- Дэчин. (2001) *Монгол хэлний ойролцоо утгатай үгийн толь*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.
- Жагварал Р. (1976) *Монгол хэлний хүндэтгэлийн үг*. Улаанбаатар.
- Идэрбаяр Б. (2005) *Ойролцоо утга бүхий төсөөт үгс. Монгол хэлний төсөөт үг*. Улаанбаатар.
- Китамура А. (2001) *Орчин цагийн монгол хэлний ойролцоо утгат үгийн толь бичиг*. Улаанбаатар.
- Лувсанжав Чой, (1964) *Нэр томъёоны цуврал бичиг, Хэл шинжлэл*. Улаанбаатар.
- Лувсанжав Чой. (1970) *Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь*. Улаанбаатар.
- Лувсанвандан Ш. (1939) *Монгол хэлний зүй*. Улаанбаатар.

- Лувсанвандан Ш. (1951) *Монгол хэлний зүй. Өгүүлбэрийн зүй. 2-р дэвтэр*, Улаанбаатар.
- Лувсанвандан Ш. (1962) *Орчин цагийн монгол хэл*. Улаанбаатар.
- Лувсанвандан Ш. (1962) *Үгсийн сангийн зүй*. Бээжин.
- Лувсанвандан Ш. (1976) Орчин цагийн монгол хэлний үгэлбэрийн бүтцийг судлах тухай асуудалд // *Хэл зохиол судлал*. XII боть, Улаанбаатар.
- Лувсанвандан Ш. (1982) Хүний хэлэнд байгаль, нийгмийн үзэгдэл үлигэр болсон нь // *Хэл зохиол судлал*, XV боть, Улаанбаатар.
- Лувсанвандан С., Сумьяабаатар Б. (1966) *Монгол хэлний ойролцоо үгийн толь*. Улаанбаатар.
- Лувсанжав Чой. (1970) *Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь*. Улаанбаатар.
- Нансалмаа Н. (2005) *Үгийн сан судлал*. Улаанбаатар.
- Отгонсүрэн Д. (1975) *Монгол хэлний найруулга зүй (Найруулгын төрөл, үгийн сангийн найруулга зүй)*, Улаанбаатар.
- Отгонсүрэн Д. (1984) *Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга, уран сайхны онцлог*, Улаанбаатар.
- Отгонсүрэн Д. (1998) *Монгол хэлний үгийн сангийн найруулга*. Улаанбаатар.
- Өлзийхутаг Ц. (1968) *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар.
- Пагва Т. (1959) *Хэлний шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар.
- Ринчен Б. (1967) *Монгол бичгийн хэлний зүй. Өгүүлбэр зүй. дотгөөр дэвтэр*. Улаанбаатар.
- Ринчен Б. (1973) Монгол хэлний “на” гэдэг язгуур үгийн учир // *Studia Mongolia*, Т. I (а) Улаанбаатар.
- Самбуудорж О., Эрдэнэсүвд Л. (2002) *Монгол хэлний этгээд үг хэллэг, этгээд үг хэллэгийн толь*. Улаанбаатар.
- Сумьяабаатар Б. (1986) Ойролцоо үгс. *Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс*, Улаанбаатар.
- Сүхбаатар Ц. (1988) *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар.
- Тогоо. (1993, 1996) *Үгийн сангийн зүй, Орчин үеийн монгол хэл*, Хөх.
- Төмөрцэрэн Ж. (1964) *Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар.
- Үгсийн утгын ялгамж*. (ӨМИС-ийн монгол хэл, утга зохиолын салбарын Хэл заан судлах тасаг). (1977) Хар мөрөн.
- Энхбат. (2005) *Үгсийн сангийн зүй. Одоо үеийн монгол хэл*, Хөх.

Гадаад хэлээр:

- Апресян Ю.Д. (1957) Проблема синонима // *Вопросы языкознания*, №6, Москва.
- Апресян Ю.Д. (1969) Синонимия и синонимы // *Вопросы языкознания*, №4. Москва.
- Апресян Ю.Д. (1974) *Лексическая семантика. Синонимические средства языка*. Москва.
- Апресян Ю.Д. (1974) О некоторых дискуссионных вопросах теории семантики (ответ Н.Ю.Шведовой) // *Вопросы языкознания*, №1, Москва.
- Апресян Ю.Д. (1988) *Англо-русский синонимический словарь*. Москва.
- Апресян Ю.Д. (Первый выпуск, 1999, Второй выпуск, 2000) *Новый объяснительный словарь синонимов русского языка*. Москва.
- Арутюнова Н.Д. (1982) Лингвистические проблемы // *Новое в зарубежной лингвистике*. Вып. XIII. Логика и лингвистика. (Проблемы референции), Москва.

- Арутюнова Н.Д. (1990) Референция. *Лингвистический энциклопедический словарь*. Москва.
- Ахманова О.С. (1957) *Очерки по общей и русской лексикологии*. Москва.
- Ахманова О.С. (1966) *Словарь лингвистических терминов*. Москва.
- Балли Ш. (1951) *Французская стилистика*. Москва.
- Бережан С.Г. (1973) *Семантическая эквивалентность лексических единиц*. Кишинев.
- Бертагаев Т.А., Цыдендамбаев Ц.Б. (1962) *Грамматика бурятского языка. Синтаксис*. Москва.
- Бертагаев Т.А. (1969) *Морфологическая структура слова в монгольских языках*. Москва.
- Бертагаев Т.А. (1971) *Сочетания слов и современная терминология*. Москва.
- Бертагаев Т.А. (1974) *Лексика современных монгольских литературных языков*. Москва.
- Брагина А.А. (1986) *Синонимы в литературном языке*. Москва.
- Будагов Р.А. (1960) *Введение в науку о языке*. Москва.
- Будагов Р.А. (1965) *Введение в науку о языке*. Москва.
- Васильев Л.М. (1990) *Современная лингвистическая семантика*. Москва.
- Винокур Г.О. (1929) Проблемы культуры речи. *Русский язык в советской школе*, №5. Москва.
- Вишнякова О.В. (1987) *Паронимия в русском языке*. Москва.
- Гречко В.А. (2003) *Теория языкознания*. Москва.
- Гумбольдт В. (1964) О различии строения человеческих языков и его влиянии на духовное развитие человеческого рода, в кн: В.А. Звегинцев. *История языкознания XIX-XX веков в очерках и извлечениях*, ч.1. Москва.
- Дугаров Н.Б. (1978) *Лексические синонимы в современном бурятском литературном языке*. Москва.
- Евгеньева А.П. (1966) Основные вопросы лексической синонимии. *Очерки по синонимике современного русского литературного языка*, Москва.
- Евгеньева А.П. (1970) Синонимы русского языка. *Словарь синонимов русского языка*, Том I, Ленинград.
- Ельмслев Луй. (1960) *Прологомены к теории языка*. Москва.
- Емельянова О.Н. (2003) Синонимы. *Стилистический энциклопедический словарь русского языка*, Москва.
- Ефимов А.И. (1969) *Стилистика русского языка*. Москва.
- Земская Е.А. (1973) *Современный русский язык. Словообразование*. Москва.
- Звегинцев В.А. (1963) Замечания о лексической синонимии, *Вопросы теории и истории языка*, Ленинград.
- Ивин А.А. (2000) *Логика*. Москва.
- Кобозева И.М. (2000) *Лингвистическая семантика*. Москва.
- Косовский Б.И. (1974) *Общее языкознание. Учение о слове и словарной составе языка*. Минск.
- Кронгауз М.А. (2005) *Семантика*. Москва.
- Кубрякова Е.С. (1990) Ономазиология. *Лингвистический энциклопедический словарь*, Москва.
- Лагутина А.В. (1967) Абсолютные синонимы в синонимической системе языка. *Лексическая синонимия*, Москва.

- Лазарева О.А. (2003) Тарономы-слова, которые смешиваются в употреблении. *Лингвистика, методика и культурология в преподавании*, Санкт Петербург.
- Лайонз Д. (1999) *Введение в теоретическую лингвистику*. Благовещенск.
- Мельчук И.А. (1974) *Опыт теории лингвистических моделей "Смысл ↔ Текст" (Семантика, синтаксис)*, Москва.
- Новиков Л.А. (1982) *Семантика русского языка*. Москва.
- Новиков Л.А. (1990) *Синонимия. Лингвистический энциклопедический словарь*. Москва.
- Павлов Т.Н. (2007) Разновременная словообразовательная синонимия в древнерусских житиях. *Системное и асистемное в языке и речи*. (Материалы международной научной конференций. Иркутск, 10-13 сентября 2000 года). Иркутск.
- Плотников Б.А. (1983) *Лексикология. Общее языкознание*. Минск.
- Прокопчик О.Д. (2005) *Семантические механизмы и прагматические функции паронимии*. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Санкт Петербург.
- Пюрбеев Г.Ц. (1979) *Типы сложных предложений в монгольских языках*. Москва.
- Реформатский А.А. (1955) *Введение в языкознание*. Москва.
- Реформатский А.А. (1967) *Введение в языкознание*. Москва.
- Розенталь Д.Э., (1985) Теленкова М.А. *Словарь-справочник лингвистических терминов*. Москва.
- В.Л.Силин. (1987) К проблеме синонимии. *Вопросы языкознания*, №4, Москва.
- Степанов Ю.С. (1975) *Основы общего языкознания*. Москва.
- Томашевский Б.В. (1959) *Стилистика и стихосложение*. Ленинград.
- Ульман С. (1962) *Дескриптивная семантика и лингвистическая типология. Новое в лингвистике*. Вып. II. Москва.
- Ульман С. (1970) *Семантические универсалии. Новое в лингвистике*, Вып. V. (Языковые универсалии). Москва.
- Уфимцева А.А. (1968) *Слово в лексико-семантической системе языка*. Москва.
- Фомина М.И. (1983) *Современный русский язык. Лексикология*. Москва.
- Чешко Л.А. (1986) О синонимах и словаре синонимов русского языка. *З.Е.Александрова. Словарь синонимов русского языка*, Москва.
- Шанский М.Н. (1972) *Лексикология современного русского языка*. Москва.
- Шведова Н.Ю. (1970) Несколько замечаний по поводу статьи Ю.Д.Апресяна *Синонимия и синонимы*, *Вопросы языкознания*. №3, Москва.
- Шмелев Д.Н. (1977) *Современный русский язык. Лексика*, Москва.
- Ramstedt G.J. (1935) *Kalmьckisches wьrterbuch*. Helsinki.

РЕЗЮМЕ

В данной статье мы сделали попытку выяснить значения синонимов в монгольском языке со стороны сигматики и прагматики, языка и речи.

В ономазиологии или сигматике сокращённо говоря, изучаются вещи, окружающие нас, их признаки и движения. Если одну вещь называют разными словами с адекватным значением, то можно отнести их к реальным абсолютным

синонимам. Например: шүүр (веник) = шаам (веник), зарлага (курьер) = тахар (вестовой для посылок и прислуживания при княжеском управлении), мебель = тавилга, подвал = хонгил. И так иностранные и диалектные слова, архаизмы образуют реальные абсолютные синонимы.

В семасиологии или языке (language) для обозначения одного понятия употребляются разные термины с адекватным значением. Это можно назвать абстрактным, абсолютным синонимом. Например: эр бөднө = хулжуухай (перепел тоор = бүглэс = бимба (персик), бааз = суурь (базис), үндэс = үндэслэл = үндэслэгээ (основа, основание, обоснование)

По мнению авторов, с ономасиологической точки зрения, однокоренные паронимы с прямым значением и относящиеся к одной части речи, имеющие одинаковую актантную структуру целесообразно считать точными синонимами. Например: тэс- = тэсвэрлэ- (терпеть, выдерживать, сносить) тэсвэр = тэсвэрлэл (терпение, выносливость); цагийн хатууг тэс- (преодолеть трудности), архи тамхийг тэс- (отказаться от курения и спиртных напитков), зовохыг тэс- (терпеть мучение). Но если заменим слово “тэс-” (терпеть), тэсвэр (терпение) словом “тэвч-” (воздерживаться), тэвчээр (выдержка) то они с точки зрения семасиологии станут точными синонимами. Именно такого мнения придерживался учёный Ю.Д.Апресян.

Со стороны речи (parole) значение слов, несовпадающее по значению нейтрализуясь в потоке речи, становится синонимичным. Хотя парные слова “хөнгөн ичингэн” несовпадают по лексическому значению, нейтрализуются по семи “подвижности” считаются синонимичными. В парном слове “нохор сүүдэр” в результате того, что слово “нохор” (друг) уподобляется слову “тень” и образуется синоним речи с одинаковым значением “нохор” (друг). Такая семантическая трансформация связана с тропом для выражения новых значений и с его различными способами.

Со стороны прагматики, синонимы дифференцируются стилистической характеристикой слов и содержат в себе эмоционально-экспрессивные чувства и оценки говорящего. Слово “ойр дотно” (близкий) относится к нейральному стилю, а слово “шадар” (поблизости, близкий) –к повышенному. В отличие от предыдущего, арго “хам” (соучастник, сателлит) следует отнести к сниженному стилю. Кроме вышеназванного есть и другие синонимы, которые отличаются коннотацией, как например: ээнэг (близкий), ээл (дорогой), элсэг (ласковый), элэгсэг (благосклонный), ээлдэг (вежливый), янаг (любимый), онгог (родной), сүнс (любящий).

В статике языка синонимы отличаются денотацией и сигнификацией а, в динамике – стилистическим и тропическим употреблением (Об этом смотрите на вышеуказанной схеме). Надо различать синонимы от вариантов слов и словообразовательной деривации, правильно установить взаимоотношение между синонимами и паронимами.

**МОНГОЛ ХЭЛНИЙ ЕРӨӨЛ БЭЛГЭ, ХАРААЛ ЗҮХЭЛ
ҮГИЙН УТГА СУДЛАЛЫН АСУУДАЛД**

Ж. Бат-Ирээдүй*

Удиртгал

Монгол хэлний үгийн сангийн найруулгын зүйлийг ажиглавал олон зуун жилийн монголчуудын соёл, сэтгэхүй, сэтгэлгээний хөгжлийн үр дүнд бий болсон олон зүйлийн үг хэллэг байх бөгөөд үүнийг өдий болтол тэр бүр тухайлан нарийн судалсан нь үгүй байна. Бид 2009 онд хэвлүүлсэн “Монгол хэлний ерөөл бэлгэ, хараал зүхэл үгийн сан” хэмээх бэсрэг номд орсон баримт хэрэглэгдэхүүндээ тулгуурлан энэхүү ерөөл бэлгэ, хараал зүхэл үгийн утгын судлалын талаарх өчүүхэн үгүүлэлийг бичив.

Монгол хэлний үгийн сангийн энэхүү үг хэллэгүүд нь үгийн сан, утга судлал, найруулгазүйн заагт бүрэлдэн бий болж улмаар шигшигдэн хэрэглэгдэж байдаг бөгөөд утга зүйн хувьд нарийвчлан авч судлуштай сонин үзэгдэл билээ. Монгол хэлний ерөөл бэлгэ, хараал зүхлийн үгийг судлах нь монгол хэлний нийгэм хэлшинжлэл, сэтгэц хэл шинжлэл, цаашилбал хэл-нийгэм, хэл-ухамсар, хэл-соёлын холбоог танин мэдэхэд чухал холбоотой билээ.

Ерөөл бэлгийн үг бол бэлгэдлийн үндсэн санаан дээр биеждэг нэгэн төрөл бодит тэмдгийн зүйл болой. Бэлгэдэл гэж юу болохыг профессор С.Дулам “... бэлгэдэл гэдэг бол бүх орчлон ертөнцийн өөр хоорондоо харилцах түгээмэл хэл, хэлмэр дохио мөн”, “дэлхийн янз бүрийн улс үндэстний өөр хоорондоо харилцах үндэсний хэлнүүд гэж байдаг бол нүдэнд үзэгдэх, үл үзэгдэх, амьтай, амьгүй, хийсвэр бодтой, хүний санаа саванд төсөөлөгдөж болох хийгээд одоогоор төсөөлж мэдрэлгүй бусад олон ертөнцийн өөр хоорондоо хэл холбоо барьж болох гагц хэл нь бэлгэдэл мөн болой. Хүмүүн төрөлхтөний хувьд бол тэдний хөгжлийн охь манлай соёл иргэншилүүд, соёл иргэншилүүдийн хөгжлийн охь манлай нь бэлгэдэл” (Дулам:2007:6) хэмээн томъёолжээ.

Бид энэ удаагийн үгүүлэлдээ монгол хэлний ерөөл бэлгийн үг, хараал зүхлийн үгийг харгалдуулан авч үзлээ. Учир нь энэ хоёр бол утгын хувьд, хэрэглээний хувьд аль ч утгаараа эсрэгцэж таарах бөгөөд хамтад нь авч үзвээс бие биеэ илүү тодруулах нигууртай хэмээн ойлгож байна. Энэ нь ардын бэлгэдэл сэтгэлгээний үүднээс үзвэл “Амны бэлгээс ашдын бэлгэ”, “Ерөөлийн үзүүрт тос, хараалын үзүүрт ус”, “Уурлавал уушиг гэмтэнэ, хүлцэлбэл хэнхэг тэнийнэ”, “Үг сөрвөл хэрүүл, үүл сөрвөл бороо”, “Үгээр хүнийг амьлуулж болно, үгээр хүнийг алж болно” гэдэг ардын үзэлтэй таарна, “Гүн ухааны үүднээс үзвэл, “эсрэг тэсрэг чанар нь зорчлийн хөгжих тодорхой үе шатыг илэрхийлсэн категори юм. Аливаа юм үзэгдэл, тал хэсгүүд нь бие биеийг үгүйсгэх арилгах явдлаар холбогдож байгаа үедээ л бие биедээ эсрэг тэсрэг чанар болно” (Философийн толь:1984:562) гэж тодорхойлж болно.

* ШУ-ны доктор, профессор

Ийнхүү ерөөл бэлгийг хараал зүхлээр харшуулан үзүүлэх нь үзэгдэл бүрийн өөр өөрийн өнгийг ялгаруулахаас гадна үзэгдэл хоорондын эсрэг шинж чанарыг улам тод томруун харуулж түүнийг ойлгох боломж олгоно гэж үзсэний үндсэн дээр нэг талбай, нэг орон зайд эсрэгцүүлэн судлахыг оролдов.

Нэг. Ерөөл бэлгийн үгийн утга, бүтэц, найруулгын асуудалд

Монголчууд далай баян ерөөлтэй, бэлгэ дэмбэрэлийн үг хэллэгтэй ард түмэн. Бэлгэ дэмбэрэлийн үг гэж бүр аман зохиолын тусгай үзэгдэл байгаа. Монгол хэлний ерөөл бэлгийн үг бол бэлгэдлийн утгыг илэрхийлдэг учраас дандаа сайн сайхан, болж бүтэх зүйлийг бэлгэдэн ерөөж байдгаараа бусад үг хэллэгээс ялгаатай. Ерөөл бэлгийн үгийг судлаачид бэлгэ дэмбэрэлийн үг, ерөөл үг, бэлгэ үг, ерөөл бэлгийн үг зэрэг хэд хэдэн янзаар нэрлэж ирсэн байна. Бид дээрх номд орсноор *“ерөөл бэлгийн үг”* гэдэг нэр томъёог энэ үгүүллэгт сонгон хэрэглэлээ.

Монгол ерөөл бэлгийн үг гэж чухам юу болох тухай эрдэмтэн Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном нар *“Ардын бэлэг дэмбэрэлийн үг нь ерөөлийн хамгийн богино хэлбэрийн төрөл зүйл болно. Бэлэг дэмбэрэлийн үгийг эрдэмтэн мэргэд тусхайлан судласан зүйл үгүй байна.”* (Гаадамба:1978:126), *“бэлэг дэмбэрэлийн үг нь гарал үүслээрээ мөн л үгийн ид шид, хүчин чадлаар хүнд хүч нэмж ажил үйлсийг нь өөдрөг бүтэмжтэй байхыг ерөөсөн яруу найргийн жижиг төрөл зүйл юм.”* (Цэрэнсодном:2011:39), гэсэн бол профессор С.Дулам, *“Монгол аман зохиолын төрөл зүйлүүд зан аалийн болон бэлгэдэлт шинжтэй байдгийг тодорхойгоо харуулах нэгэн зүйл нь бэлгэ дэмбэрэлийн үгс буюу бэлгэ үгс юм. Монгол хүний хэлдэг уламжлалт бэлгэ дэмбэрэлийн үгс нь “амны бэлгээс ашдын бэлгэ”, “ам алдуурснаас ашдын бэлгэ хазайх” хэмээн үздэг бэлгэдлийн сэтгэлгээнээс нь үүдэлтэй аман зохиолын онцлог зүйл болно. Энэ бол монгол хүний оюун сэтгэлгээний салгаж болиггүй өвөрмоц онцлог, монгол утга соёлыг бусад утга соёлоос ялгаруулах шинж...”* (Галсан:2009:2) хэмээн бичжээ.

Монгол ерөөл бэлгийн үгийг зөвхөн аман зохиолын санд уламжлагдаж ирсэн тодорхой хэдэн үг хэллэгээр хязгаарлаж болохгүй бөгөөд хүний ухаан сэтгэлийн хүчээр өдөр өдрөөр төлжиж, үйлээ даган үржин дэлгэрч, амьдралаас урган гарч хөгжиж байх учиртай. Үүний жишээ нь монгол ерөөл бэлгэ үгийн бүхэл бүтэн хоёр ботийг *“сурвалжлан цуглуулж, сэлбэн сэтгэж”* тусхайлан зохиож бэлэглэн барьсан бүтээл юм. Тухайлбал, Ардын уран зохиолч Тангадын Галсан *“Бэлгэ үг”* тэргүүн болон дэд боть зохиолоо 2009 онд Улаанбаатар хотод хэвлүүлсэн нь үүний гэрч билээ.

Монгол хэлний ерөөл бэлгийн үгийн утгын талаар бичиж хэвлүүлсэн зүйл ховордуухан байдаг. Ерөөл бэлгийн үг гэдэг нь ерөөсөө л сайн сайхныг ерөөн бэлгэдсэн эерэг утгатай үг хэллэг юм. Энэхүү ерөөх утгыг үзүүлж байгаа гол зүйл бол сайн сайхны утгат үг, ерөөх утгат нөхцөл болой. Үүний үр дүнд ерөөл бэлгийн утгат үг үүснэ. Ерөөл бэлгийн үгийг ерөнхийд нь байгальд хандсан, хүнд хандсан гэж хоёр хувааж болмоор байна. Хүнд хандсан ерөөл бэлгийн үг дийлэнхи хувийг эзлэнэ. Тухайлбал байгальд хандсан нь есөн ес наян нэгэн тэнгэр өршөө, овооны их танд, хүнд хандсан нь бат орших болтугай, бурхан өршөөг, зуу наслал, өндөр болоорой, насаа нэм, заяа нь дэлгэр, урт наслал, удаан жарга гэх мэт.

Ерөөл бэлгийн үгийн утгыг судласан ихэнхи судлаачид ерөөл бэлгийн үг, хэллэгийг баймжийн айд хамруулан судалж ирсэн буй. Тухайлбал, Д-р Ю.Мөнх-Амгалан, монгол хэлний ерөөл бэлгийн үгийг нэмэлт баймж утгын бүлэгт бүр цаашилбал *“өгүүлэгчийн эерэг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж”* утгад

хамруулан үзжээ. Энэ нэмэлт баймж нь “...бодит байдалд холбогдох өгүүлэмжийн агуулгын харьцаа бодит шинжтэй байдаг бол уг өгүүлэмжийн агуулгад өгүүлэгчээс хандах үнэлэмжийн харьцаа нь нэмэлт юм уу аль эсвэл хийсвэр маягтай...” байдгийг онцлоод ерөөх утга “... нь өгүүлэгчийн гадагш хандсан эерэг сэтгэлийн байдал илтгэж харилцагч этгээдэд сайн сайхан, өөдрөг бэлгэтэй зүйл хүсэн илэрхийлдэг.” (Мөнх-Амгалан:1998:237) гэжээ.

Д-р Д.Бадамдорж ерөөл үг гэдэг нэр томьёо хэрэглээд, ерөөл үг гэдгээ “сайн сайхан ерөөлийг айлтгасан утганцартай үг хэллэг”, “үг тус бүрийн утгаар биш нийт үгийн утга санаагаар бэлгэ дэмбэрэлийн үгийн утгыг тодорхойлбол,” хэмээн нүүдэлчин аж ахуй, амьдралыг өөдрөг бай хэмээн ерөөсөн утгатай, таван хошуу малаа өсгөж ашиг шимийг арвитгах утга агуулгатай, аз жаргал сайн сайхныг ерөөсөн, (Бадамдорж: 2006:278) хэмээн үндсэн гурван бүлэгт хувааж үзсэн байна.

Монгол хэлний ерөөл бэлгийн үгийн үгийн сангийн үндсэн бүрэлдүүлбэр болсон үгийг авч үзвэл алт, ачлал, аялгуу эгшиг, арвин, ах зах, баатар, бат, баян, буман, бурхан, буян, буянтай, дардан, дүүрэн, дэвжээ, дээж, ерөөл, ерэн ес, заяа, зөөлөн, зуу, их, лус, мөнх, манлай, мянга, мяндас, навч, найр, найр хөөр, нар, нас, ная, од, олз, өглөг, өлзий, өлмий, өн, өнгөлөг, өндөр, өнөр, өнтэй, өргөө, өргөн, савдаг, сайн, сайхан, сүлд, тавин тав, торго, тос, тэгш, тэнгэр, удаан, түмэн, унага даага, уран, урт, үйлс, хамба, хайр, хатуу, хийморь, хонь хурга, хурц, хурц, цагаан, цог, цуу, шандас, элбэрэл, эрдэнэ, зэрэг нэр, тэмдэг, тооны үг, аврах, баяжих, баясгах, дарах, дэлгэрэх, жаргах, ивээх, мандах, наслах, нэмэх, орших, өршөөх, өсгөх, сунгах, тахих, түших, хураах, хүндлэх, хүндлэгдэх, энэрэх, эрхшээх зэрэг сайн сайхан, хүндэтгэл, дээдлэл, бэлгэдэлийн утгат үйл үг өргөн хэрэглэгдэж байгаа нь ерөөл бэлгийн үгийн нэг онцлог юм.

Харин муу муухайн утгатай үг хэллэг хэрэглэсэн тохиолдолд үгүйсгэх утгатай үг болон нөхцөл хэрэглэж бэлгэлдэг байна. Жишээ нь, “гар нь **бүү** ядар, гарах нь **бүү** багас”, “**бууриггүй** буянтай, **саариггүй** сантай яв” гэх мэт.

Мөн монгол хэлний ерөөл бэлгийн үг, хэллэг нь үгийн үндсээр төгссөн байж болно. Тухайлбал, өлмий бат орш, тосоор гоож, заяа нь дэлгэр, бурхан өршөө, буянаар бол, зуу насла, олз ор, чих алт бол гэх мэт.

Ерөөл бэлгийн үгийн бүтэц бүрэлдэхүүнд багтах үгээс гадна түүний утгыг ерөөх бэлгэдэх утга руу шилжүүлж хувиргаж байдаг нэг зүйл бол яах аргагүй нөхцөл мөн.

Ерөөл бэлгийн үгийн нөхцлийн хэрэглээг ажиглавал энэ үгс ихэнхи тохиолдолд, үйл үгийн биеэр төгсгөх нөхцлийн ерөөн хүсэх утгат –**тугай**, –**түгэй**, зөвшин хүсэх утгат –**г**, зөвлөн захирах утгат –**аарай**⁴, зэрэг нөхцлийг ашиглахаас гадна үйл үгийн үндэс, зарим баймж утгат үгээр төгсөх нь элбэг байна. Жишээлбэл, бол, багас, гоож, ор, өршөө, нэм, яв, түшиг, бол**тугай**, болог, байг, оршиг, өршөөг, наслаг, наслатугай, яв **даа**, бол гэм, болоорой, жаргаарай, жаргатугай, яваарай, наслаарай, оршиг **доо**, хураагаарай, **гэх** мэт. Ингэж үзвэл ерөөл бэлгийн үг нь сайн утгат үгийн үндэс болон ерөөх бэлгэшээх утга илэрхийлэх нөхцлийн “хамтын буюу нийлмэл бүтээл” бөгөөд үг болон нөхцөл дангаараа ерөөл бэлгийн үгийг бүтээх чадамжгүй болох нь тодорхой байна. Энэ нь “үсэг хурааж нэр болох. Нэр хурааж үг болох. Үсгээр утгыг үзүүл бөлгөө. Утгыг үзүүлэх тэр цагт нөхцөл хэрэгтэй болай” (Данзандагва:1983:11) хэмээх эрдэмтэн Данзандагвын гүн утгат үгийн агуулгатай дүйж байна.

Дээрх нөхцлийн утгыг тайлбарласан эрдэмтэд ч ерөөл дэмбэрэлийн утга илэрхийлдэг болохыг зохиол бүтээлдээ дурдсан. Тухайлбал, проф. Ц.Өнөрбаян, “зөвлөн захирах – **аарай**⁴ нөхцөл хэлэх зорилго, аялга, сэтгэлийн хөдөлгөөн зэргээс шалтгаалж шаардах,

даалгах, уриалах, зөвшөөрөх, хориглох, **ерөөх** зэрэг нэмэлт утга илтгээж болно.”. зөвшин хүсэх утгат –г нөхцлийг “ялангуяа **бэлгэ дэмбэрэлийн үг хэллэгт ерөөх ба бэлгэшээн хүсэх** утга илрэх нь олонтоо байдаг.” гэсэн бол “**ерөөн хүсэх –тугай, –түгэй** нөхцөл бол тухайн үйл хөдлөлийг гуравдугаар бие гүйцэтгэхийг өгүүлдэгч этгээд **ерөөх ба бэлгэдэн хүсэх баймж утга илтгэнэ.**” (ОЦМХ:2004:172-173) гэжээ.

Ерөөл бэлгийн үгийн бүтцэд хамгийн их орж адилтгалын аргаар ерөөл бэлгэт утга бүтээдэг **адил, мэт, чинээ, шиг**, гэх мэт дагавар олон бий. Жишээлбэл, **адил** – наран адил $\approx$ гэрэлтэй, навчин адил $\approx$ дэлгэрэх, **мэт** – азаргын саарь мэт $\approx$ хатуу, бат, бухын магнай мэт $\approx$ хатуу, бөх, гүехэн мэт, намхан мэт, он мэт $\approx$ тэгш, од мэт $\approx$ гэрэлтэй, төмөр мэт $\approx$ бэрх, хад мэт $\approx$ их, хайрга мэт $\approx$ их, олон, **чинээ** – дэлхийн чинээ $\approx$ их, уулын чинээ $\approx$ их, **шиг** – дун шиг $\approx$ хатуу, дурдан шиг $\approx$ артай, дэлбээ шиг $\approx$ цэцэглэх, мөндөл шиг $\approx$ олон, мөчир шиг $\approx$ дэлгэрэх, өглөөний нар шиг $\approx$ мандах, өндөр хангайн цэцэг шиг $\approx$ дэлгэрэх, хун шиг $\approx$ цагаан, цас шиг $\approx$ цагаан, гэх мэт. Зарим тохиолдолд тэмдэг нэрийн ахиулах зэргээр бэлгэдэн үзүүлэх утга илтгэнэ. Жишээ нь, “яснаас хатуу, цаснаас цагаан”, гэх мэт.

Монгол утга зохиолын төрөл бүрийн найруулгад тэр дундаа уран зохиолын найруулгад ерөөл бэлгийн үг арвин хэрэглэгдэж байна. Жишээлбэл, **өндөр болох**, “Тэрбиш идээ цайг аваад бяцхан хар ширгуулганыхаа нүд татан охинд хоёр ширхэг цаастай чихэр авч өгөөд. - **За өндөөр болоорой** гэвэл охин -**За гээд чихрийг хоёр гардан авлаа.**” (Б.Бааст, “Хаш аяга”), **тосоор гоожих**, “За яахав дээ, хүүхээ. Шар өдөр бор хоног түлхэж л сууна. **Тосоор гоож.**” (З.Дорж, “Эрдэнэ засгийн унага”).

Нэг үгүүлбэрт хэд хэдэн ерөөл бэлгийн үг дараалан орж болно. Жишээлбэл, “- Нэхийнүрэвийн минь **аян зам өлзийтэй болтугай. Тэнгэр заяа нь өршөөг! Үйлс нь дэлгэрч яваг!** хэмээн хэдэнтээ давтан зүүн зүгт цацал сүү өргөөд хэн нэгэн хүний төлөө анх удаа залбирч байгаадаа сэтгэл нь их хөдөлжээ.” (Д.Намсрай, “Бор галуутайн талд”),

Бэлгэ дэмбэрэлийн үг нь зарим тохиолдолд нийлмэл үгүүлбэрээр байж болно. Тухайлбал, “Бурхан өршөө, буянтай айлын бэр бол”, “Арван цагаан буян чинь дэлгэрч яв, ах дүү олондоо хүндлэгдэж яв”, “овооны их танд, олзны их манд”, “төрийн сүлд өршөөж, түмний заяа түшиг”, “урд хормойноос нь унага даага, хойд хормойноос нь хонь хурга”, “урт наслах, удаан жаргах”, “хайч нь хурц, ахар нь арвин” гэх мэт. Энэхүү нийлмэл үгүүлбэрээр байх бэлгэ дэмбэрэлийн үг хэллэгийг утга зохиолын жишээнээс олж үзбэл, “Уул нь Богд маань дааж байгаа цэрэг юм гэдэг шүү хөөрхий. Хүүгий минь **төрийн сүлд өршөөж, түмний заяа түшиг.** Баруун хацрыг чинь үнсье. Ирэхэд чинь аав нь зүүн хацрыг чинь үнсэнэ гээд хүүгийнхээ баруун хацрыг үнэрлэн үнслээ.” (Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”), “Бат: - **Арван цагаан буян чинь дэлгэрч яв, ах дүү олондоо хүндлэгдэж яв даа.** Давст: - Нэмүүлнэ үү, дахиад авах уу? Бат: - Болно, болно.” (Ч.Ойдов, “Далан худалч”), гэх мэт болой.

Хоёр. Хараал зүхлийн үгийн утга, бүтэц найруулгын асуудалд

Хараал зүхлийн үг бол ерөөл бэлгийн үгийн эсрэг утгатай үг хэллэг гэж ойлгож болно. Чухам ийм учраас бид нэг номд хамт оруулж, нэг үгүүлэлд хамт үзэх болсон тухайгаа өмнөх хэсэгт дурдсан билээ.

Монгол хараал зүхэл үгийг судлаачид бүдүүлэг болон этгээд үг хэллэгийн бүлэгт багтааж хараал зүхлийн үг, хараал зүхэл үг, бүдүүлэг үг гэх мэтээр нэрлэж иржээ. Тухайлбал, эрдэмтэн О.Самбуудорж, “... этгээд үг хэллэгийн найруулгын өнгө бүдүүлэг,

хараалын, дорд үзсэн, басамжилсан, үл тоосон, шоолсон, дотночилсон, зөрүүлсэн, тохуурхсан, хүний сэтгэл хөдлөл болон сэтгэлийн мэдрэмжийг хурцаар тусгадаг байна.” (Самбуудорж:2002:50) гэжээ.

Хараал зүхлийн үг гэж юу болох талаар эрдэмтэд мөн тодорхойлсоор иржээ. Академич Д.Цэрэнсодном “Хараал зүхлийн үг нь дом шивилэгийн нэгэн адил хүн төрөлхтөний үгийн “ид шидэд” итгээж биширч байсан эрт балар цагт үүссэн ажээ.” (Цэрэнсодном:2011:35), хэмээн үзжээ.

Монгол хэлний баймжийн айт судлаач Ю.Мөнх-Амгалан, монгол хэлний хараал зүхэл үгийг “хараах утга”-д хамруулан өгүүлэгчийн сөрөг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж утгын айд харьяалуулж, “энэ нь өгүүлэгчийн гадагш хандсан сөрөг сэтгэлийн байдал итгээж харилцагч этгээдэд хүйтэн цөвдгээр хандан түүнийг зүхэн доромжилсон агуулгатай байдаг. Монгол хэлний хараалын үг хэллэг, бүдүүлэг үг хэллэг, этгээд үг хэллэг, завхай үг хэллэг зэрэг нь ерөнхийдөө эл утга илэрхийлдэг” (Мөнх-Амгалан:1998:251) гэсэн байна.

Зарим судлаачид хараал зүхлийн үгийг бүдүүлэг үг хэллэг гэдэг бүлэгт оруулдаг.

Хараал зүхлийн үгийг д-р Д.Бадамдорж бүдүүлэг үгэнд хамруулан үзэхдээ хоч үг, завхай үг, хараал үг, уулга алдах үг, гэж дөрөв хуваасан байна. Тэрбээр, “бүдүүлэг үг гэдэг бол хэлний аливаа хэл найруулгад хязгаартай, сэтгэл хөдлөлийн сөрөг утга санааг нэвтрүүлэр, ёс бусын утганцартай үг хэллэг юм. Хүний муу үйлийн үр, сэтгэл санааны тавгүй, урам хугарсан үе, ичих мэдрэмжийг төрүүлдэг цөөн бөлөг үгсийг утга судлалд ор тас орхигдуулж болохгүй юм. Тийм үгс нь нийтийн хэрэглээний бус боловч хүний зан суртахууныг байгаа байдлаар нь дүрслэх шаардлагаас тэрс утганцрыг ашиглах болдог байна. Бүдүүлэг үгийг утгын талаас нь хоч үг, завхай үг, хараал үг, уулга алдах үг гэх зэргээр зааглаж болно.” (Бадамдорж:2006:300) гэжээ. Хараал зүхэл үгийн ид шид, үг хэллэгийн нөлөөний талаар эрдэмтэд зарим судалгааны зохиолд дурдаж байна. Тухайлбал д-р Л.Чулуунбаатар, “Хараал зүхэл, ширүүн үг зэрэг нь хүний сэтгэлийг хямрааж, сөрөг энергийн орчинг бий болгож байдаг. Хэлний дөрвөн гэмд худал үг, хов хэлэх, ширүүн үг, чалчих ордог нь үүний баталгаа юм.” (Чулуунбаатар:2011:29) гэжээ.

Аливаа үгийн сангийн үзэгдэл тэр дундаа бэлгэ дэмбэрэлийн ба хараал зүхлийн үг хэллэгийн бүрэлдэхүүнийг авч үзвэл үнэхээр эсрэг тэсрэг байдалтай байх нь ажиглагдана. Монгол хэлний хараал зүхэл үгийн үгийн сангийн бүрэлдэхүүнийг дээрх номын жишээ баримтад тулгуурлан ажиглаж, авч үзвэл аалз, адаг, адгуус, адсага, баас, бузар, (нүдний) булай, гайхал, галзуу, гичий, гуйланчин, гуйранч, гуриа, дамшиг, дух, ёроол, жулдрай, заяагүй, зовлого, золиг, зөнөг, зулбасга, илжиг, лалар, луйварчин, лүд, маанаг, мал, моньд, моньш, муу, муусайн, новш, нохой, нөж, нусгай, нүгэлтэй, ороолон, өгөр, өлөгчин, өөдгүй, салга, сөлөр, там, тархи, туучий, тэнэг, үмхий, үхэр, үхээнц, үхээр, хар, хог, хомхой, хувалз, хувхай, хуухай, хүүр, цагаач, цус, цустай, чавганц, чөтгөр, шаар, шидэл, элэнцэг, эрваа, яатуу, янхан, зэрэг муу утгат нэр болон тэмдэг үг, алгадах, бөглөрөх, бузарлах, гашлах, долоох, донгосох, дөнгөлөх, задрах, залгих, золигтох, идэх, навсайх, салгалах, сэтрэх, үхэх, хатах, харлах, хахах, хутгах, хуцах, хэвтэх, цөмрөх, цуслах, чиргүүлэх зэрэг муу муухайн, бэлгэ дэмбэрэлгүйн, ёрлосон, зохисгүйн утгат үйл үг зонхилж байгаа нь уг үгийн илэрхийлэх утга, зорилгод “бүрэн нийцэж” байгаа нь харагдаж байна.

Хараал зүхэл үгийн бүтцийг авч үзвэл хараал зүхлийн үгийг бүтээх гол махбод нь муу утгат дээрх үгс бөгөөд эндээс нэрлэсэн хараал зүхэл үг, үйлийг ёрлосон хараал

зүхэл үг гэж хоёр ялгаж болохоор байна. Нэрлэсэн хараал зүхэл үг нь муу хар сөлөр, адгын шаар, адсага, хар тэнэг, босоо ороолон, гуйлагчин, гуйранч, галзуу солиг, саарал илжиг, дамшиг, жулдрай, зулбасга, задарсан тархи, муу новш, зальтай нохой, заяагүй амьтан, зөнөг толгойт, мал, моньш, гичий, луйварчин, муу нохой, хөсрий, цагаач, нурмайсан хог, үхэр монгол, хүний шаар, хүүр, шаар, туучий, яатуу, гэх мэт. Үйлийг ёрлосон хараал зүхэл үг нь дөрөөндөө чиргүүлж үх, нохой долоо, нохой долоож үх, цус нөжийг нь хутгах, үхсэн хатсанаа түүх гэх мэт.

Хараал зүхлийн үг хэллэгийн хувьд ерөөл бэлгийн үг шиг тэр бүр өөр хэлзүйн нөхцөл хэрэглэх нь ховор бөгөөд үгүүлэхүүн нь ихэвчлэн үгийн үндэс буюу тушаан захирах баймж хэлбэрээр төгсдөг нь энэ төрлийн үг хэллэгийн бас нэг онцлог юм. Жишээлбэл, *“битгий донгос, битгий хуц, дөрөөндөө чиргүүлж үх, нохой долоо, цусаар тээглэ, чөтгөр ав, үргэх малгүй, үнсэх үхгүй бол, тэгнэх тэмээ чинь үх, тэврэх эхнэр чинь үх, явган нүүж, нүцгэн жарга, даагаа дэлтэй нь ид, даллагаа сумтай нь хая, буураа зогдортой нь ид, бурханаа яндартай нь хая”* гэх мэт.

Мөн хараал зүхлийн үгэнд үйлийн биеэр төгсгөх нөхцлийн зөвшин хүсэх –г нөхцлийг хэрэглэх нь элбэг байна. Жишээлбэл, гишгэсэн газар чинь **цөмрөг**, нарны бараа бүү **үзэг**, хэл чинь **сугараг**, чих нь **бөглөрөг** гэх мэт.

Мөн үйл үгээс нэр үг бүтээх чадавхитай –мар⁴ дагаврыг түгээмэл ашигладаг байна. Жишээлбэл, буянаа **бармар**, хамарт нь хатиг **ургамар**, хамар нь **сэтэрмэр**, хэлээ **хазмар**, заяа нь **харламар/хаямар**, чих нь **бөглөрмөр**, нохой **идмэр**, толгой нь **гашламар**, цусаар **тээглэмэр**, чөтгөр **авмар** гэх мэт.

Хараал зүхлийн үгэнд сайн сайхан утгат үг хэрэглэхийн цагт үгүйсгэлийн нөхцөлүүдийг хэрэглэдэг болох нь ажиглагдлаа. Жишээлбэл, Амны хишиггүй, насандаа нарны бараа **бүү** үзэг, намартаа тарианы бараа **бүү** үзэг, өөрөө **бүү** сур, сурсан хүний үгэнд **бүү** ор, хоттой хониноос чинь чоно **битгий** сал, хотгор дүүрэн адуунаас чинь тахар **битгий** сал, хяр дээр гарах **хүнгүй**, хялгана хазах **малгүй** гэх мэт.

Хараал зүхэл үгийн утгыг авч үзвэл нүүдэлчин монголчуудын аж ахуйтай, байгаль орчин, шашин шүтлэгтэй холбоотой болох нь ажиглагдана. Тухайлбал хараал зүхлийн үгэнд мал аж ахуй, адгуус амьтантай холбоотой үг хэллэг арвин буй. Жишээлбэл, адсага (ганц адсага, задарсан адсага, гурван адсага), илжиг, зулбасга, хувалз, гичий, гуриа, өлөгчин, мал, моньш, нохой (нохой чи, нохой долоо, нохой долоож үх, нохой идмэр, нохойн хоол, муу нохой), сөлөр, умс, чөтгөр гэх мэт.

Хараал зүхлийн үгийг ажиглавал Монголын өргөн дэлгэр нутаг дэвсгэрт нутаг нутагт дэлгэрч түгсэн онцлог хараал зүхлийн үг хэллэг арвин байна. Тухайлбал, нэг аймагт цус, нөж-тэй холбоотой хараал зүхэл их байхад нөгөө аймагт хүүр, нохой-той холбоотой хараал зүхэл их байх жишээтэй.

Хэрэглээ, найруулгын талаас авч үзвэл хараал зүхлийн үгийн хэрэглээ тийм их өргөн дэлгэр биш албан бичгийн болон бусад найруулгад тэр бүр хэрэглэгддэггүй бөгөөд гагцхүү зохиолын баатрын дүрийг тодруулахад хэрэглэдэг үгийн сангийн үзэгдэл гэж үзэж болно. Монгол хүний хувьд өдөр тутмын яриа хөөрөөндөө хараал зүхэл үг нэлээд хэрэглэдэг. Энэ нь ихэнхи тохиолдолд өөр дээрээ хэрэглэдэг бас нэг онцлог юм. Энэ бол монгол хүний өөрийгөө бусдын өмнө буруушаах сэтгэлзүйн онцлогтой холбоотой бөгөөд өөрийгөө *“ээ өгөр тархи, тэнэг хог, буруу хойшоо, -хаа⁴ ч алд, харламар, өгөр гуйранч, ээ нүдний булай, ээ хог, нохой долоо, өө шившиг, хар тэнэг толгой, хийморио алд, ээ цус гэж”* гэх мэтийн өдөр тутмын хараал зүхлийн үгээс тодорхой байна.

Харин монгол ахуйдаа баттай суусан байдаг энэ нэг хэсэг үг хэллэгийг зөвхөн уран зохиолын найруулгад хэрэглэдэг гэж орхиж болохгүй бөгөөд нийгэм хэлшинжлэлийн үүднээс монгол хүний ахуй сэтгэлгээний онцлог шинжийг тодруулахад бас нэгэн чухал хүчин зүйл болох ёстой хэмээн үзэж байна. Хараал зүхэл үгийн найруулгын хэрэглээний талаар профессор Ц.Сүхбаатар *"Найруулгын бүдүүлэг үг хэллэг нь бухимдан уурласан, биеэ барьж чадаагүй үеийн ярианд байх бөгөөд бичиг зохиолын боловсронгуй найруулгад зохицомгүй. Гагцхүү уран зохиолын баатрын сэтгэлийн байдал, зан төрх, хэл ярианы онцлогийг гаргах зорилгоор хааяа хэрэглэдэг."* (Сүхбаатар:2009:330) хэмээн бичжээ.

Үнэхээр Монгол утга зохиолын найруулга тэр дундаа уран зохиолын төрөл бүрийн хэлбэрийг шүүрдэн үзвээс монголчуудын хэрэглэдэг хараал зүхлийн үг олныг олж болно. Эдгээр нь голдуу зохиолын баатрын зан төрхийг тодорхойлох, дүрийг тодруулахад л чиглэсэн байдаг нь зохиолын агуулгаас тодорхой байдаг. Жишээлбэл, *"Турав дахь хошууны нэг муу залангийн хэдэн адсаганы төлөө эд нар ингэж их юм болох учиргүй."* (Д.Маам,"Газар шороо"), *"Яндаг өвгөн - Ай хар тэнэгүүд ээ, дээгүүр шахахгүй яасан хар тэнэгүүд вэ? Муу сайн морь уруудаад тэр доодох улаан эрэгт хашигдвал яаж гарна гэж бодноо гэж тэсэж ядан байв."* (С.Эрдэнэ,"Гарам дээр"), *"Тэгнээ тэр, тийм амьтан Самбуу яаж тогтоох уу, - Амны хишиггүй золиг, муу Самбуу ч орноос нь шээх нь холгүй л байсан даа."* (Д.Батбаяр, "Хорсол"), *"Өмнө явсан хоёр морьтой хүний нэг нь - Сунтгийн нөгөө үзүүр нь Богдын эрх тогорууны хөлөөс уяатай байдаг юм гэсэн үнэн болов уу? гэхэд нөгөөдөх нь - Битгий донгос, дээдсийн мутарт байдаг юм гэнэ билээ, алдас болно гэлээ."* (Ч.Лодойдамба,"Тунгалаг Тамир"), *"Бөглүүлмэр чинь Өгий дээр ер санасангүй л дээ. Тэрнээс... байсан л байлгүй. Ээ мал гэж хэмээн өөрийгөө зүхлээ."* (Л.Дашням,"Бор еэвэн"), *"Хүүжий өөрийнхөө бодлоос өөрөө айж "Байтлаа энэ чинь Дарь эхтэй зэрэг булаалдах нь ээ. Буянаа бармар! Хөгийн Хүүжийн энэ бодлыг хүн мэдвэл яана?! Амьтны доог" гэж амандаа шивнэв."* (Д.Намсрай, "Бор галуутайн талд"), *Энэ хүний нэрийг ядуус сонсвол магнай тэнийж, манай нутгийн сайн эр гэгцээдэг, баяд сонсвол шазуур зууж 'дөнгөлмөөр тархи' гэгцээдэг ажээ."* (Л.Түдэв,"Уулын үер"), *"Шив шинээрээ тас үсэрдэг байна шүү. - Еэ өгөр гэж Цоодол үглэх зуур элэг бүсээ ахиулан зангидаж залгав."* (Д.Цэдэв,"Улаан хамбан зодог буюу тавын даваа"), *"Яана гэнээ, задарсан тархи? Ямар ч л гэсэн чиний буруу. Гурван зуун адуу, гутал, эмээл зэргийг түргэн цагийн дотор төлж барагдуул гээд л түшмэл задран тушааж гарчээ."* (С.Дашдэндэв, "Сувдан гутлын хэрэг") гэх мэтээр монголын утга зохиолоос арвин олныг олж болох бололцоотой.

Дүгнэхүй

Монгол хэлний ерөөл бэлгийн үг хэллэг, хараал зүхлийн үг хэллэгийг тэр бүр нарийн судлаагүй байгаа бөгөөд утга чанарын хувьд ерөнхийдөө эсрэгцсэн шинжтэй байна. Энэ нь түүний бүрэлдэхүүнд орж байгаа үгийн утгыг нягталбаас ил тодорхой болж байна.

Бүтцийн хувьд бэлгэ дэмбэрэлийн үг хэллэгт ихэнхидээ сайн сайхныг *"бэлгэдсэн утгатай үг хэллэг"* хэрэглэгддэг бол хараал зүхлийн үг, хэллэгт муу муухайг *"ёрлосон утгатай үг хэллэг"* их оролцож хэрэглэгддэг гэж үзэж болох юм.

Бүтцийн хувьд авч үзвэл тус тусын төгсгөх дагавар болон нөхцлийн хувьд бас онцлог ялгаатай байна. Ерөөл бэлгийн үг нь ихэнхи тохиолдол ерөөсөн бэлгэдсэн утгатай (-аарай⁴, -тугай, -г зэрэг) нөхцөл хэрэглэдэг бол хараал зүхлийн үг нь ихэнхидээ

захирсан, тушаасан хэлбэрт төгсөхөөс гадна зарим нэг онцлог нөхцөл (-мар, -г зэрэг) хэрэглэж байгаагаараа онцлогтой юм.

Ерөөл бэлгэ, хараал зүхлийн үг аль аль нь хүний өдөр тутмын амьдрал, яриа хөөрөөнд өргөн хэрэглээтэй, харин уран зохиолд зохиолын баатрын дүрийг тодруулах зорилгоор бичгийн хэлэнд мөн өргөн ашигладаг үгийн сангийн нэг үзэгдэл юм. Ерөөл бэлгэ, хараал зүхлийн үгийг зөвхөн аман зохиолын баримт хэрэглэгдэхүүнээс биш утга зохиолын төрөл бүрийн найруулга, амьд аман ярианаас олж болно.

Ийнхүү монгол хэлний ерөөл бэлгэ, хараал зүхэл үгийг бүтэц, утга, хэрэглээний талаас өнгөц боловч сөхөн үзвэл дээрх маягийн дотоод бүтэц, хэв шинж, ур маяг, утга санаатай байх бөгөөд цаашид соёлын хэлшинжлэл, сэтгэлгээний талаас, улам нарийсган үзэх шаардлагатай юм.

НОМЗҮЙ

1. Бадамдорж. Д. (2006) *Монгол хэлний үгийн сангийн утгазүй*, Улаанбаатар.
2. Бат-Ирээдүй.Ж. (2009) *Монгол хэлний ерөөл бэлгэ, хараал зүхэл үгийн сан*, Улаанбаатар.
3. Гаадамба Ш, Цэрэнсодном. Д. (1978) *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*, Улаанбаатар.
4. Галсан.Т. (2009) *Бэлгэ үг, тэргүүн боть*, Улаанбаатар.
5. “Зүрхэн тольтын тайлбар огторгуйн маань” (1983) (*Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг*) Хөх хот.
6. Дулам. С. (2007) *Монгол бэлгэдэл зүй I, тооны бэлгэдэл зүй, YIII боть*, Улаанбаатар.
7. Мөнх-Амгалан. Ю. (1998) *Орчин цагийн монгол хэлний баймжийн ай*, Улаанбаатар.
8. Орчин цагийн монгол хэл, (2004), Улаанбаатар.
9. Самбуудорж. О. (2002) *Монгол хэлний этгээд үг хэллэг, этгээд үг хэллэгийн товч толь*, Улаанбаатар.
10. Сүхбаатар.Ц. (2009) *Монгол хэлний найруулга зүй*, Улаанбаатар.
11. Цэрэнсодном Д. (2011), *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*, Улаанбаатар.
12. Чулуунбаатар. Л. Монгол үгийн энерги, *Acta Mongolica* // NUM, N11(366), 29-34 х.

РЕЗЮМЕ

В этой статье автором изучены "*Благопожелательные и бранные слова и выражения монгольского языка*" в антонимической оппозиции и затронуты их структурные, семантические, стилистические особенности и грамматические свойства. Благопожелательная и бранная лексика монгольского языка малоизучена в структурном, семантическом и стилистическом плане. Большинство исследователей изучали ее преимущественно в текстах фольклора. Эти "*Благопожелательные и бранные слова и выражения монгольского языка* равномерно употребляются в письменной и устной речи. Предшествующие исследователи изучали эти слова и выражения и сделали выводы опираясь на материалах и фактах традиционных устных народных творчеств, то автор данной статьи анализировал" Благопожелательные и бранные слова и выражения монгольского языка на обширных и общеупотребительных примерах, материалах, которые входили в книгу "*Фонд благопожелательных и бранных слов и выражений монгольского языка*" 2009, написанную самим автором. В этом заключается особенность настоящей статьи от других ранних.


МЕТАФОР БА ХЭЛНИЙ СОЁЛ СУДЛАЛ

Ж. Баянсан*

Соёлын тухай олон зуун тодорхойлолт гарсны зарим нь соёлыг биежсэн хөдөлмөртэй холбож, зарим нь хүний бүтээсэн эдийн болон оюуны үнэт зүйлсийн цогцолбор хэмээн тайлбарласан байна.

Соёл буюу *culture* (*культура*) гэдэг энэ үг нь латин хэлний *Colere* буюу анхны утга нь байгалийг хүн зориудаар хөндөж, өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн өөрчлөх буюу газар боловсруулах гэсэн утгаар хэрэглэж байсан үгээс гарал ирэлтэй ажээ.


Гэвч соёл бол хориглож цээрлэдэг, бас урьдаас дагаж мөрддөг зүйлс тодорхой тогтолцоо болон илэрч байдаг хамт олны өвлөмөл ой юм. Ийм учраас ажиллаж хөдөлмөрлөх арга барил, ёс суртал, зан заншил, харилцах онцлог, ертөнцийг үзэх үзэлт, ертөнцийг таньсан танилт, түүнийг хөндөн хувиргах арга үйлдэл бүхэн соёлд хамаатай бөгөөд зам харгуйд хаа сайгүй хэвтэж байдаг чулуу бол байгалийн нэг зүйл болохоос соёлын зүйл биш бол харин оршуулсан цогцсын тэргүүн талд зориуд тавьсан чулуу бол харин соёлын учир холбогдолтой болно (*Маслова 2001:12-13*) хэмээх үзэл ч байна.



Дээрх зурагт тасархай зураас нь эдийн соёлын зүйл бол бодот ертөнцийн нэг хэсэг, харин оюун билгийн соёл нь хийсвэр ертөнцийн нэг хэсэг буюу зүйл болно гэсэн санааны тэмдэглэгээ бөгөөд хоёр тийш харсан сум нь эсрэгцсэн харьцааг илэрхийлэх утгатай хэмээн ойлгож болно. Тэдгээрийн агуулгад юу юуг багталцуулан авч үзэж байгааг удаах загвараас ажиглаж болно. Өөрөөр хэлбэл, оюун билгийн соёл гэдэг нь ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдлыг илэрхийлэл болж байдаг онцлогтой гэж үзвэл зохих юм. Үүнийг Вайсгерберг бодот ертөнц, хийсвэр ертөнц хоёрын завсрын

* МУИС-ийн МХСС-ийн доктор, профессор

ертөнц хэмээн ойлгох боломжтой гэж тэмдэглэсэн зүйл ч бий. Бас түүнийг *virtual world* боломжит ертөнц хэмээн ойлгож болох юм.



Соёл гэдгээс үүдээд *соёл иргэншил* гэдэг бас нэг ойлголт гарч ирдэг. Энэ нь 17 дугаар зуунд латин хэлнээс ирэлтэй *civilis* гэдэг үгээс гаралтай бөгөөд анхандаа зэрлэг балар байдалтай эсрэгцсэн ойлголтыг тэмдэглэж, мөнөөх соёл хэмээхтэй ойролцоо утгаар хэрэглэж байсан гэдэг. Нэхэн дурдваас, 19 дүгээр зууны эцсээр энэ хоёр нэр томъёог утгаар нь ялган зааглаж хэрэглэх хандлаг германы утга зохиолд гарч эхэлсэн гэдэг. Ингэхдээ нийгмийн үйлдвэрлэлийн хөгжлийн ачаар бүтээн боловсруулж авсан эд өлгийн болон оюун санааны цогц бүрдлийгээ соёл иргэншилд хамаат болгон ойлгож, харин энэхүү соёл иргэншлийн оюун санааны агуулга нь даруй соёл хэмээгч болох юм гэж тодорхойлох болсон байна. Германы гүн ухаанч О.Шпенглерийн 1918 онд хэвлүүлсэн нэгэн содон бүтээлийг 1993 онд оросоор “*Закат Европы*” хэмээн орчуулсан эхийн дотор: “соёл болгонд өөрийн гэсэн соёл иргэншил гэж байна. Соёл иргэншил бол чухамдаа, соёлын мөхөл юм гэх буюу соёл бол оюун санааны амьд бие бол соёл иргэншил нь түүний занданшуулсан цогцос шиг юм” гэсэн санаа нь нэн сонирхолтой байдаг. Өөрөөр хэлбэл, О.Шпенглер европын соёл иргэншлийг Европын хувьсал хөгжлийн эцсийн шат хэмээн онцолсон нь яах аргагүй содон сонин санаа юм. Харин Г.Шпет соёл иргэншил бол соёлын төгсвөр ч мөн, эхлэл ч мөн гэж үзсэний хувьд зарин талаараа О.Шпенглертэй адилавар санаа дэвшүүлж байсан бололтой.

Гэтэл А.Тойнби нийгмийн янз бүрийн хэв маяг болгоныг соёл иргэншил гэж үзэх саналтай байсан. Харин С.Хантингтон соёл иргэншил бол соёлын нийтлэг шинжийн хамгийн дээд эрэмбийн зүйл бөгөөд барууны, конфузын, японы, индусын,


исламын, славян-үнэн алдартны, латин америкийн, африкын гэсэн найман зүйлийн соёл иргэншил байна гэж тодорхойлсон байна.

Тэгвэл М.К.Мамардашвили: *“соёлыг зөвхөн оюун санааны хүч чармайлтаар олж авдаг зүйл бол соёл иргэншлийг ашиглаж хэрэглэж ч болно, хаяж орхиж ч болно”* гэсэн нь бас сонин дүгнэлт гэж үзүүштэй байдаг юм. Хэлний соёл судлалын ганц сэдэвт бүтээлдээ В.А. Маслова: *“соёл бол шинэ зүйлийг бүтээдэг. Харин соёл иргэншил нь нэгэнт тодорхой байсан зүйлийг зөвхөн хувилж олшруулах төдий зүйл юм”* хэмээн тэмдэглэсэн нь соёл ба соёл иргэншил хэмээх ойлголтын орчин үеийн үзэл баримтлал зарим талаар нэлээд цэгцрэх байдалтай болж ирж байна уу гэсэн сэтгэгдэл төрөхүйц байдаг.


Чингээд хүн төрөлхтөн соёлжих замд хэл ямар үүрэгтэй байсныг бас л олон янзаар төсөөлөн тайлбарлаж иржээ. Нэгэн ишлэл татъя: *“Хэл бол эсвэл соёлын нэг хэсэг бузуу махбодь, үгүй бол түүний багаж зэмсэг, хэлбэр нь юм. Харин соёл бол оюун санааны үнэт зүйлсийг бүтээх, хадгалах, хуваарилах, хэрэглэх, бодот ертөнцийг оюунчлан эзэмших нэг зүйлийн тогтолцоо юм”* хэмээсэн Г. П. Немещенкогийн тодорхойлолт бас зүй ёсоор анхаарал татдаг.

Энэ бүхнээс үзэхэд хэл, соёл хоёр ухаант хүний гарал үүсэл, хувьсал хөгжлийн түүхэнд ямар учир холбогдолтой зүйл байдгийг үе үеийн ухаантан мэргэд онцгойлон анхаарч, олон талаас нь нягтлан шинжилж, олон янзын үзэл онол дэвшүүлж ирсэн нь өнөө үед улам бүр чухал ач холбогдолтой болоод байна. Ялангуяа хэлний хийсвэрлэлийн хамгийн дээд эрэмбийн зарим асуудал, онцолж хэлбэл, хэлц нэгжийн утга үүргийг хэлшинжлэлийн ухаан төдийгүй, хүнийг судалдаг бусад ухаануудын онол аргазүйн өнөө хүрсэн төвшний уулзварт авч судлах нь зайлшгүй болж байна.

Хүн бол хийсвэрлэн сэтгэдэг, хэлээр ярьдаг, бас заавал нийтэч, хамт олны дотор төлөвшиж хөгждөг, өмнөх үеийнхний бүтээсэн эд өлгийн зүйл болон оюун билгийн соёлыг бэлнээр өвлөн авч хэрэглэхийн зэрэгцээ, түүнийг баяжуулан бүтээж, хөгжүүлж, улмаар хойч үедээ өвлүүлэн уламжлуулдаг бодгаль бас нийгмийн бие хүн байдаг учраас хүний хэлж сэтгэх үйл ажиллагааны хамгийн дээд эрэмбийн үзэгдэл болон илэрдэг метафорыг судлан тайлбарладгаас хүнийг судалдаг ухаануудын судалгааны аргазүй, үр дүнг цогцоор анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай болохыг дараах загвараар харуулахыг зорьсон болно.



Үүнээс үүдээд хүнийг судалдаг ухаанууд буюу ХҮМҮҮНЛИГ-ийн ухаануудын уулзвар дээр дараах шинэ салбар ухаанууд үүсэх болжээ.



Тэгвэл хэл, соёл хоёрын харилцан хамаарлын асуудлыг ерөнхий эсвэл тодорхой аль ч байдлаар авч үзсэн ч тэдгээрийн зайлшгүй нэгдлийг хэлбэр нь чухам ямар байдалтай байх учиртай юм вэ гэдэг асуултыг заавал тодруулахаас өөр аргагүй юм. Үүнд хариу өгөхийн тулд хэл, соёлын харилцан хамааралт шинжийг дараах хэдэн хувилбар бүхий нөхөцмөл асуудлын шийд байдлаар тодорхойлох шаардлагатай болох юм. Үүнд:

1. Хэл, соёлын хамаарлыг харилцахуйн хүрээний асуудал болгон авч үзэх нь зайлшгүй юм. Өөрөөр хэлбэл, нийгэмшсэн хүнээс ангид энэ тухай авч хэлэлцэх боломжгүй юм.
2. Хэрэв хэл, соёлын харилцан хамаарлын асуудлыг гарвалзүйн өнцгөөс нь харвал хэлж ярих, түүнийг сонсож хүлээн авах чадвар дээд эрэмбийн сэтгэцийн тогтолцоонд бүрэлдэн төлөвших онцлог ямар байдалтай хэрэгждэгийг анхаарч үзэх шаардлагатай болно гэсэн үг ажээ. Үүнтэй уялдаад хүний чадварыг орон зай, цаг хугацааны орчилд дамжуулан нэвтрүүлэх үйл ажиллагаа ямар оньсоор хэрэгжиж байгаад хариу өгөх ёстой болдог байна.
3. Нөгөөтээгүүр, нийгэмшсэн хүн төрөлхтөн үүсч бий болоход хэл, соёлын үүрэг ямар учир холбогдолтой байсан вэ гэдэг асуудал нь хувьсалзүйн учир холбогдолтой болохын хувьд бас л зүй ёсоор анхаарал татдаг байна.

Хэл, соёл хоёр харилцан бие биенээ нөхцөлдүүлэх болзмол шинж нь тэдгээрийн аль алинд багталцаж байдаг зарим нэгэн дундын үүсгэлийн үүтгэл шалтгаанаар хэрэгжиж байдаг гэсэн нотолгоог судлаачид уг асуудлын мөн чанарт хариу өгөх эх үндэс болгодог байна. Хэл, соёл хоёр гарвалзүйн шалтгаанаар харилцан нөхцөлдмөл шинжтэй байдгийг нотлох баримт болдог энэхүү дундын махбод нь чухам юу байх вэ гэвэл, тэр нь даруй оюун билигийн (*оюунлиг*) буюу хийсвэрлиг махбод (*идеальное или Idealized*) ажээ. Энэхүү оюун билигийн (*хийсвэрлиг*) махбод нь хэлэндээ гэхэд түүний тэмдгүүдийн утга болж илэрдэг. Харин соёлдоо бол соёлын зүйлсэд дам биежсэн хэлбэр байдлаар оршиж байдаг байна. Түүнчилэн ямар нэг үйл ажиллагааны арга хэлбэр ч юмуу, эсвэл ямар нэг үйл ажиллагааны хүрэх үр дүнгийн дүр, үгүй бол энэ үр дүнд хүрэх зохистой арга, үйл ажилаагааны дүр маягаар дам биш, шууд хүртэгдэх нь ч бий ажээ. Ингэхлээр оюун билигийн (*оюунлиг*) буюу хийсвэрлиг зүйл гэдэг нь чухамдаа хэл соёл хоёрыг харилцан нөхцөлдүүлэгч үүтгэл болохын дээр тэдгээрийн нэгдмөл шинж бодитой орших хэлбэр болж байна гэсэн үг юм.

Ингэхлээр хүний биед цоо шинээр “*үүсэн бий болж*” байгаа энэ чадвар нь амьтан хүний алинд нь ч төлөвшдөг рефлексээс тэс ондоо, зөвхөн ухаант хүнд л цогцлох зүй тогтолтой, онцгой чадвар юм. Энэ онцгой чадвар л хүнийг амьтнаас ялгах нэг гол чанар болно. Энэ чадварынхаа ачаар хүн амьтны сүрэгт биш, гагцхүү хүний нийгэмд аж төрөх хувьтай болж, тэдний өвөг дээдсийн уридаас хуримтлуулсан соёлын зүйлийг хүртэж мэдрэхээр зогсохгүй, түүнийг эзэмдэж эзэмших, хөгжүүлж гүнзгийрүүлэх, улмаар хойч үедээ биежүүлэн үлдээх жам хуультай байдаг ажээ. Хэрэв ингэж үзвэл, хэл бол хэдийгээр соёлын нэг зүйл боловч, хэрэв соёлын тухайн зүйлийг хүртэж мэдрэх, ухаж ойлгох оюун билиг хүнд дутвал соёлын тэмдгийг хэлний тэмдгээр хичнээн тов тодорхой илэрхийлсэн ч гэсэн түүний агуулга буюу утга санаа нь тухайн хүнд огтхон ч эс ухагдаж болно.

Хэлний тэмдгийг зууч болгосон соёлын тэмдгийг бүтэц бүрэлдэхүүнээр нь задлах (*эсвэл бие махбодоороо, үгүй бол оюун ухаанаараа*), түүнийг зүй зохисоор нь ашиглаж хэрэглэх, хэрэгцээ гарвал шинээр бүтээж бий болгох зэрэг чадвар, дадал хүний биед төлөвшихийн цагт сая хэл, соёл хоёр нөхөцмөл шинжтэй мөн чанар болно.

Энэ бол соёлын зүйлтэй харьцах, түүнийг ашиглаж хэрэглэх, бас түүний бүтцийн загвар, түүнийг бүтээх үйл ажиллагааны загварт тулгуурлан түүнтэй ижил зүйлийг давтан бүтээх буюу хувилах эсвэл түүнтэй хэлбэр, агуулгын аль нэг шинжээрээ адилсуу өөр шинэ зүйлийг хийж бүтээх чадварыг эзэмших арга үндэс болно.

Соёлын зүйлс нь хүний чадварыг биежмэл хэлбэрээр удамшлын бус аргаар үеэс үед өвлөн уламжлуулж байгаагаараа онцлог юм. Харин үйл ажиллагааных нь хэв загвар болтлоо хүнийг насан турш нь дагаж, хойч үед нь нэвтрэн уламжилж байдгаараа удамшлын программтай адилсуу зүй тогтолтой болж байна.

Ингэснээр орчин үеийн хэлний соёл судлал нь хүмүүнлигийн ухаануудын уулзвар дээр хүний хийсвэрлэн сэтгэх чадварын хамгийн дээд эрэмбийн үзэгдэл болох метафор, түүнийг үүсгэх арга, харилцаандаа түүнийг хэрэглэхийн утга учрыг судлан тайлбарлах ухаан болж байна.



Ингээд хэл, соёл хоёрын харилцан хамаарлыг таньж мэдэх нэг хэрэглэгдэхүүн, хэрэглүүр нь Метафор судлал гэж үзвэл, Метафорыг бүтээх оньс нь сэтгэлгээний тогтвортой хэв шинж (*Stereotype*), сэтгэлгээний жишиг хэмжүүр (*Etalon*) гэх мэт мета хэлийг ашиглахаас өөр аргагүй болно.

Эталон, стереотип үүсэхэд тухайн соёл-хэлтний аж төрж ирсэн газар нутгийн тогтоц, байгаль цаг уурын нөхцөл, тэнд ургадаг ургамал, тэнд амьдардаг амьтан, тэнд байдаг гол мөрөн, уул ус, тэдгээрийн байдал шинж эртнээс эдүгээ хүртэл тэнд аж төрж ирсэн овог аймаг, отог омог, үндэстэн угсаатан, ястан үндэстний уламжлалт аж төрөх арга ухаан, хийж бүтээж ирсэн эд өлгийн зүйл, ёс заншил, шашин шүтлэг үүнтэй холбоотой тэдний эрхэмлэн дээдэлдэг, дургүйцэн жигшдэг бүх зүйл, зан үйлийн чуулбар болгон чухал учир холбогдолтой байдаг учраас метафор судлалд тэр болгоныг маш нягт нямбай анхаарч үзэх ёстой.

Хүн соёлын зүйлтэй харьцаж эхлэхийн цагт тухайн юм “*Юу байна вэ?*” гэдэг нь төдий л чухал биш, харин “*Яагаад ийм байна вэ?*” гэдэг хандлага маш чухал учир холбогдолтой байна.

Соёлын зүйл болгоныг бүтэц махбодоор нь задлахын хэрээр түүний хэлбэр маяг, бүтэц байгууламжтай нийцсэн үйлдэл, үйл ажиллагааны хэв маяг буюу чадвар хүний бие цогцост аяндаа төлөвшин тогтдог байна.

Энэ чадвар нь тухайн зүйлийн хэлбэр бүтэц, түүнтэй харьцах үйл ажиллагааны тогтвортой хэв маяг (*stereotype*) байдлаар сэтгэцэд хадгалагдана.

Сэтгэцийн энэ тогтвортой хэв шинж нь соёлын тухайн зүйлийг ажиглаж хэрэглэх, бүтээж бий болгох, улмаар түүнийг үеэс үед өвлүүлэн уламжлуулах оньс болдог байна.

Соёлын аливаа зүйлийг уламжлуулахад тухайн зүйлээс гадна түүнийг бүтээж хийсэн үйл ажиллагаа, бас түүний бүтэц хэлбэр, бүтээх үйл ажиллагааны тухай

сэтгэцийн хэв загвар гол хүчин зүйл болно. Үүний ачаар соёлын зүйлс удамшлын бус аргаар үеэс үед маш богино хугацаанд хүний чадвар болж төлөвших учиртай байна.

Нүүдэлчдийн сэтгэлгээг судлахдаа Хүн-Байгаль, Хүн-Мал/амьтан, Хүн-Хүн гэсэн харьцаанд авч үзэх ёстой. Энэ байдлаас үүссэн зарим жишиг хэмжүүр (*эталон*) - ийн жишээг ажиглая.

*Хаврын тэнгэр шиг хувирамтгай
Үүрийн цолмон шиг тод
Талын цэцэг шиг танхил
Арван тавны сар шиг мэлтгэр
Ургаа хад шиг хөшүүн хойрго
Үнсэнд хаясан шалз шиг орц гарцгүй
Өрөмний өт шиг тогтворгүй
Нуур нугас шиг ижилдэн зохирсон
Усны шувуу шиг суурин нутаггүй
Хургаа голсон хонь шиг энэрэл эргэцэлгүй
Тэлээ хурга шиг танхи дураараа
Өмтэй ямаа/тэмээ шиг тогтвор суурилгүй
Дөрлүүлсэн бух шиг дуулгавартай
Дөргүй бух шиг өөрийнхөөрөө зүтгэх
Хонины морь шиг номхон
Нуруугаа авсан морь шиг халирхай
Уургын морь шиг уулгамч
Сүүл долойсон гөлөг шиг долгигнуур*

Дээрх жишээнээс ажиглавал, сэтгэлгээний жишиг хэмжүүр болсон илэрхийллүүдийн зарим нь монгол газар нутгийн байгалийн байдал, цаг уурын орчин нөхцөлийн онцлогтой холбоотой, нөгөө зарим нь монголчуудын нэн эртний үеэс амьдарлагынхаа үндэс болгож ирсэн уламжлалт мал, аж ахуй, түүнийг эрхлэх явцад бий болсон танилт, зан үйл зэргээс шууд шалтгаачан хамаарч үүссэн болох нь илэрхий байна. Жишээлбэл, “*хаврын тэнгэр шиг ааштай хүн*” гэдэг адилтгал нь монгол газрын хаврын тэнгэрийн өдөрт хэдэн янз болж хувирдаг байдлыг эс мэдэх хүнд ямар ч энэ газрын хүмүүст ойлгогдох жинхэнэ утга санаа нь тун бүрхэг бүдэг байхаас аргагүй. Үүний эсрэгээр чийглэг зөөлөн уур амьсгалтай газар нутагт хаврын өдөр ирэх тусам намууран дулаарч, улам аятай тавтай болж, хүмүүсийн зүрх сэтгэл хөөрөн сэргэдэг газарт бол энэ илэрхийлэл маш ялдам, эелдэг сайхан ааштай хүний зан аашийг илэрхийлсэн утгатай хэрэглэгдэх боломжтойг тааварлахад төвөггүй байна.

Үүнчлэн, “*үнсэнд хаясан шалз шиг*” гэдэг адилтгалыг хаврын цагт хачиг бууж, ядарч доройтсон бог мал, ялангуяа туниа муутай төл малыг туйлдуулдаг нэгэн аюултай гамшиг байдаг хийгээд түүнийг малын биеэс түүж, дахин малын биед орохоос нь сэргийлж, халуун нурамтай үнсэнд хаяж, сая нэг амсхийдэг үйлийг эс мэдвэл, гадаадын байтугай, дотоодын бидэнд ч гэсэн тун ойлгомжгүй илэрхийлэл байдаг нь цөм соёлын учир холбогдлоор тайлбарлагдах үүдэлтэй байдгийн гэрч болно. Үүний нэгэн адилаар, “*уургын морь шиг*” гэдэг адилтгалын утгыг зөв ойлгоход бас л ороо морийг элдэж, уургалж барихад тусгайлан давхиулж хэвшүүлсэн морио ингэж нэрлэдэг, ийм морьтой бол ямар ч ороо морийг бахдалтай уургалж цадаж байгааг үзэж эс мэдэрсэн хүнд бас л учир битүүлэг утгатай адилтгал болно.

Ухаант хүнийг байтугай, адгуус малыг гэршүүлж гаршуулах явцдаа хүн өөрийнхөө дураар тэдний үйлийг залж чаддаг болтол нь дасган хэвшүүлж, жолоодон сургана гэдэг бол үнэхээр гайхалтай соёл гэхээс яах вэ? Эдгээр үзэгдэл баримт бол бидний өмнө тэмдэглэснээр, монголчуудын уламжлалт сэтгэлгээний онцлогийг таньж тайлахдаа тэдний үйлийг Хүн-Мал, Хүн-Амьтан, Хүн-Хүн гэсэн хосолмол харьцаанд авч шинжлэх нь зохистой байдаг гэсний учир энэ болно.

Хүний хэлний чадварын хэрэгжих нөхцөл давын өмнө:

1. Тухайн хэлний үгийн сан-утгазүйн мэдлэг
2. Хэлзүйн дүрмийн тогтолцооны тухай мэдлэг
3. Байгаль, нийгмийн юм үзэгдэл, үйл байдал, шинж чанар, тэдгээрийн харьцаа хамаарлын тухай дэвсгэр мэдлэгээс ихээхэн хамаарна. Эдгээрийн нэгдлээс ухамсрын агуулга бүрдэнэ.

Ухамсрын агуулга нь соёлын зүйлийг эзэмших явцад бүрэлдэж, тухайн соёлын зүйлийн биежмэл хэлбэр ба түүнийг бүтээх, түүнтэй харьцах, улмаар түүний ашиглаж хэрэглэх үйл ажиллагааных нь хэлбэртэй хамтаар үндэстний сэтгэлгээ (*Mentality*)-ний хэлбэр, тогтвортой хэв шинж (*Stereotype*), “*дардас*” байдлаар ухамсарт төлөвшин хадгалагддаг байна.

Соёлын зүйлийг нэвтрүүлэх хэлний үүрэг, чадвар боломжийн мөн чанар чухам юу юм бэ? гэвэл:

Агуулгыг нь хэлний тэмдгийн бод биеэр зуучлан нэвтрүүлж, оюунжсан дүр, дүрслэл байдлаар ухамсарт тогтоон бэхжүүлж байдаг хүний онцгой чадвар буюу мэдлэг юм гэж үзэж болно. Хэлний илэрхийллийг ашиглаж соёлын зүйлийг үеэс үед уламжлуулахад хэлний тэмдгийн бод бие нь харилцагчдын ухамсар, оюун санаанд байгаа соёлын зүйлийн тухай мэдлэгийг “*цочроож*” сэргээдэг, зуучийн төдий л үүрэгтэй болохоос утгын тал нь хамгийн чухал зүйл болно. Эдгээр хэллэгүүдийн утгыг юу гэж ойлгох учиртайг анхааралтай ажиглана уу.

- *Гуялаагүй байж туг ширээ*
- *Төрж ядаж байж төлөгт эх болох*
- *Тос гүзээлэх гээд тугалаа гүзээлэх*
- *Өглоо хазаар, орой таиуур*
- *Ухнад явсан хүү ямаа ишиглэсэн хойно ирэв*
- *Үхрийн сүүл дээр хутга*
- *Үдийн газар нэргүй, үнсний цаана мөргүй*
- *Нэр хугарахаар яс хугар*
- *Урмы нь хугалахаар ууцы нь хагал*
- *Зэмэнд хатахаар зэвэнд хат*
- *Ургамалд үгүй бол сургамалд үгүй*
- *Усан нүдтэй цусан зүрхтэй*
- *Харьтыг хажуунаас нь харийн хүнийг гаднаас нь*
- *Яаравч явган бүү суу*
- *Оргүйгээс охинтой нь дээр*
- *Зээрээр мал хийдэггүй, зээгээр үр хийдэггүй*
- *Хийморий нь ямаа хивэх*

Зарим нэг хэллэгийн утга санаатай холбоотой ганц хоёр зүйл тэмдэглэе.

Үүнд: “Гуялаагүй байж туг ширээ” гэдэг хэллэг нь шууд утгаараа зөвхөн тэмээний тарга тэвээргийг шинжиж тодорхойлохоос үүдсэн гэдгийг мэдэж гэмээнэ, түүнийг хүний зан байдлын ямар шинжид хамаатай болгон маш уран яруу илэрхийлж байгааг мэдэхэд амаргүй. Хэрэв үүнийг зөв тайлж чадвал уг хэллэг нь “санаа нь тэнгэрт, салтаа нь цасанд, санаа нь эзнээ голдоггүй, сархинаг нь баасаа голдоггүй, эзэн нь юмаа голдоггүй, ирэг нь сүүлээ голдоггүй, саваагүй нохой саранд хуцах гэгч” хэллэгүүдтэй яагаад ойролцоо утгатай болох боломжтойг тайлбарлахад амархан болж ирнэ.

Ер нь дүрслиг сэтгэлгээний илрэл нь даруй метафорчлох аргаар үүсдэг. Ингэхлээр метафор бол шинээр таньж мэдсэн зүйл, эсвэл шинээр бүтээж бий болгосон зүйл, үгүй бол өинээр нэрлэх зүйлийн илрхийлэл болдог гэдгийг мартаж болохгүй. Нөгөөтэйгүүр, аливаа метафор үүсэх, түүнийг харилцаанд ашиглаж хэрэглэх хэрэгцээ шаардлага нь уг юм, үйл явдал, үйл байдал, шинж царар, нөхцөл байдалд хандах өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийн байдал, хандамж, түүгээрээ сонсогчид нөлөөлж, түүний сэтгэл хөдлөлийн янз байдлы нь тандаж мэдэх гэсэн дотоод сэдэл тэмүүллийн илрэл байдгийг ямагт санах учиртай болно.

Эндээс ажиглавал, дээрх хэллэгүүдийн утга санааг зөв ойлгож тайлахын тулд монголчуудын уламжлалт аж төрөх ёс, зан үйлийн мэдлэг зайлшгүй хэрэгтэй болно. Ийм учраас уг хэллэгүүдийн жинхэнэ утга санааг зөв тайлбарлахад төрөлх монгол хэлтэн зарим хүнд хүртэл амаргүй байдгийн учир ийм байна.

Тэгвэл өөр өөр соёл - хэлтний тухайд тогтвортой хэллэгийн утгын дүйлгийг онооход сонирхолтой ч, бэрхтэй ч асуудалтай алхам тутам тулгардаг гэнэ.

Жишээлбэл:

- *Төрөөгүй хүүхдэд төмөр олгий*
First catch your hare then cook him
Catch the bear before you sell his skin
- *Ямааны мах халуун дээрээ*
Strike while the iron is hot
Make hay while the sun shines
- *Үхрийн сүүлэн дээр хумга*
There is many slips between the cup and the lip
- *Маргаагийн өөхнөөс өнөөдрийн уушиг*
Bird in the hands is worth two in the bush
Better an egg today than a hen tomorrow
- *Хүний авгай томь тогоос, өөрийн авгай тогооны бариул*
The grass is always greener on the other side of the fence
Чужая женишина – лебедь, а своя – горькая полынь стети
- *Өсөхдөө сураагүйг өтөлсөн хойноо сурахгүй*
Хургандаа цадаагүй бол төлгөндөө майлах
Чему Ванька не учился, того Иван Иванович не будет знать
- *Усны эх нь шавартай бол адаг нь булингартай*
Эх нь хээр алаг бол хүү нь шийр алаг
Хэлтэн гүүнээс шувтан унага
Алаг азарганы унага адаглаад таваг цагаан
Ерөөлчийн хүүхэд ерөөлч, хараалчийн хүүхэд хараалч

*От худой курицы, яйца и худые
От худой птицы, и худые песни
Отец рыбак и дети в воду смот*

Ийм төрлийн жишээг аль ч хэлний баримтаас харьцуулан судалж, сонирхолтой дүгнэлт гаргах боломжтой.

Жишээлбэл, монгол хэлэнд **“Харамч”** хэмээх концептийг *“- хорголоо тоолох, нарийндаа хатах, гарын алга дээшээ нь харуулахгүй, гар татуу, гар чангатай, гаднах нь гэртээ, гэртэх нь гэдсэндээ ороогүй, айлд намар, гэртээ хавар, лонхонд унгаж нохойд зайлж өгдөг”* гэх мэт маш олон хэллэгээр илэрхийлнэ. Гэтэл хятад хэлэнд энэ концептийг **“төмөр тахиа”** гэдэг хэллэгээр илэрхийлдэг нь өндөг өгдөггүй, өдийг нь авч болдоггүй гэсэн ухаарлаас үүдэлтэй гэдэг. Ингэхлээр өөр өөр соёл хэлтэнд нэг зүйлийн концептийг илэрхийлэх арга өөр өөр ч байж болно. Заримдаа ижилдүү ч байж болно. аль нь байсан тэдгээрийн сэтгэлгээний онцлог ба нийтлэг шинжээр нөхцөлдсөн болохыг нарийн шинжлэн тодорхойлох учиртай болно.

Нэгэн зүйлийг тэмдэглэхэд, аль ч хэлний метафорыг ерөнхийд нь ажиглавал хүний зан байдлын сөрөг шинжийн тухай өгүүлсэн метафор тооны хувьд илт илүү байдаг нь бас нэг сонирхолтой асуудал болно. Үүнийг аливаа анамоли буюу гаж үзэгдэл болгон хүний оршихуй, амьдрахуйн саад болж байдаг, сөрөг зүйл учраас түүний учрыг олох гэсэн сэдлээс үүдэн, түүний тайлал болгон нь тухай тухайн сонирхолтой нэршил /метафор/ олон олноор үүсэн хэрэглэгдэх зүй тогтолтойг гэрчилдэг байна. иймээс аналог, анамоли хоёрыг бас тэнцүү харгалзуулан үзвэл танин мэдэхүйн үүднээс сонирхолтой дүймэнгүүд гарах боломжтой байдаг ажээ.

ДҮГНЭЛТ

Хэрэв монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн онцлогийг хэлний илэрхийллээр зуучлан судалж байгаа бол уг асуудлын судлагдахуун нь чухам юу байх ёстой юм бэ гэсэн асуулт гарах нь зайлшгүй юм. Тэгвэл ардын үлгэр домог, ерөөл магтаал, туульс, ардын дуу шүлэг зэрэг билиг сургаалын зүйлсээс авахуулаад зүйр цэцэн үг, өвөрмөц, хэвшмэл хэллэг, оньсого таавар зэрэг хэлний тогтвортой илэрхийллүүд юуны түрүүнд судалгааны хэрэглэгдэхүүн болох юм. Учир нь тухайн төрөлх соёл - хэлтний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал, эртнээс нааш эдүгээ хүртэл бүтээн туурвиж, ашиглаж хэрэглэн, улмаар өвлөн уламжилж ирсэн эдийн болон оюуны соёлын зүйлсийн тухай ухаарал ойлголт, мэдлэг ухаан нь чухам эдгээр илэрхийлэлд л тод томруун тусч хадгалагддаг учиртай байна.

Үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлог бүрэлдэн тогтох эх сурвалж нь олон нөхцөл шалтгаанаас үүдэлтэй байх нь гарцаагүй юм. Тухайлбал, тухайн үндэстний эрт дээр үеэс нутаглан аж төрж ирсэн нутаг газрын тогтоц байршил, түүний байгаль цаг уурын нөхцөл байдал, ус ургамал, араатан жигүүртэн, тэдгээрийн шалгаран зохицсон амьдарлын хэв маяг, байгалийн элдэв үзэгдлийн шинж төлөв зэрэг нь чухал учир холбогдол бүхий нэгэн онцгой хүчин зүйл болох нь эргэлзээгүй юм. Чингээд энэ болгонд эртнээс дасан зохицож, нийгэмшин аж төрж ирсэн тухайн отог омог, угсаатан ястан, улс үндэстэн өвөрмөц соёл, өвөрмөц соёл иргэншилтэй байх ёстой болох нь ч бас эргэлзээгүй юм.

Таван хошуу малыг өсгөн үржүүлж, ашиг шимийг нь боловсруулан, тасралтгүй хүртэж байхад суурилсан амьдарлын нэгэн онцгой хэв маяг нь өнгөцхөн ажиглавал, байгалийн хүчнийг аялдан дагалдаж, дасан зохицсон байдалтай мэт санагдавч чухамдаа хүний нийгэмшилд өсч хөгжихдөө хийсвэрлэж сэтгэх, хэлж ярих онцгой чадварыг цогцлоон эзэмдэгч хүнээс өөрөөс нь үүтгэлтэй, ерөнхийлөн илэрхийлвэл, хүн-байгал, хүн-хүний шүтэлцээ, дэлгэрүүлсхийж хэлбэл, хүн-бодос, хүн-байгалийн үзэгдэл, хүн-амьтан, хүн-мал, хүн-хүний хэрэг явдлын харилцан нөлөөлөл, харилцан шалтгаалалцлын улмаас бий болсон нэгэн “шинэ” ертөнц буюу эд-оюуны соёлыг гарвал сурвалж, хувьсал хөгжлийнх нь аль ч талаас авч үзсэн, нэн өргөн дэлгэр, гүн гүнзгий утга учиртай агаад уг асуудлын мөн чанарыг бүрэн дүүрэн тодорхойлж гэвэл наад зах нь “гүн ухаан, сэтгэл судлал, соёл судлал, хэлшинжлэл” зэрэг хүнийг нийгэмшсэн бодгаль, олон түмний төлөөлөлийн талаас нь онцлон судалдаг Хүмүүнлигийн ухаануудын уулзвар дээр зөв тайлбарлаж ухаарах боломжтой болох юм.

Бидний өмнө тэмдэглэснээр, хэл-соёл судлалын гол судлагдахуун нь тогтвортой хэллэг байдаг учраас тогтвортой хэллэгийг соёлын тэмдэг-илэрхийлэл болох талаас нь судалвал өөр хоорондоо гарцаагүй харилцан хамаарал бүхий гурван үндсэн асуудал чухал учир холбогдолтой болно.

Үүний нэгдэх гол асуудал бол үндэстний соёлын өвөрмөц байдлын илэрхийлэл болдог хэлц нэгжүүдийн бүрэлдэхүүнийг хэлний нэрлэлтийн сан хөмрөгөөс ялгаруулан тодорхойлох шаардлагатай болно.

Хоёрдох гол асуудал нь угсаатны хэлшинжлэл, хэл-соёл судлалын үүднээс хэл, соёл хоёрын харилцан хамаарлыг судлахдаа тогтвортой хэллэгийн соёлын утгазүйг шинжлэн тодорхойлж, товчоолон тайлбарлах арга, хүрсэн үр дүнд ямар ялгаа, ямар хамаарал байгааг тодруулах явдал юм.

Гуравдах чухал асуудал бол хэл, соёл хоёрын аль алинд нь нийтлэг үйлчилэхүйц аргазүйн талбарыг зөв тодорхойлох явдал юм. Аргазүйн ийм нийтлэг суурьтай болсноор соёлын “хэл”-ний тэмдгийн үүргээр харилцаанд сэргэн хэрэглэгдэж, үндэстний соёлын тухай мэдлэг, түүнийг хэлээр илэрхийлэх арга чадамжийг үеэс үед өвлүүлэн эзэмшүүлж байгаа тогтвортой нэгжүүдийг судлан тайлбарлах аргыг боловсруулж ашиглах юм.

Эдгээрээс нэлээд чухал нь хэлний хэлц нэгжийн ихэнхэд нь тухайн хэлийг төрөлх хэлээ болгон харилцаж ирсэн үндэстний соёлын өвөрмөц онцлог тусч илэрсэн байдгийг судлан тодорхойлох явдал онцгой ач холбогдолтой юм.

Үүнээс үүдэж хэл-соёл судлалын асуудлыг авч үзэхдээ түүний агуулга, мөн чанар, ач холбогдолд шууд хамаарах дараах түлхүүр ойлголтуудад зайлшгүй тулгуурлах ёстой гэж үзэж байна.

Үүнтэй уялдаад **соёлын дадхал, соёл-хэлний ижилсэх шинж, соёл-хэлний чадамж чадвар, соёлын оногдохуун, соёлын хамсмал утга, соёлын бичвэр, соёлын (тухай) мэдлэгийн сан, соёлын тайлал дохио, соёлын бэлгэ тэмдэг** зэрэг олон ойлголтыг тус бүр ялган авч үзэх учиртай болох юм. Эдгээр нь уг асуудлын хүрээнд судалгаа шинжилгээ явуулах *судалгааны хэл* (метаязык) нь юм.

Монгол нүүдэлчдийн сэтгэлгээний өвөрмөц хэв шинж нь тэдгээрийн уламжлалт соёл, зан үйлээс үүтгэлтэй байх нь зайлшгүй юм. Үүнийг судлан тайлбарлахын тулд монгол газар шороон дээр таван хошуу малыг амьдарлагынхаа үндэс болгон эртнээс нааш аж төрж ирсэн нүүдэлчид ертөнцийг хэрхэн үзэж, яаж ойлгосон нь тэдний ердийн

харилцаанд яаж илэрч байдгийг хэлнийх нь баримтаас тунгаан нягталж үзэх ёстой болно.

Хэлний ийм баримт нь элдэв бүтэцтэй зүйрлэсэн хэллэг, зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэгт тодорхой туссан байдгийг иш үндэс болгож байна. Ийм хэллэгүүд үүсч хэрэглэгдэх учир шалтгаан нь нэгдүгээрт, монгол орны цаг уур, газар нутгийн тогтоц байршил, ан амьтан, ус ургамал, таван хошуу мал, түүний зан араншин зэргийг шууд тусгаж хэлээр илэрхийлсэн онцлог, хоёрдугаарт, түүнийг үлгэр болгож, хүний зан ааш, сэтгэлийн байдал шинжийг тодорхойлох арга хэрэглүүр болгосон онцлог нь судлаачийн анхаарал татах болжээ.

Нүүдэлчдийн сэтгэлгээг судлахдаа Хүн-байгаль, Хүн-мал, Хүн-хүнтэй харьцах, харилцах онцлог гэсэн гурван үндсэн айг юуны урьд баримжаа болгож үзэх нь зүйтэй байна. Ийм харилцааны явцад үндэстний өвөрмөц ухамсар, сэтгэлгээний тогтвортой хэв маяг бий болдог байна. Үндэстний нийгэмшсэн ухамсар төлөвшихөд байгалийн юм үзэгдлийг тусган ухаарсан сэтгэхүй, сэтгэлгээний тогтсон хэв маяг (*стереотип*) чухал учир холбогдолтой байх юм. Сэтгэлгээний тогтсон хэв маяг нь тогтсон жишиг хэмжүүр (*эталон*) -ээр илэрдэг. Үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхойлохын тулд хэлний гарын дор байгаа ганц нэг жишээг авах биш, сэтгэлгээний агуулгыг бүрэн тодорхойлж чадах багцалмал мэдлэгийг төрөл зүйлээр нь айчилж, түүнд хамаарах хэллэг, хэлмэлийг аль болох шавхан түүвэрлэсэн жишээг судалгааны хэрэглэгдэхүүн болгох ёстой гэсэн аргазүйг баримтлах учиртай гэдгийг энд онцлон тэмдэглэж байна.

НОМ ЗҮЙ

- Баянсан.Ж. (2002) Соёл, Хэл, Үндэстний сэтгэлгээ. Улаанбаатар.,
- Баянсан.Ж. (2004) Аномали ба Метафор // МУИС.МХСС. Монгол судлалын Эрдэм шинжилгээний бичиг. Боть ХХI(220). Улаанбаатр.,
- Ж.Баянсан. (2004) Тогтвортой хэллэгийн утгыг тайлбарлах асуудалд. // МУИС.МХСС. Монгол судлал, эрдэм шинжилгээний бичиг. Боть ХХII(227), Улаанбаатар.,
- Ж.Баянсан. (2004) Тогтвортой хэллэгийн утгын когнитив шинж. МУИС.МХСС. Монгол судлал. Эрдэм шинжилгээний бичиг. Боть. ХХIII (328) Улаанбаатар.,
- Баянсан.Ж. (2009) Хэлний соёл судлал нь монгол судлалын шинэ парадигм мөн. // МУИС. Монгол судлал, эрдэм шинжилгээний бичиг. боть ХХХ. х.,41-49, Улаанбаатар.,
- Баянсан. Ж. (2010) Хийсвэрлэл бол хэл, соёлын харилцан хамаарлын мөн чанарыг таньж мэдэх гол арга зарчим болох нь. // Хэл зохиол судлал. Боть II(34), х., 26-31, Улаанбаатар.,
- Телия В.Н. (1996) Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологический аспекты. Москва.,
- Фразеология в контексте культуры. (1999) Москва.,
- Маслова В.А. (2001) Лингвокультурология. Academia, Москва.
- Корнилов О.А. (2003) Языковые картины мира как производные национальных менталитетов. ЧеПо, Москва.,
- Красных В.В. (2002) Этнопсихоллингвистика и лингвокультурология. “Гнозис”, Москва.,
- G. Lakoff and M. Johnson. (1980) *Metaphors We Live By*. Chicago.,

- Paul Ricoeur. (1997) *The Rule of Metaphor: Multi-disciplinary studies of the creation of meaning in language*. Routledge, London
- Claire Kramsch. (2001) *Language and Culture*. Oxford University Press.
- Chang Zonling. (2004) *Comparative in language & Culture*, Ocean University Press.,
- Chang Zonling. (2005) *Cognitive Studies in language & Culture*, Ocean University Press:Qingdao.,
- Zhang Ailing, Chong Ching Da Hue. (2003) *Intercultural Communication*, Chu Ban She.,
- Ungerer F, Schmid N.J. (2001) *An Introduction to Cognitive Linguistics*. Foreign language Teaching and Research Press.,
- Judith N.Martin, Thomas K. Nakayama. (2009) *Intercultural Communication in Contexts*. Foreign language Teaching and Research Press, Beijing.,
- Zoltan Kovecses. (2006) *Language, Mind, and Culture*, Oxford university press.,
- Nancy Bonvillain. (2003) *Language, Culture, and Communication: The Meaning of Messages*. Upper Saddle River, New Jersey.,
- Stephen C. Levinson. (2008) *Space in language and Cognition: Exploration in Cognitive Diversity*
- William A. Foley (2001) *Anthropological Linguistics. An Introduction*. University of Sydney.,

SUMMARY

In this article, author discusses cultural and civil feature's studies of nomadic Mongols, in other words, provides a lingua-culturology in-sight to Mongolian language through the stability expressions such as traditional tales and legends, eulogies, epics, folk poems and songs, as well as proverbs, idioms, phrases, puzzles, metaphors and metonymy. Thus, interpreting metaphor examples requires understanding several aspects of the national mentality.

The fundamental basis for creating those is closely related with dwelling area, geographical landscape, natural and weather conditions, plants, animals, style of living and various natural phenomena.

Metaphor study is on the intersection of different sciences such as culturology, psychology, theory of cognition, cultural anthropology, socio-cultural anthropology and ethnography; hence theirs respective research methodologies and results are utterly applicable.

The main criterion for successful study of the nomadic mentality is comprehension of three basic categories: *man and nature*, *man and animals*, *man and people*. From intermingling of these, the national soul and stereotypes are born. These two are driving forces behind establishing the socio-fundament for civilized society on basis of comprehending natural environment. The stereotypes are represented through a stable merit called etalon.

National mentality features cannot be defined solely on examples of singular use, but based on wholesome definition of its mental content, the category of its content, corresponding phrases, metaphors and metonymy. Only entire encompassment of these can prove authenticity of the research method, as according to the study.

МОНГОЛ ХЭЛНИЙ НЭР ҮГЭЛБЭРИЙН ХАМААТУУЛАХ АЙН ӨВӨРМӨЦ НӨХЦӨЛ

Г. Буянтогтох*

Монгол бичгийн ∇ · ∇ · Θ болон олон монгол хэлний¹ *-ын, -ийн, -ы, -ий, -ны, -ний, -э, -йин, -ии, -не, -ни, -йи, -нэ, -а, -н, -ин, -гин, -хин, -ай, -эй, -ой, -иин, -гай* нөхцөлийг олон үеийн турш “харьяалахын тийн ялгалын нөхцөл” хэмээж ирсэн бөгөөд *-ийн, -ы, -ий, -ны, -ний* нөхцөлийг орчин цагийн монгол болон өвөр монгол хэлэнд,

-ын нөхцөлийг буриад, орчин цагийн монгол, өвөр монгол, халимаг хэлэнд,

-н нөхцөлийг буриад, халимаг, орчин цагийн монгол болон өвөр монгол хэлэнд,

-йин, -ии нөхцөлийг дагуур хэлэнд,

-не нөхцөлийг монгол хэлэнд,

-ни, -йи нөхцөлийг дуншиан хэлэнд,

-нэ нөхцөлийг баоань хэлэнд,

-э, -а, -ин, -гин, -хин нөхцөлийг халимаг хэлэнд,

-ай, -эй, -ой, -иин, -гай нөхцөлийг буриад хэлэнд тус тус хэрэглэнэ.

Эдгээр нөхцөл утга, үүргийн хувьд манж, шивээ хэлний *-и, -ни*; казах-түрэг хэлний *-ын, -ин, -ун, -үн, -нын, -нин, -нун, -нүн, -дын, -дин, -тын, -тин, -ан, -дн, -нын, -нй, -тын, -тй, -дын, -дй, -нюн, -ниң, -тиң, -диң, -ни, -ны, -ню, -ну, -дун, -дүн, -тун, -түн, -туң, -түң, -нуң, -нүң, -дуң, -дүң, -нинг, -йн, -ён, -н, -нынъ, -нинъ, -дынъ, -динъ, -тынъ, -тинъ, -нең, -ныги, -ниги*; наран хэлний *-но*, солонгос хэлний *-ыи* нөхцөлтэй дүйнэ. Үүнд, эдгээр нөхцөл хэрэв, биеийн төлөөний үгийг хэлбэржүүлбэл гурван биеийн аль алинд хамаатуулах, ерийн болон оноосон нэрийг хэлбэржүүлбэл зөвхөн гуравдугаар биед хамаатуулна.

Дурдсан нөхцөл бүтээвэр үгэлбэрзүйн төвшинд нэр үгийг хувилгах үүрэгтэй бус. харин, “... өгүүлбэрт үгийг холбон найруулж, голцуу хамаатайн санаа заадаг...” (Чой.Лувсанжав. 1972.х.31)² байна. Өөрөөр хэлбэл, “... харьяалах хамаарах утга илтгэхээс бус юмсын хөдөлгөөний чиг байр заахгүй” (Базаррагчаа.1992.х.10)³; зөвхөн “эзэмших эзэмлэгчийн харьцаа үүсгэсэн эрхлэх утга...” (Бадамдорж.2001.х.97)⁴-тай

* МУИС, МХСС-ийн багш, доктор, профессор

¹ Буриад, халимаг, дагуур, монгол, баоань, дуншиан зэргийг Монгол Улсын талаас бол нутгийн аялгуу гэж болох ч засаг захиргааны харьяаллын талаас нь тусгай нэгэн монгол хэл гэхээс өөр аргагүй юм.

² Чой.Лувсанжав (1972) Монгол хэлний тийн ялгалын тухай // МУИС. ЭШБ.№ 41. 31 х., Улаанбаатар.

³ М.Базаррагчаа (1992) Монгол хэлний тийн ялгалын утгыг ангилах нь // МУИС. МСХ.ЭШБ. Улаанбаатар.

⁴ Д.Бадамдорж (2001) Монгол хэлний утга судлал, Улаанбаатар.

юм. Тийм учраас, эдгээр нөхцөлийг халимаг хэлний хэлзүйд "Родительный или надеж принадлежности . . . - Харьяалахын буюу хамаатуулах тийн ялгал . . . " (Павлов. 1983.с.104)⁵, буриад хэлний хэлзүйд " . . . родительный (хамаанай) надеж . . . " (Черемисов.1951.с.780)⁶ хэмээсэн байна. Түүнчлэн, эдгээр нөхцөлтэй үгийг " . . . үйл үг огт захирдаггүй" (Базаррагчаа.2000.х.51)⁷ бөгөөд хамниган хэлнүүдэд ийм бүтээвэр байхгүй тул эдгээрийн утгатай дүйх утгыг хамаатуулах нөхцөл илтгэдэг. Энэ бүх онцлогт тулгуурлан бодоход, монгол болон бусад алтай хэлний эдгээр бүтээвэр нэр үгэлбэрийн хамаатуулах айн нөхцөл болох нь эргэлзээгүй байгаа бөгөөд хамаатуулах айн утгыг задлаг (аналитический способ, analytical method); задлаг-нийлэг (аналитико-синтетический способ, analytical-synthetic method) аргаар илтгэх хэрэглүүр болдог байна. Үүнд,

а.Задлаг аргын жишээ:

Буриад хэл: *Миний мори* - миний морь, *манай нутаг* - манай нутаг, *шиний мори* - чиний морь, *танай гэр* - танай гэр, *тэрэнэй нюр* - түүний нүүр, *тэдэнэй саархан* - тэдний цаас, *Аламжын мори* - Аламжийн морь, *морин нюрган* - морины нуруу, *баяшуулай хүбүүд* - баячуудын хөвгүүд;

Дагуур хэл: *Ииний мори* - түүний морь, *ааний кэүкэ* - тэдний хүүхэд, *миний адоо* - миний адуу, *бэдний гажир* - бидний газар, *дэүйши чаас* - дүүгийн цаас, *акайши ноф* - ахын нохой;

Орчин цагийн монгол болон өвөрмонгол хэл: *Миний ном, бидний дэвтэр, чиний үзэг, танай гэр, түүний ах, тэдний эгч, аавын сургаал, ээжийн ерөөл*;

Халимаг хэл: *мини мори* - миний морь, *мана һазр* - манай газар, *чини ах* - чиний ах, *тадна хөн* - танай хонь, *терүнэ нурһн* - түүний нуруу, *теднэ мал* - тэдний мал, *хунын живэр* - хун шувууны жигүүр, *төрскни заян* - эх орны хувь заяа гэх мэт.

б.Задлаг-нийлэг аргын жишээ:

Буриад хэл: *Мүнөө шиний араһаа шини харахадамни* - Сая чиний араас чинь харахад минь; *Энэ эбэр миний һанаһан һанааеымни, бодоһон бодолымни бэелүүлжэ шадаха эбэр* - Энэ эвэр миний санасан санааг минь, бодсон бодлыг минь биелүүлж чадах эвэр;

Дагуур хэл: *Миний кэкумини хажирбэи* - Миний хүү минь буцаж ирэв; *Мааний адоомаани хажирсан* - Манай адуу маань харьж ирсэн; *Бэдний тарээнэань бараан болсон* - Бидний тариа маань арвин болсон, *Шиний битэгшини эдэрдсэн* - Чиний бичиг чинь эвдэрсэн;

Орчин цагийн монгол болон өвөрмонгол хэл: *Миний бяцхан бүжин минь, Энэ миний дурсамж дүүрэн анхны минь үерхэл, Чиний хар хүн чинь хэн юм бэ?, За тэгээд та бүхний ирсэн зорилго тань биелэв үү, Тэдний ганц хогшил хэрэглэл нь гэвэл энэ*;

Халимаг хэл: *Мини бийм арвн нээнтэдэн чини эцгдчн ирэд . . .* - Миний бие минь арван наймтайдаа чиний эцэгт чинь ирээд . . . , *Чини сгэлэнчн ноормас давулад күцэхлэ яяхмч?* - Чиний сааль чинь нормоос даваад гүйцэхлээр яах юм бэ чи?, *Нүдм бидн хури, гармдн ут болдмн* - Бидний нүд маань хурц, гарууд маань урт болно гэх мэт.

⁵ Д.А.Павлов (1983) *Имя существительное. Грамматика калмыцкого языка*. Элиста.

⁶ К.М.Черемисов (1951) *Бурят-монгольско-русский словарь*. Москва.

⁷ М.Базаррагчаа (2000) *Монгол хэл*. Улаанбаатар.

НОМ ЗҮЙ

Бадамдорж Д. (2001) *Монгол хэлний утга судлал*. Улаанбаатар.

Базаррагчаа М. (1992) Монгол хэлний тийн ялгалын утгыг ангилах нь. *МУИС. МСХ.ЭШБ*. Улаанбаатар.

Базаррагчаа М. (2000) *Монгол хэл*. Улаанбаатар.

Лувсанжав Чой. (1972) Монгол хэлний тийн ялгалын тухай. *МУИС. ЭШБ. №41*. Улаанбаатар.

Павлов Д.А. (1983) *Имя существительное. Грамматика калмыцкого языка*. Элиста.

Черемисов К.М. (1951) *Бурят-монгольско-русский словарь*. Москва.

SUMMARY

The author studied following suffixes in Mongolian: $\sim$ · $\sim$ · Θ and *-ын, -ийн, -ы, -ий, -ны, -ний, -э, -йии, -ии, -не, -ни, -йи, -нэ, -а, -и, -ин, -гин, -хин, -ай, -эй, -ой, -иин, -зай* which are not the genitive case suffixes, rather they are possessive suffixes.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Том. XXXIV (360)

2012

(63-67)

ҮНДЭСНИЙ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН БИЧМЭЛ ГАНЖУУРЫН
ЭХ БИЧГИЙН ЗАРИМ ОНЦЛОГИЙН ТУХАЙ

/Юмын ботийн жишээн дээр/

Д.Бүрнээ*

Манай Улаанбаатар хотод хадгалагдаж буй монгол бичмэл Ганжуурын /хойшид УБГ/ ботийн тоо бүрэн бус¹, эхэн, дунд, төгсгөлөөсөө дутуу зохиол цөөнгүй бөгөөд урагдаж сэмэрсэн, балласан, мөрийн завсар хооронд оруулбар хийсэн, урагдсан хэсгийг цаас тавьж наасан, мөр хооронд төвдөөр бичсэн буюу галигласан хуудас тааралдана. Зарим судрын хуудасны дугаарыг товчилж бичсэн, нөхөн бичихээр шинэ хуудас оруулсан, зарим судрыг хичээнгүй нягт нямбай бичсэн байхад заримыг бэх дусаах буюу хазгай мурий бичсэн ч тааралдана. Зарим судрын хуудасны голын 4-7 мөр болон зохиолын нэр, бөлөг хэсгийн гарчигийг улаан бэхээр бичсэн байх боловч зарим ботийг хар бэхээр дагнан бичсэн ч бий. Зарим ботийн бичлэг жигд байхад зарим ботийг хэд хэдэн хүн бичсэн байдалтай жигд биш байна.

Үндэсний нийтийн номын санд Ганжуурын Юмын 12 ботиос 8 боть хадгалагдаж байгаа бөгөөд Nga, Cha, Tha, Na боть дутаж байна. Зарим боть дутаж байхад зарим ботийн хуулбар байгаа бөгөөд үүнд Da ботийн 2 хуулбар байгаа боловч эхлэл төгсгөлөөсөө дутуу бүрэн бус болно.

Үндэсний нийтийн номын санд /хойшид ҮНС/ хадгалагдаж буй Юмын ботийн гарчигийг Санкт-Петербургийн монгол бичмэл Ганжуур /хойшид СПГ/ болон монгол дармал Ганжуур /хойшид ДГ/-тай харгуулвал:

Улаанбаатарын ҮНС-ийн монгол бичмэл Ганжуур			Санкт-Петербургийн монгол бичмэл Ганжуур		Монгол дармал Ганжуур	
№	ботийн дугаар	Ботийн гарчиг	ботийн дугаар	Ботийн гарчиг	ботийн дугаар	Ботийн гарчиг
1	Ка боть	<u>degedü medekü nü</u> činadu kijayag a kürügsen jayun mingyan <u>költi</u>	Боть 27, 524 (1)	<u>bilig ün činadu</u> kijayara kürügsen jayun mingyan <u>toy-a-tu</u>	Боть 26, 0747	<u>bilig ün činadu</u> kürügsen jayun mingyan <u>toy-a-tu</u>

* МУИС-ийн доктор, дэд профессор

¹ Тус Ганжуурын бүтцийн тухай миний бие тусгайлан өгүүлэл бичиж хэвлэлд өгсөн буй.

2	Kha боть	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 28, 525 (1)	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 27, 0748	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu
3	Ga боть	bilig ün činadu kijayar a kürügsen jayun mingyan <u>költi toy-a-tan</u>	Боть 29, 526 (1)	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 28, 0749	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu
4	Ca боть	<u>degedü medekün ü</u> činadu <u>kijayar a</u> kürügsen jayun mingyan <u>költi</u>	Боть 31, 528 (1)	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 30, 0751	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu
5	Ja боть	bilig ün činadu <u>kijayar a kürügsen</u> jayun mingyan <u>toy-</u> <u>a-tan költi</u>	Боть 33, 530 (1)	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 32, 0753	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu
6	Nya боть	bilig ün činadu <u>kijayar a kürügsen</u> jayun mingyan <u>költi toy-a-tan</u>	34 боть, 531 (1)	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 33, 0754	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu
7	Ta боть	bilig ün činadu <u>kijayar a kürügsen</u> jayun mingyan <u>költi toy-a-tan</u>	35 боть, 532 (1)	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 34, 0755	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu
8	Da боть (3)	bilig ün činadu <u>kijayar a kürügsen</u> jayun mingyan <u>költi toy-a-tan</u>	37 боть, 534 (1)	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu	Боть 36, 0757	bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu

Дээрхи хүснэгтээс харвал УБГ-ын Юмын олонхи ботийн гарчиг СПГ болон ДГ-ын гарчигтай таарах бас зөрөх зүйл байна. Тухайлбал төвдөөр *shes rab kyi pha rol tu chyin pa stong phrag brgya ba* гэсэн гарчигийг *bilig ün činadu kürügsen jayun mingyan toy a tu* гэж орчуулсан тухайд таарч байгаа боловч kijayar a хэмээх үгийг нэмж, *bilig ün činadu kijayar a kürügsen jayun mingyan toy-a-tan* гэж орчуулсан, мөн költi хэмээх үгийг нэмж *bilig ün činadu kijayar a kürügsen jayun mingyan költi toy-a-tan* гэж орчуулсаны хувьд ялгаатай. “*Költi*” хэмээх үг бол төвдөөр “*bye ba*”, монголоор “*арван сая*” хэмээх тооны санскрит нэр (ca: koiti). Харин “*költi*”-ийг нэмсэн нь утгыг давхардуулжээ. 1742 онд зохиогдсон “*Мэргэд гарахын орон*” болон түүнээс өмнөх толь бичгүүдэд төвд хэлний “*shes rab*” хэмээх үгийг “*билиг*” гэж орчуулсан байдаг бол энэ үгийг Ка, Са ботийн гарчигт degedü medekün гэж орчуулсан байна. Үүнд төвд хэлний “*shes rab*” хэмээх үгийн “*shes*”-г “*мэдэхүүн*”, “*rab*”-ыг “*дээд*” гэж буулгажээ. Түүнчлэн төгсгөлийн үгийг СПГ, ДГ-ын төгсгөлийн үгтэй харьцуулбал зөрөө харагдана. Тухайлбал Ка ботийн төгсгөлийн үгд тус ботийг орчуулсан Ширээт гүүшийн нэрийг СПГ, ДГ-ын төгсгөлийн үгд бичсэн байдаг бол тус Ганжуурт хасчээ. Ширээт гүүш Юмын 12 ботийг

орчуулсан² бөгөөд түүний нэрийг Юмын тэргүүн ботийн төгсгөлийн үгийн эхэн болон төгсгөлд хоёр удаа тодорхой нэр дурдсаныг УБГ-т хасчээ. Энэ хассаныг бас санамсаргүй зүйл гэж үзэж болмооргүй санагдаж байгаа бөгөөд УБГ бол халхчуудын хийсэн нэгэн зүйл хуулбар учир халхын гүүш Алтангэрэлийн орчуулгыг оруулж, Ширээт гүүш зэрэг зарим өвөр монгол орчуулагчийн нэрийг хассан байж болох юм³. УБГ-ын Юмын Ка ботийн төгсгөлийн үгд СПГ, ДГ-ын төгсгөлийн үгд байхгүй нэмж бичсэн зүйл бий. Түүнийг сийрүүлвэл:

*“aldarsiṯ san boyda erke tū sigemūni yin jarliṯ-I arban qoyar debter tū eke bilig baramid un nom-I asaraqu setkil ūn egūden eče terigūleṯ būrūn. Ayui yeke mongṯol un kelen eče sudurlaju abubai, čaylasi ūgei gūn narin nom un irūgen-I uqaysan iyar čaylasi ūgei kičiyen bičigsen buyan iyar čaylasi ūgei burqan u qutur-I olqu bolturai”*⁴. Энэхүү төгсгөлийн үгийн *Ayui yeke mongṯol un kelen eče sudurlaju abubai.*” гэсэн өгүүлбэрийн “сударлаж авав” гэсэн хэллэгийг авч үзье. “Хорин наймтын тайлбар толь”-д “сударлах” гэдэг үгийг “эрт ба эдүгээгийн онцгой явдал учирьг тэмдэглэн бичих”-ийг хэлнэ гэжээ. Тэгэхээр “агуу их монголын хэлээс сударлаж авав” гэснийг “Билгийн чанад хязгаараа хүрсэн зуун мянгат” хэмээх хөлгөн судрын бэлэн монгол орчуулгыг хуулбарлан авсан гэж ойлгож болмоор байна. Харин хуулбарлахдаа ямар эхээс хуулсан болох нь тодорхойгүй бөгөөд ямар ч байсан Ганжуурын ямар нэг бичмэл эх судар байсан байж таарна.

Дармал Ганжуур дахи энэ ботийн төгсгөлийн үгд Ширээт гүүш орчуулсан гэж тэмдэглэсэн зүйл бий боловч бас Ширээт гүүшийн орчуулгыг засан найруулсан гэж бичсэн зүйл бий. Үүнийг эш татвал “тэнсэл үгүй монгол улсаа тус болохыг сэтгэж, олон сонссон эрдэмийн цогцосоор чимсэн, умар зүгийн зүүн этгээдийн энэ ахуйд үзүүлэгчдийн манлай Ширээт гүүш Манзушири цорж үгсийг найруулан монгол аялгуугаар орчуулсан буюу. Тэл хэлт Дорждаг нэрт дэлгэр банди хийгээд төгс эрдэмт Мэргэн дайчин тайж хоёул нь дахиж аялгуудыг найралтайяа дохиолдуулж бүрүүн. Түүдрэл үгүй орчуулахуйд сэлбэлцэн нөхцсөн буюу”⁵ гээд “Арван хоёр дэвтэр билиг барамидын аялгуу нь адил бөгөөдийн тулд, алдарт богд цоржива ману самбудад хураасныг, анхаарч үл ухагч бичигчид илүү дутуу болсоныг үзэж, тэрхүү богд ламын тидши түүдрэл үгүй самбаа билигт чид хөвгүүн түүнийг төвдийн эх бичиг лүгээ дохиолдуулж, даруй өдийхөн илүү дутуу болсон гэмийг засаж оршуулвай”⁶. Энд бичсэн зүйлээс үзвэл Ширээт гүүшийн орчуулгыг эндүү ташаа хуулж бичсэнийг төвд эх судартай нь тулган магадлаж тэл хэлт Дорждаг нэрт дэлгэр банди хийгээд төгс эрдэмт Мэргэн дайчин тайж хоёул зассан ажээ.

Бичмэл болон дармал эхийн зарим нэг үг хэллэг, өгүүлбэрийг төвд Ганжууртай харьцуулан бичмэл эхийн орчуулгын онцлогийг авч үзье.

² Д.Бүрнээ (2010) Ширээт гүүш Юмын ботиудыг орчуулсан тухай, *Лам нарын сэтгүүл* // 12 сар, №3, 36-39-р тал. Улаанбаатар.

³ Энэ тухай “Үндэсний номын сангийн монгол бичмэл Ганжуурын төгсгөлийн үгээс орчуулагчийг тодруулах нь” хэмээх Д.Бүрнээгийн бичсэн өгүүлэлийг үзнэ үү. /хэвлэлд буй/

⁴ Bilig-un cinadu kijayar-a kurugsen jaṯun mingṯan toṯa-tu, бичмэл Ганжуурын Ка боть, 366а тал.

⁵ Bilig-un cinadu kijayar-a kurugsen jaṯun mingṯan toṯa-tu, дармал Ганжур, 26 дугаар боть 4296 тал.

⁶ Bilig-un cinadu kijayar-a kurugsen jaṯun mingṯan toṯa-tu, дармал Ганжур, 26 дугаар боть 4306-421а тал.

№	ҮНС-ийн монгол бичмэл Ганжуур Юмын Ка боть	Монгол дармал Ганжуур 26 дугаар боть	Төвд Ганжуур ⁷
1	Degedь medekūnū činadu kijayara kūrūgsen jayun mingyan kōlti 2a	Bilig un činadu kijayara kūrūgsen jayun mingyan toya-tu	Shes rab kyi pha rol tu phyin pa stong phrag brya pa 1a
2	Angq-a degedū debter terigūn bōlūg	Terigūn degedū debter eče uridu bōlūg	Glegs bam thog ma bam po dang po 1b
3	Degedū medekūn I masida tegside aldaraysan 2b	Bilig masi teyin bōged geyigsen	Shes rab shin tu rnam par grol ba 2a
4	Ajinai medegči 2b	Medekūi uqay a tai 2a	Cang shes pa 2a
5	Yeke jayad un qayan metū 26	Yeke jayan ūile ūiledūgsen 2a	Glang po chen po bya ba byas pa 2b
6	Barasi ūgei sajin-I medekūi 4a	Barasi ūgei ūjūgūlūgsen e öber e öber e ūneker uqaqui 26	Bstan pa zad mi shes pa la so so yan dag par rig pa 3a
7	Yekede ile medegsen – iyer 4a	Yeke jōng bilig iyer 26	Mngon par shes pa chen pos 3a
8	Ulemjirekūi kiged ergūgdekūi sedkil 4a	Asiglaqui ergūgdekūi sedkil 26	Khe dang bkur sti'I sems 3a
9	Nayidangyui ūgei nom I ūjūgūlūgči 4b	Mayu edülge ūgei e nom i ūjūgūlūgči 2b	Zang zing med pa'I chos stong pa 3a
10	Kijayalal ūgei anadir yalab ud tur degedū medekūni ūjūgūlkūi tūr mergen 5a	Toyolasi ūgei kōlti yalab ud dur ūjūgūlūgsen belge bilig iyer yaryaqui dur mergen 3a	Bskal pa bye ba mtha' yas par bstan pa'I ye shes kyis 'byung ba la mkhas pa 3b
11	Jayun mingyan diyan-I ile bütūgekūi tūr tegsi nigülsejū degedū medekūi uqayan u tōr tūr mergen boluysan 6a	Jayun mingyan samadi yi iledte bütūgekūi dūr teyin bōged čenggekūi belge bilig i onuyulqui dur mergen 36	Ting nge 'dzin brgya stong mngon par sgrub pa la rnam par brtse ba'I ye shes rtogs par bya ba mkhas pa 4b

Төвд хэлний “shes rab” гэдэг үгийг degedū medekūn гэж орчуулсан тухай өмнө өгүүлсэн билээ. Дээрхи хүснэгтэд “shes rab” гэдэг үгээс гадна төвд хэлний “ye shes”, уламжлалт орчуулгад “belge bilig” гэж орчуулдаг үгийг мөн degedū medekūn гэж орчуулсан, төвд хэлний “cang shes pa” гэдгийг УБГ-т ajinai medegči гэсэн бөгөөд ajinai

⁷ bka' 'gyur bris ma, stog pho brang, 'bum, Ka.(Stog Palace Kanjur, TBRC)

бол санскрит хэлний ājśāneya “*лавтай мэдэгч*” гэсэн үг тул ajinai medegči гэсэн нь “*лавтай төгс мэдэгч*” гэсэн утгатай. ДГ-т бол харин medekūi uqaγ -a tai гэжээ. Мөн төвд хэлний “*mingon par shes pa*” гэдэг үгийг УБГ-т ile medegsen гэж орчуулсан бол ДГ-т jōng bilig гэж “*Мэргэд гарахын орон*” толь бичигтэй адил орчуулсан байна. УБГ-т буй зарим зөрөөтэй орчуулгыг авч үзье. “*Bstan pa*” хэмээх төвд үг хоёр утгатай. 1 дүгээр утга нь “*ишаин*”, 2 дугаар утга нь “*үзүүлэх*” болно. 6 дугаар жишээний “*Bstan pa zad mi shes pa la so so yan dag par rig pa*” гэсэн төвд өгүүлбэрийг ДГ-т Barasi ūgei ūjūgūlūgsen e öber e öber e ūneker uqaquī буюу ūjūgūlūgsen гэж орчуулсан нь зүйтэй. 3 дугаар жишээнд qayān metū гэсэн үг илүү орсон, 11 дүгээр жишээнд “*brtse ba*” гэсэн төвд үгийг хоёр өөр орчуулсан нь төвд эхтэй холбоотой байж болно. “*brtse ba*” гэсэн үг угтвартай бол nigūlsejū, угтваргүй бол cenggekiū гэсэн утгатай. 10 дугаар жишээний тухайд бол УБГ-т живаа хэмээх тооны нэрийг орхисон байх бөгөөд түүний оронд anātir хэмээх үгийг бичжээ. Энэ үгийг монгол бичгээс хэдэн янзаар буулгаж болох боловч anātir гэж буулгах нь зүйтэй болов уу. Энэ үг бол төвд хэлний “*mtha' yas pa*” хэмээх үгийн an anta буюу “*хязгааргүй, хэмжээлшгүй*” гэсэн утгатай санскрит үгийн галиг гэж бодож байна. 11 дүгээр жишээнд “*ting nge 'dzin*” гэсэн үгийг хоёр өөр орчуулсан байх бөгөөд samadī (ca: samādhi) гэж буулгасан нь зов бөгөөд харин diyan (ca: dhyāna) гэсэн нь “*bsam gtan*” хэмээх үгийн хөрвүүлэг болно. Энэ нь дээр хэлсэнчлэн төвд эхийн үг үсгийн зөрүүтэй холбоотой болов уу.

Энэ зөрөөнөөс үзвэл бичмэл Ганжуурын энэ боть Ганжуурын нэгэн зүйл хуулбар болох бөгөөд ингэхдээ засан найруулахаас өмнөх үеийн хувилбар байж магадгүй гэж бодож байна. Нөгөөтэйгүүр “*Билгийн чанад хязгаараа хүрсэн зуун мянган тоот*” хэмээх Юмын ботийн гарчигийг зөрөөтэй буулгасан хийгээд зарим ботийн хэд хэдэн хуулбар байгаа зэргээс тус бичмэл Ганжуур нь өөр өөр хуулбарын нийлбэр байхыг үгүйсгэх аргагүй.

SUMMARY

The handwritten Mongolian Kanjur stored in the National Library of Mongolia is not complete. In this paper, some text features of Śatasāhasrikā-Prajñāpāramitā have been studied. These volumes are not complete, eight of twelve volumes have been kept and other volumes, Nga, Cha, Tha, Naare are still missing. Some differences in the title of eight volumes might be connected to the Tibetan original text, or it might be a collection of volumes from different places. The colophon of first volume has no information about the translator. In the volumes of Saint-Petersburg's Mongolian handwritten Kanjur and printed Mongolian Kanjur, it is noted that this volume was translated by Širegetū gūūši, and the translation was edited by *tel keletū Dorji gray neretū delger bandi kiged Mergen dayičin tayiji*. In Mongolian and Tibetan historical sources we can find information that leads us to believe that all twelve volumes of Śatasāhasrikā-Prajñāpāramitā were translated by Širegetū gūūši. We view that the absence of the name of the translator in the colophon of Ulaanbaatar Kanjur as not typical.

**МОНГОЛ ХЭЛНИЙ ТӨРӨЛ САДАН, УДАМ УГСААГ ЗААДАГ
ЗАРИМ ҮГИЙН УТГЫН ТУХАЙ**

Ж.Сэржээ*

Өөрийн уг язгуурынхаа түүхийг өндөр дээд өвгөөсөө эхлэн аман болон бичгийн хэлбэрээр дамжуулан хойч үедээ үлдээх уламжлал монголчуудын дунд нэн эрт үүсч, өөрсдийн уг гарал, угсаагаа сайн мэдэж байсныг түүхийн олон баримт гэрчилдэг. XIII зууны монголчуудын тухай Персийн түүхч Рашид-ад-Дин: “Эдгээр бүх аймгууд яруу тодорхой удам угсааны түүхтэй. Учир нь монголчуудын заншил бол овог дээдсийнхээ удам угсааг залган санаж, төрсөн үр хүүхдэдээ зааж сургадаг. Ийнхүү тэд уг язгуурынхаа тухай үгсийг хүмүүсийн хүртээл болгодог учраас тэдний дунд яс угсаа, овог аймгаа мэдэхгүй хүн нэг ч үгүй” гэж бичиж байв. /1952: 13-р тал/

“Монголын нууц товчоо”-нд 1162 онд төрсөн Чингис хаан Тэмүүжиний уг гарлыг YIII зууны үеэс буюу түүний эртний өвөг дээдэс Бөртэ Чино, Гоо Марал нарын үеэс эхлэн түүнийг хүртэл 23 үеийн хүмүүсийг нэг бүрчлэн нэрлэн жагсаасан байна. Бас Монгол улсын үндэсний номын санд 8109/96 дугаартай хадгалагдаж буй “Бэда хэмээх Монгол улсын анхны ноён Бөртэ чино” Гоо марал хоёроос эхлэн Түшээт хан Гомбодорж, Сэцэн хан Шолой нарын үр хүүхдүүдийг хүртэл 42 үеийн угсаа залгамжийг үзүүлсэн угийн бичиг хадгалагдаж байна. Энэ угийн бичиг нь 100x352 см хэмжээтэй, давхарлан наасан муутуу цаасан дээр хар, улаан бэх хэрэглэн бийрээр бичсэн гар бичмэл бөгөөд Монгол улсын түүх соёлын хосгүй үнэт дурсгалын бүртгэлд орсон бүтээл юм. Ийнхүү өөрийн уг гарлаа, сайтар мэдэж, цус ойртолтоос сэргийлэн хамгаалж байсны үр дүнд монголчууд цөөн ч гэсэн олон мянган жил саруул ухаан, чийрэг биетэй, эрэмгий зоригтой, дайчин ард түмэн байж чадсан юм. Судалгааны ном зохиолуудаас үзвэл монголчууд хүчирхэг төр улсаа байгуулж байхдаа ч өнөөгийнхөөсөө олон хүнтэй байсангүй. Тухайлбал, 1247 оны тооллогоор 2 сая орчим, Юань улсын үед 2,5 сая монгол хүн байжээ. /1:140/

Монголчууд нэн эрт үеэс эхлэн өөрсдийн уг гарал, удам судар, овог аймаг, төрөл саднаа ийнхүү сайн мэдэж байсан нь олон үг, хэллэг, нэр томъёогоор дамжин монгол хэлэнд маань хэрхэн тусч үлдсэнийг монгол хэлний тайлбар толь болон орчуулгын толь бичгүүдээс харж болно. Харамсалтай нь, өнөө цагийн олон монгол хүн өөрийн овог, удам угсаагаа мэдэхээ больсон болохоор тэдгээрийг нэрлэн заадаг үгсийн утгыг ч бас нарийн ялгаж мэдэхгүй болсон байна. Тухайлбал, энэ зууны эхэн хүртэл хүмүүсийн албан ба албан бус харилцаанд овог хэрэглэхгүй, зөвхөн эцгийн /эхийн/ нэр, өөрийн нэр

* МУИС, МХСС-ийн багш, доктор, профессор

хоёрыг хэрэглэж байснаас **“овог”** гэдэг үгийг эцэг /эх/-ийн нэр хэмээн ойлгодог болсон байлаа. Өөрөөр хэлбэл монголчууд овог хэрэглэж байсны гэрч болж аливаа хүний бичиг баримтанд **овог нэр** гэсэн асуулт хэлбэрээр энэ үг үлдсэн байв. Харин өнөөдөр монголчууд овог гэдэг бол эцгийн /эхийн/ нэр биш, түүнээс асар өргөн агуулгатай өөр ойлголт юм байна гэдгийг мэддэг болжээ. Гэхдээ олон хүн, түүний дотор иргэний бүртгэлийн байгууллагын ажилтнууд хүртэл овог гэхийн оронд **ургийн овог** хэмээн ярих болсон байна. Энэ бол эцэг эхийн чинь нэр биш, жинхэнэ овог чинь юм шүү гэдгийг л ийнхүү ургийн овог гэдэг үгээр тодотгоод байгаа бололтой. Тэгвэл овгийг овог л гэх ёстой. Ураг гэдэг үг бол өөр утгатай үг билээ. Иймд ургийн овог хэмээн хэлэх, ярих нь буруу юм. Арав гаруй жилийн өмнөхийг бодвол овог гэдэг үгийн утгыг илүү ойлгодог болсон өнөөгийн монголын иргэдэд ураг хэмээх үгтэй хоршин хэлж будлиан үүсгэх шаардлагагүй.

ОВОГ гэдэг үгийг **Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд**: 1. Ясан төрлийн холбоотой хүмүүсийн өвөг дээдсээс уламжлагдсан нэр, *овог аймаг* /нэг угсаанаас гаралтай хүмүүсийн нэгдэл/, *овог удам* /өвөг дээдсийн угсаа гарал/, **Я.Цэвэлийн тайлбар тольд**: *“Ясан төрлийн удам угсааны үе уламжилсан нэр, омог”*, **Хорин нэгтийн тайлбар тольд**: **овог** - нэг төрлийг нэг овог хэмээмүй, **овогтой** – нэг төрлийг нэг овогтой хэмээмүй, бас бус хүнийг тэр овогтой хүн, энэ овогтой хүн хэмээн хэлэлцмүй, **Хорин наймт тайлбар тольд**: аливаа хүний уг язгуурыг **овог** хэмээмүй. Овог язгуур хэмээн холбож хэлэлцмүй гэсэн бол, **С.Шагжийн тайлбар тольд**: **овог** – угсааны ясыг, **овогтой** – нэг ястайг нэг овогтой хэмээмүй, Норжин, Ман Мөрөн нарын эрхлэн найруулсан **“Монгол хэлний толь”**-д: овог – 2. Ясан төрлийн удам угсаа бүхий хүмүүсийн үе уламжилсан нэр гэх мэтээр манай гол тайлбар толиудад тайлбарласан байна. Түүнээс гадна хоёр болон олон хэлний орчуулгын толиудад энэ үгийг хэрхэн ойлгож дүйцэх үг оноосныг үзвэл: 1895 онд Санкт – Петербургт хэвлэгдсэн **К.О.Голстунскийн “Монгол-орос толь бичиг”**-т *“Овог – род, семейство, родовое имя, фамилия”* гэж оноосон бол 1844 онд Казаньд хэвлэгдсэн **О.Ковалевскийн “Монгол–орос–франц толь бичиг”**-т *“фамилия, род, колено”* хэмээн тайлбарласан байх бөгөөд хамгийн сүүлд буюу 2001 онд Москва хотод хэвлэгдсэн **“Монгол-орос дэлгэрэнгүй их толь”**-д *“овог-2. Фамилия”* гэж оноогоод **овог нэр** – фамилия и имя, *таны овог нэр хэн бэ?* – как ваше имя и фамилия ? гэх мэтийн жишээ авчээ. **Үүнээс үзвэл овог гэдэг нь хэн нэгэн хүний эцгийн нэр биш, харин тэр хүний ясан төрлийн бүх хүнийг нийгэд нь нэрлэсэн нэр гэдэг нь тодорхой байна.**

Монголчуудын дунд лавтайяа мянга гаруй жил хэрэглэгдэж, үгийн санд нь гүн гүнзгий орсон “монгол хүний овог”-ийг арав гаруйхан жилийн өмнө сэргээн хэрэглэсэн бөгөөд өнөөдөр Монгол улсын иргэний бүртгэлд 95 мянга гаруй овог байгаа ба тэдний дотор боржигин овог хамгийн олон буюу нийт хүний 14% -ийг эзэлж байна. Боржигин овог бусдаасаа олон байгаа нь дэлхийн аль ч улс оронд зарим овог түгээмэл тархсан байдаг зүй тогтлоос ангид үзэгдэл биш юм. Гэвч монголчуудын овгийг дахин устгахыг, бүр ядвал “удам” гэдэг үгээр солихыг санаархагчид өнөө ч байсаар байгааг дашрамд дурдах нь зүйтэй. Тэдний саналаар бол, 2012 онд шинээр олгох **иргэний үнэмлэх дээр** монголчуудын хэдэн зуун жил хэрэглээд ирсэн Овгийн нэр, эцэг эхийн нэр, өөрийн нэр гэсэн асуултын оронд **Удмын нэр, аав ээжийн нэр, өөрийн нэр** гэсэн асуулт бичих гэнэ. Тэд энэ санаагаа хэрэгжүүлэхийн тулд хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлаад Монгол улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх **“Иргэний танхим”**-д

“Удмаа мэдэж эрхэмлэгдээ” нэртэй хэлэлцүүлгийг энэ оны 1-р сарын 24-нд хийсэн байна. Аливаа хэлний ямар ч үгийг хэн нэгэн хүн дуртай үедээ устгах юмуу өөр үгээр сольж болдоггүй. Өөрөөр хэлбэл тэмээг ямаа гэж нэрлэж болдоггүйтэй адил овгийг удам хэмээн нэрлэж болохгүй гэдгийг мэддэггүй шинжлэх ухааны докторууд /нэг биш/ байдаг юм байна. Овог, удам хэмээх хоёр үгийн утга тэмээ ямаа хоёр шиг ялгаатайг дараах толь бичгүүдийн тайлбараас төвөггүй мэдэж болно.

Өнөөгийн монголчуудын дунд **УГ, УДАМ, УГСАА, УРАГ, ТӨРӨЛ, САДАН** гэх мэтийн үгсийг янз бүрээр ойлгож, толь бичгүүдэд ч янз бүрээр тайлбарлаж байгаад анхаарлаа хандуулж, нэгэн мөр болгон цэгцэлж, нэгдсэн ойлголттой болох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тухайлбал: **С.Шагжийн тайлбар тольд** : **Уг** - аливаа юмны анх үүслийг нь, бас өвс модны үндэсний этгээдийг нь, **Угсаа** - аливаа төрлийн хүнийг, **Удам** -ургийг, бас нэг овгийн хүнийг, **Ураг** - аливаа худ ургийн хамаат хүнийг хэмээн тайлбарласан бол **Хорин нэгтийн тайлбар тольд**: **Уг** - аливаа үндэс эхийг уг хэмээмүй, **Угсаа** - төрөл аймгийн анх нь нэгэн язгуураас үндэслэн үржсэн бөгөөд уг утга зан чанар нэгэн адилаар угсаа хэмээмүй, **Удам** – нэг овгийн хүнийг удам хэмээмүй, жич ургийн хүнийг мөн ураг удам хэмээн хэлэлцмүй, **Ураг** – аливаа худ овгийн хамаат хүнийг цөм ураг хэмээмүй, Жич эцэг эхийг мөн **төгс ураг** хэмээн хэлэлцмүй, **Төрөл** – нэг овгийн ах дүү нарын зэргийг төрөл хэмээмүй гэж тайлбарласан байна.

Хорин наймт тайлбар тольд: **Угсаа** – төрөл аймгийн анх нь нэгэн язгуураас үндэслэн үржсэн бөгөөд уг утга, зан чанар нэгэн адилаар угсаа хэмээмүй, **Удам** – нэг овгийн хүнийг удам хэмээмүй. Жич ургийн хүнийг мөн ураг удам хэмээн хэлэлцмүй. **Ураг** – Эхнэрүүд бие шалтгаантай болоод тогтносныг ураг хэмээмүй. Аливаа худ ургийн хамаат хүнийг цөм ураг хэмээмүй. Жич эцэг эхийг мөн **төгс ураг** хэмээн хэлэлцмүй. **Төрөл** – нэгэн өвгөөс үржсэнийг нь төрөл хэмээмүй. **Садан** – төрөл ургийн үр хүүхэд бүхнийг аймаг садан хэмээмүй. Бас ураг садан хэмээн холбож хэлэлцмүй. **Хамаа** - эцгийн төрөл, эхийн ураг ураг сүлбээ бүхнийг цөм хамаа хэмээмүй. Бас хамаатай хэмээмүй. **Я.Цэвэлийн тайлбар тольд**: **Уг** - 1. Ёзоор, язгуур, 2.үүсгэл, анх эх; угийн бичиг /гэрийн үеийн бичиг/, **Угсаа** – 1. Үндэс, сурвалж; үндэс угсаа, яс угсаа, 2. Угсаа залгамжлах /хаад ноёдын хөвгүүд, төрлийн хүмүүсээс тэдний хэргэм зэрэг, тушаалыг залгамжлан авах/, **Удам** – 1. Угсаа төрөл; угсаа удам, удам судар, удам судрыг дуудах /хүний өвөг дээдэс угсааг сөхөж өгүүлэх/, **Ураг** – 1. Худ худгуйн хамаатан; ураг төрөл, ураг садан, ураг тогтох /хөвгүүн охин хоёроо эр эм болгохоор хэлэлцэж тохирох/, ураг бололцох /эр эмийг холбож худ худгуй болох/ **Төрөл** – 2. Садан; *садан төрөл, төрөл садан, ураг төрөл, цусан төрөл* /эхийн төрөл/, *ясан төрөл* /эцгийн төрөл/, *төрлийн ах* /нэг овгийн ах/, *төрлийн дүү* /нэг овгийн дүү/, **Садан** – хамаатан, төрөл; *садан төрөл, эцгийн садан, холын садан*, **Хамаатан** – садан төрлийн хүмүүс; *хамаатан садан* хэмээн тус тус тайлбарлажээ.

Өвөр монголд 1999 онд хэвлэгдсэн “*Монгол хэлний толь*”-д: **Уг язгуур** – уг үүсэл, **уг удам** – өвөг дээдэс нэгтэй хүмүүсийн язгуур, **Угсаа** - нэр төр бүхий удам угсаа, **Угсаатан** – нэг язгуурынхан, **Удам** - 1. Угсаа, төрөл, 2. Цусан сүлбээгээр дамжин уламжилсан нэгдэлтэй онцлог шинж. *Удам угсаа* – хүн амьтны өвөг дээдэс, уг язгуур, *удам судар* – хүний өвөг дээдэс төрөл угсааг тэмдэглэсэн түүх бичиг, *удам тасрах* – үр хүүхэдгүй болж голомт харлах, **Ураг** – 1. Хүний эм чанарын үржлийн эс, 2. Эхийн хэвлийд тогтсон хүүхэд, 3. Гэр бүл болсон эр эмийн харьцаа, 4. Худ бололцсон хоёр

айлын харьцаа. *Ураг элгэн* – нагац зээ зэрэг цусан төрлийн харьцаагаар ойрхон хамаатан, *ураг удам* – цусан төрлийн харьцаат удам, *ураг садан* – ургийн харьцаанаас шалтгаалсан хамаатан, *ураг төрөл* – цусан төрлийн харьцаат хамаатан. **Төрөл** – 3. Яс цусны ойр удмын барилдлага бүхий хүн. *Ясан төрөл, цусан төрөл, ураг төрөл, садан төрөл*. **Садан** – сүлбээ холхон төрлийн харьцаа бүхий хүмүүс. **Хамаатан** – төрөл садан. гэх мэт тайлбар хийсэн байна.

2008 онд хэвлэгдэн гарсан таван боть **Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд**: **Уг** – 1. Юмны ёзоор, язгуур; *уг язгуур /эх үүсвэр/, 2. Хүн амьтан, бодис юмны үүсэл, эх; уг гарал /гарал үүсэл/, угийн бичиг /...удмын бичиглэл/ уг эх /а. жинхэнэ эх, б. Эхлэл үүсгэл/, Угсаа* – 1. Үүсэл гарвал, үндэс гарвал, үндэс сурвалж; *угсаа эш /гарал үүсэл/, удам угсаа /уг гарвал, гарвал үүсэл/, үндэс угсаа /үндэс сурвалж/, яс угсаа /яс үндэс/, төрөл угсаа /угсаа гарал, удам судар/, угсаа үндэстэн /гарал үүсэл, хэл, соёл нэгтэй хүмүүс/, 2. Хаад ноёдын удам залгамжлагч; угсаа залгамжлах /хаад ноёдын хөвгүүд, төрлийн хүмүүсээс тэдний хэргэм зэрэг, тушаалыг залгамжлан авах/, угсаа төрөл /цусан төрлийн удам бүхий хүмүүсийн сүлбээ/, үүлдэр угсаа /мал амьтны уг гарвал, угшил/, Удам, - угсаа, төрөл язгуур; удам дагах, удам дамжих, удам залгах, удамтасрах, эцгийн удам /эцгийн угсаа, төрөл/, удам судар /угсаа гарал, үүх түүх/, овог удам /өвөг дээдсийн угсаа гарал/, уг удам /угсаа гарал/, ураг удам /удам угсаа/, Ураг* – 1. Угсаа төрөл; *алтан ураг /Чингис хааны ургийн хүмүүс/, ураг төрөл /мах цусны холбоотой төрөл садан хүмүүс/, ураг удам /хүн амьтны уг угсаа/, ураг элгэн /бүх хамаатан садан цөм/, 2. Худ бололцсон хоёр айлын харьцаа; ураг барилдах. ураг бололцох /эр эмийг холбож худ худгүй болох/, Төрөл* – 1. хүний амьдрах үе, нэгэн нас; 2. Садан; *төрөл хүмүүс /садан хүмүүс, гарал угсаа нэгтэй хүмүүс/, цусан төрөл /эхийн төрөл/, ясан төрөл/ эцгийн төрөл/, төрөл садан /хамаатан садан, мах цусны барилдлага бүхий хүмүүс/, төрөл төрөгсөд /хамаатан садан/, төрөл угсаа /угсаа гарал, удам судар/, төрөл удам /удам угсаа/, ураг төрөл /мах цусны холбоотой төрөл садан хүмүүс/, Садан* – Хэвтээ чиглэлийн гарлын холбоотой хамаатан хүмүүс; *ойрын садан /гарлын холбоо ойр хүн/, холын садан /гарлын холбоо хол хүн/, эхийнсадан /цусан төрлийн холбоотой хүн/, эцгийн садан /ясан төрлийн холбоотой хүн/, амраг садан /хань болон хамаатан хүмүүс/, төрөл садан /яс махны барилдлагатай хүмүүс/, ураг садан /а. Цусан төрлийн холбоо бүхий хамаатан хүмүүс, б. Худ ургийн хоорондын холбоо сүлбээ/, хамаатан садан /яс,цус, ураг төрлийн харилцаа холбоо/, элгэн садан /мах цусны холбоо бүхий төрөл хүмүүс, ойрын төрлийн хамаатан/, Хамаатан* – Садан төрлийн хүмүүс; *холын хамаатан /өөрийн ах дүүсийн хэн нэгэнтэй дам холбогдох садан төрлийн хүн/, хамаатан садан /ураг төрлийн хүмүүс/, хамаатан сүлбээтэн /хамаа сүлбээ бүхий хүмүүс/ хэмээн тайлбарласан тайлбаруудыг уншаад дээрх үгсийн жинхэнэ гол утгыг олж ойлгоход багагүй хүндрэлтэй учирна. Энэ нь манай монгол хэлний тайлбар толиуд дахь үгийн утгын тайлбар оновчгүй, шинжлэх ухааны үндэслэл гүехэн, учир шалтгааны холбоо муутай байгаагийн цөөхөн жишээ болно. Эдгээр тайлбаруудыг нэгтгэн үг тус бүрийнх нь гол утгыг тодорхойлохыг хичээе. Үүнд:*

УГ –аливаа юмны анхны эх үүсвэр, язгуур хэмээх утгаар олонхи толь тайлбарласан байна. *уг эх* гэвэл анхны эх, *уг гарал* гэвэл эх үүсвэр, *угийн бичиг* гэвэл хүний язгуурын гарлыг заасан бичиг хэмээн ойлгож болно. Бас нэгэн эхээс үүдсэн төрөл хүмүүсийн дээд угийг заасан **УГСГАР** хэмээх үг бий. Хорин наймт тайлбар тольд: Аливаа юмын анх эхлэн үүдсэн үүсвэр үндсийг уг эх хэмээмүй. Бас хүний язгуур

үндсийг мөн уг эх хэмээх ч буй. Нэгэн салаанаас үржсэн хүүхэд дүү нарыг нэг угсгар хэмээмүй гэж тайлбарласан байна.

УГСАА, УДАМ гэсэн хоёр үгийн утгыг дээрх тайлбар толь бичгүүдэд хоёуланг нь бараг ижил утгаар: */үүсэл гарвал, үндэс гарвал, үндэс сурвалж/* тайлбарласан байна. Тухайлбал, С.Шагж: **Угсаа** - аливаа төрлийн хүнийг, **Удам** -ургийг, бас нэг овгийн хүнийг, Хорин нэгтийн тайлбар тольд: **Угсаа** - төрөл аймгийн анх нь нэгэн язгуураас үндэслэн үржсэн бөгөөд уг утга зан чанар нэгэн адилаар угсаа хэмээмүй, **Удам** – нэг овгийн хүнийг удам хэмээмүй, жич ургийн хүнийг мөн ураг удам хэмээн хэлэлцмүй гэсэн нь хоёр толийн тайлбар удам гэдэг үгийн хувьд нийлж байгаа ба угсаа гэдэг үгийг С.Шагж “аливаа төрлийн хүн” гэсэн бол Хорин нэгтийн тайлбар тольд: “*төрлийн анх, нэгэн язгуураас үндэслэсэн*” гэж тайлбарлажээ.Тэгвэл Я.Цэвэл: **Угсаа** – 1. Үндэс, сурвалж; үндэс угсаа, яс угсаа, 2. Угсаа залгамжлах */хаад ноёдын хөвгүүд, төрлийн хүмүүсээс тэдний хэргэм зэрэг, тушаалыг залгамжлан авах/*, **Удам** – 1. Угсаа төрөл; */угсаа удам, удам судар, удам судрыг дуудах /хүний өвөг дээдэс угсааг сөхөж өгүүлэх/*, гэж удам гэдэг үгийг угсаа гэдэг үгээр нь тайлбарласан байна. Норжин Ман Мөрөн нарын Монгол хэлний тольд: **Угсаа** – нэр төр бүхий удам угсаа, **Удам** – угсаа төрөл гэсэн нь аль алины нь тодорхой тайлбар болж чадсангүй. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд: **Угсаа** – 1. Үүсэл, гарвал, үндэс, сурвалж; 2. Хаад ноёдын удам залгамжлагч; **Удам**, - угсаа, төрөл язгуур; */удам дагах, удам дамжих, удам залгах, удам тасрах, эцгийн удам /эцгийн угсаа, төрөл/, удам судар /угсаа гарал, үүх түүх/, овог удам / өвөг дээдсийн угсаа гарал/, уг удам /угсаа гарал/, ураг удам /удам угсаа/, хэмээн энэхүү хоёр үгийг үндсэндээ утгын ялгаагүй шахам тайлбарлаад удам угсаа, яс угсаа, үндэс угсаа хэмээх хоршоо үгсийг дурджээ. Монгол хэлний тайлбар толиудад ийнхүү будилсан, оновчгүй буруу тайлбар хийж байхад “Монгол-Орос дэлгэрэнгүй их толь”-д: угсаа- 1.происхождение, удам- 1.наследственность, преемственность, 2. Потомство, потомок, удамших- наследоваться, передаваться по наследству гэх мэтийн үг оноосон нь угсаа, удам гэсэн хоёр үгийн утгын ялгааг маш сайн гаргасан байна.*

Орчин үед угсаа, удам хэмээх хоёр үгийн тус тусын нь утга ийнхүү бүдгэрснээс хүмүүс өөрийнхөө угсаа, удмыг ялгаж чадахгүй болсон байна. Энэ хоёр үг хоёулаа хүний уг гарал, залгамж хойч үеийг нь илэрхийлэх утгатай ч угсаа гэдэг нь одоо цагаас /би/ өмнөх үеийг, удам гэдэг нь одоо цаг /би/аас хойш үед хамаарах утгын нарийн ялгаатай юм. Өөрөөр хэлбэл угсаа гэдэг нь “уг язгуур, үндэс сурвалж, гарал” гэсэн утгатай бөгөөд угсаа гарал, үндэс угсаа, угсаа залгах, угсаа тасрах гэх мэтийн холбоо үг үүсгэдэг. Тэгвэл удам гэдэг үг маань “хэн нэгний залгамж хойчис” гэсэн утгатай ба удам сайтай, удам тасрах, удам дамжих, хааны удам, бөхийн удам, хурдан удмын морь гэх мэтийн холбоо үг үүсгэдэг. Удам гэдэг үг маань “залгамж, хойчис” гэсэн утгатай учраас угсаа хэмээх үг шиг “гарал, үндэс, язгуур” гэсэн үгтэй нийлж “удам гарал, удам үндэс, удам язгуур” гэх мэтээр холбоо үг үүсгэхгүй. Харин хоорондоо нийлж “удам угсаа” гэх холбоо үг үүсгэх ба энэ нь хүний өмнөх болон хойт үеийг нийтэд хамруулан хэлсэн утга илэрхийлнэ. Угсаатны бүлэг, угсаатны тархац, угсаатны судлал /угсаатны зүй/ гэх мэтийн шинжлэх ухааны нэр томъёонуудад ч “угсаа” гэдэг үгийг “гарал үүсэл нэгтэй бүлэг хүмүүс” гэсэн утгаар хэрэглэдэг. В.Инжинааш. Хөх судар түүхэн романдаа “Ертөнцийн хүмүүн уг язгуур, удам үндсээ мэдэх нь зүй болой.” хэмээн өгүүлсэн байдаг.Удам гэдэг нэр үгээс удамших гэсэн үйл үг үүсдэг. Удамших гэдэг үгийн утгыг: –1. Бие махбодийн

гадаад төрх, бодосын солилцооны хэвшил, хөгжлийн онцлог үе удамд дамжин давтагдах шинж чанар, 2. Улс үндэстэн ард түмний хэв заншил ёс суртахуун, үзэл санаа хойч үедээ уламлан ирэх гэж Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд тайлбарласан байна. Удамших гэдэг үйл үгээс бас “*удамшил*” гэх нэр үг үүсдэг бөгөөд түүний утгыг уг тайлбар тольд: “*Эцэг эхийн шинж төрх нь үр удамдаа дамжих чанар*” хэмээн маш тодорхой тайлбарлажээ.

Төв Азийн нүүдэлчдийг монгол угсаатан, түрэг угсаатан, манж угсаатан хэмээн ялган хэлэлцэх ба тэдгээр нь дотроо угсаатны бүлгүүдтэй байдаг. Монгол хэлэнд угсаа гарал, гарал угсаа, угсаа залгамжлах гэх ба харин удам гарал, гарал удам, хэмээн хэлэлцдэггүй нь **угсаа, удам** хэмээх үгийн утгын ялгаатай холбоотой бөгөөд шинжлэх ухааны **угсаатны зүй, удам зүй** гэсэн өөр өөр салбарууд байдгийг ч үүнтэй холбон үзэх ёстой.

УРАГ хэмээх үгийг С.Шагжийн тайлбар тольд: аливаа худ ургийн хамаат хүн гэж тайлбарласан бол Хорин нэгтийн тайлбар тольд: 1. аливаа худ ургийн хамаат хүнийг цөм ураг хэмээмүй, Жич эцэг эхийг мөн **төгс ураг** хэмээн хэлэлцмүй гэжээ., Я.Цэвэлийн тайлбар тольд: **Ураг** – 1. Худ худгуйн хамаатан; *ураг төрөл, ураг садан, ураг тогтох* /хөвгүүн охин хоёроо эр эм болгохоор хэлэлцэж тохирох/, *ураг бололцох* /эр эмийг холбож худ худгуй болох/ гэсэн бол, Норжин нарын эрхлэн найруулсан тольд: 3. Гэр бүл болсон эр эмийн харьцаа, 4. Худ бололцсон хоёр айлын харьцаа гэж тайлбарлажээ. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд: 1. Угсаа төрөл; *алтан ураг* /Чингис хааны ургийн хүмүүс/, *ураг төрөл* /мах цусны холбоотой төрөл садан хүмүүс/, *ураг удам* /хүн амьтны уг угсаа/, ураг элгэн /бүх хамаатан садан цөм/, 2. Худ бололцсон хоёр айлын харьцаа; *ураг барилдах, ураг бололцох* /эр эмийг холбож худ худгуй болох/ гэж тус тус тайлбарласан байна. Үүнээс үзвэл **ураг хэмээх үгийн үндсэн утга нь эр эмийг холбож худ худгуйн хамаатай болсныг илэрхийлж байна. Түүнээс гадна Монгол түүхийн зохиолуудад “алтан ураг” хэмээх холбоо үгийг нилээд хэрэглэсэн байдаг. Алтан ураг гэдэг нь зөвхөн тухайн нэр заасан хүний /хааны/ үр удам болохыг заадаг. Жишээлбэл Чингис хааны алтан ургийн хүмүүс гэвэл Хасар тэргүүтэй ах дүүсийн нь үр удмаас зөвхөн Чингис хаан Тэмүүжиний үр хойчсыг ялган нэрлэсэн үг юм. Түүнчлэн Батмөнх даян хааны алтан ураг гэвэл зөвхөн Батмөнх даян хааны л үр удам гэсэн утгатай байдаг.**

САДАН, ТӨРӨЛ гэдэг хоёр үгийн “*садан*” нь Хорин нэгтийн тайлбар толь болон С.Шагжийн тайлбар тольд байхгүй ажээ. Харин “*төрөл*” гэдэг үгийг энэ хоёр тольд “*Нэг овгийн ах дүүг төрөл хэмээмүй*” гэж адилхан тайлбарлажээ. Я.Цэвэлийн тайлбар тольд: **Садан** – хамаатан, төрөл; *садан төрөл, эцгийн садан, холын садан, Төрөл* – 2. Садан; *садан төрөл, төрөл садан, ураг төрөл, цусан төрөл* /эхийн төрөл/, *ясан төрөл* /эцгийн төрөл/, *төрлийн ах* /нэг овгийн ах/, *төрлийн дүү* /нэг овгийн дүү/, хэмээн садан гэдэг үгийг төрөл гэдэг үгээр, төрөл гэдэг үгийг садан гэдэг үгээр тус бүрийг зөрүүлэн тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл хоёр үгийн нэгийг нөгөөгөөр нь солбин тайлбарласнаар хоёр үг хоёулаа тайлбаргүй болжээ. Хорин наймт тайлбар тольд: **Төрөл** – нэгэн өвгөөс үржсэнийг нь төрөл, **Садан** – төрөл ургийн үр хүүхэд бүхнийг аймаг садан хэмээн тайлбарлажээ. Тэгвэл Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд: **Садан** – Хэвтээ чиглэлийн гарлын холбоотой хамаатан хүмүүс; *ойрын садан* /гарлын холбоо ойр хүн/, *холын садан* /гарлын холбоо хол хүн/, *эхийн садан* /цусан

төрлийн холбоотой хүн/, *эцгийн садан* /ясан төрлийн холбоотой хүн/, *амраг садан* /хань болон хамаатан хүмүүс/, *төрөл садан* /яс махны барилдлагатай хүмүүс/, *ураг садан* /а. Цусан төрлийн холбоо бүхий хамаатан хүмүүс, б. Худ ургийн хоорондын холбоо сүлбээ/, *хамаатан садан* /яс, цус, ураг төрлийн харилцаа холбоо/, *элгэн садан* /мах цусны холбоо бүхий төрөл хүмүүс, ойрын төрлийн хамаатан/, **Төрөл** – 1. хүний амьдрах үе, нэгэн нас; 2. Садан; *төрөл хүмүүс* /садан хүмүүс, гарал угсаа нэгтэй хүмүүс/, *цусан төрөл* /эхийн төрөл/, *ясан төрөл* /эцгийн төрөл/, *төрөл садан* /хамаатан садан, мах цусны барилдлага бүхий хүмүүс/, *төрөл төрөгсөд* /хамаатан садан/, *төрөл угсаа* /угсаа гарал, удам судар/, *төрөл удам* /удам угсаа/, *ураг төрөл* /мах цусны холбоотой төрөл садан хүмүүс/, хэмээн тайлбарласан байна. Энд “*төрөл*” гэдэг үгийг шууд садан гэж тайлбарласан байх ба “*садан*” гэдэг үгээ гарал угсаа нэгтэй хүмүүс гэсэн утгаар тайлбарлаж, “*төрөл хүмүүс*” гэдгээ шууд “*садан хүмүүс*” хэмээн тайлбарласнаар энэ хоёр үг хоёулаа тайлбаргүй болсон байна. Бас “*садан*” гэдгийг хэвтээ чиглэлийн гарлын холбоотой хамаатан хүмүүс гэж тайлбарласан нь толь ашиглаж буй хүнд ойлгомжгүй болсон байна. Энэхүү хэдэн мөрийг эвлүүлэн бичиж буй миний бие Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь зохиох ажлыг удирдан ажиллаж байхдаа зохиогчдод хандан утга нь ойролцоо хоёр үгийг нэгийг нөгөөгөөр нь тайлбарлаж болохгүй, тэгвэл хоёр үг хоёулаа тайлбаргүй болдог гээд Цэвэл гуайн тайлбар тольд буй төрөл, садан хэмээх хоёр үгээр жишээ татан ярьж байсныг толийн зохиогч найруулалгүйгээр шууд миний ярьж байснаар үгийн тайлбар болгон бичсэнээс ийм ойлгомжгүй тайлбар гарсан бололтой.

Хүмүүсийн төрөл садны холбоо их нарийн тогтолцоотой байдаг. Тухайлбал “*би*”-ээс дээш эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, элэнц, хуланц; “*би*”-ээс доош хүү, охин, ач, зээ, жич, гуч гэх мэтээр босоо тэнхлэгийн шууд холбоотойг /нэг нь нөгөөгөө төрүүлсэн/ нь төрөл хэмээн нэрлэнэ. Эцгийн талын төрлийг ясан төрөл, эхийн талын төрлийг махан /цусан төрөл гэдэг нь *кровенное родство* гэдгийн үгчилсэн орчуулга/ төрөл гэдэг. Өөрөөр хэлбэл “төрөл” гэдэг нь төрөх, төрүүлэх гэсэн үгтэй язгуур нэгтэй үг юм. Тэгвэл “*би*”-ээс ах, эгч, дүү, үеэлд, хаяалд, бол, бөлөнцөр, авга, нагац, гэх мэтээр хэвтээ тэнхлэг дэх холбоог нь садан хэмээн нэрлэдэг. “*Садан*” гэдэг нь салаа, салах, салбар гэх үгстэй нэг язгууртай юм. Дээрх хоёр үгийн бие биеэсээ ялгарах утгын гол ялгаа нь энэ юм. Энэ ялгааг салган ойлгохгүйгээс “*садан төрөл, төрөл садан*” гэж бүдүүн тоймоор бүрхэгдүүлэн яриад садан гэдэг нь хэн юм, төрөл гэдэг нь хэн юм гэдгээ мэдэхгүй болсон байна. Нэгэнт эдгээр үгийнхээ үндсэн утгыг тогтоож чадаагүйгээс *төрөл садан, ураг садан, хамаатан садан, элгэн садан* гэх зэрэг холбоо үгсийн утгыг ялган нарийн тайлбарлаж чадаагүй байна. Мөн *төрөл садан, төрөл төрөгсөд* гэсэн холбоо үгсийг хоёуланг нь “*хамаатан садан*” гэсэн үгээр тайлбарласан нь оновчтой болж чадсангүй. Ийм жишээ олныг дурдаж болно.

ХАМААТАН гэдэг үгийг Я.Цэвэлийн тольд: **Хамаатан** – садан төрлийн хүмүүс; Норжин нарын найруулсан Монгол хэлний тольд: **Хамаатан** – төрөл садан хэмээн тайлбарласан байна. Тэгвэл 2008 онд хэвлэгдэн гарсан таван боть **Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд**: **Хамаатан** – Садан төрлийн хүмүүс; *холын хамаатан* /өөрийн ах дүүсийн хэн нэгэнтэй дам холбогдох садан төрлийн хүн/, *хамаатан садан* /ураг төрлийн хүмүүс/, *хамаатан сүлбээтэн* /хамаа сүлбээ бүхий хүмүүс/ хэмээн тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл “*хамаатан*” хэмээх үгийг “*садан*

төрлийн хүмүүс” гэж яг адилхан утгаар тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл садан төрлийн хүмүүсээ хамаатан гэж нэрлэдэг хэмээн эдгээр тайлбараас ойлгоно. Тэгвэл “*хамаатан*” гэдэг үгэнд садан, төрөл гэсэн утга байхгүй. Энэ үгийн үндсэн утга нь “*хамаа бүхий хүн*” бөгөөд тухайн хүн /би/ -ий төрөл ч биш, садан ч биш, гэхдээ таны төрлийн хэн нэгэн хүний, эсвэл таны садны, эсвэл таны худ ургийнхны хэн нэгэнтэй хамаа бүхий хүнийг хамаатан гэж хэлдэг ажээ. Хамаатан гэдэг үгийн эсрэг утга нь “*хамаагүй*” билээ. Тийм ч учраас аав ээж, хүү охин, ач зээ зэрэг төрлийн хүмүүсээ, авга нагац, ах эгч, дүү, үеэл хаяал, бөл бөлөнцөр, зэрэг садны хүмүүсээ хамаатан хэмээн нэрлэдэггүй. Хэрэв та өөрийн аав ээж, ах эгч, дүү, хүү охин зэрэг төрөл саднаа “*хамаатан*” хэмээн дуудвал түүнийг доромжилсон хэрэгт унах нь гарцаагүй.

Эцэст нь хэлэхэд, монгол хэлэнд төрөл садан, удам угсаа, уг гарал гэх мэтээр ихэвчлэн хоршин хэрэглэгддэг, ойролцоо утгатай олон арван үгсийн тус бүрийнх нь бие даасан утга бүрхэгдэн бүдгэрч, улмаар хүмүүсийн яриа, тайлбар толь, орчуулгын толь бичгүүдэд ч өөр өөр утгатай хэрэглэгдэж байгаад анхаарлаа хандуулан утга зүйн нарийвчилсан судалгаа хийх шаарлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. *Монголчуудын түүх соёлын атлас*. (2004), 140-р тал Улаанбаатар.,
2. Рашид –Ад-дин. (1952) *Сборник летописей*. Том.1, кн. II, М-Л. 13-р тал.
3. *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Таван боть*. (2008) Улаанбаатар.,
4. Цэвэл. Я. (1966) *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.,
5. Шагж. С. (1998) *Монгол үгийн тайлбар толь*. Монгол улсын Соёлын сан, Дундад улсын үндэстний хэвлэлийн хороо.,
6. *Хорин нэгт тайлбар толь*. (1979), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.,
7. *Монгол- орос дэлгэрэнгүй их толь*. Дөрвөн боть, (2001) Москва.,
8. Голстунский. К.О. (1893-1895) *Монгольско-русский словарь*. Т-I, II, III, С-Петербург.,
9. Ковалевский. О. (1844-1849) *Монгольско-русский-французский словарь*. Том I-III, Казань.,
10. *Хорин наймт тайлбар толь*. (1994) Намжилмаа эмхлэв. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
11. *Монгол хэлний толь*. (1999) Эрхлэн найруулагч Ц.Норжин, Ман Мөрөн, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.,

SUMMARY

In the modern Mongolian language, the words such as *ovog, turul, sadan, ug, ugsaa, udam, urag, khamaatan* are widely used in either the spoken or written language. As of yet, we do not know the concrete meanings and do not clearly distinguish the meanings between these words. *There are serious problems, such as explaining one word by another similar one (For example: Explaining sadun by turul, but turul by sadun) and to explain two different words as same because of the lack of suitable explanations* in Mongolian language dictionaries. In the article, the concrete meanings of these words will be brought to light by the author.